

ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН СЕКТОР
ИРГЭН, ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЗҮЙН СЕКТОР

“ЦАХИМ ХУДАЛДААНЫ ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН
ЗОХИЦУУЛАЛТ” СУДАЛГААНЫ АЖЛЫН ТАЙЛАН



ӨМНӨХ ҮГ

ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газраас судалгааны ажил гүйцэтгүүлэх тухай албан бичгийн хүрээнд тус Хүрээлэнгийн Олон улсын эрх зүйн сектор, Иргэн, эдийн засгийн эрх зүйн сектор хамтран “Цахим худалдааны олон улсын ба үндэсний эрх зүйн зохицуулалт” сэдвийн судалгааны тайланг 2012 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс 6 дугаар сарын 15-ны өдрийг дуустал хийж гүйцэтгэхээр товлож, судалгааны ажлын удирдамж, нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулсан.

Судалгааны багийн удирдагчаар доктор Б.Гүнбилэг, багийн гишүүдэд Олон улсын эрх зүйн секторын эрхлэгч Ж.Соёлмаа, Иргэн, эдийн засгийн эрх зүйн секторын эрхлэгч Б.Тэмүүлэн, эрдэм шинжилгээний ажилтан Б.Энх-Амгалан, Н.Мөнхтуяа, Г.Халиунаа, Б.Наранцацрал, Б.Солонго нар хамтарч ажилласан бөгөөд багийн гүйцэтгэх ажлын календарьчилсан төлөвлөгөөг багийн удирдагчийн баталсан арга зүйн хүрээнд нийцүүлэн боловсруулсны үндсэн дээр уг төлөвлөгөөний дагуу судалгааг гүйцэтгэсэн болно.



ХУРААНГУЙ

Цахим худалдаа нь даяаршлын далайцтай жишээ болж, түргэцтэй хөгжиж байна. Цахим худалдаанд техник, эдийн засаг, нийгэм ба соёлын зэрэг олон талын асуудал холбогдоно. Эдгээр асуудлыг тусгаж, бүхэлд нь авч үзэх, эрх зүйгээр зохицуулах шаардлага гардаг. Тухайлбал, цахим хэлбэрээр хийгдсэн арилжаа хүчинтэй байх асуудал, түүнээс урган гарах хууль зүйн үр дагавар зэрэг чухал ойлголтуудыг дурдаж болно. Цахим арилжааны эрх зүйн бусад асуудал мэдээллийг хамгаалах, татвар төлөх, гаалийн татвар ногдуулах, аюулгүй байдлыг хангах, оюуны өмчийн эрхийг хамгаалах, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, маргаан шийдвэрлэхтэй холбоотой асуудлууд болон интернет үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын хариуцлага, хууль бус үйлдэл болон гэмт хэрэг, интернетийн засаглал, цахим арилжаа явуулах төлбөр тооцооны тогтолцоо зэрэгтэй холбоотой асуудлууд багтана.¹ Тус судалгаагаар эдгээр олон талын асуудлыг бүхэлд нь хөндөлгөөгээр дараах хүрээнд судалсан. Үүнд:

Нэгдүгээрт, “Цахим худалдааны олон улсын эрх зүйн зохицуулалт” сэдвийн хүрээнд олон улсын холбогдох гэрээ, загвар хууль зэрэг эрх зүйн баримт бичгүүдийг хамруулан судалсан. Цахим худалдаатай холбоотой олон улсын эрх зүйн зохицуулалт хэрхэн бий болж хөгжсөн болоод өнөөгийн байдлаар эрх зүйн ямар баримт бичиг, гэрээ, конвенц үйлчилж байгаа талаар авч үзэв. Тухайлбал, Бараа худалдах, худалдан авах олон улсын гэрээний тухай Венийн конвенц, Иргэний болон арилжааны асуудлаарх шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөх тухай Брюсселийн конвенц, Иргэний болон арилжааны хэргийн асуудлаар гадаадын шүүхийн шийдвэр, маргаан шийдвэрлэх шүүхийн харьяаллын тухай Гаагийн конвенц, Маргаан шийдвэрлэх шүүхийг сонгох зөвшилцлийн тухай Гаагийн конвенц, Олон улсын гэрээнд цахим харилцааг ашиглах тухай конвенц болон цахим худалдаанд холбогдох олон улсын загвар хуулийг судалсан нь олон улсын эрх зүйн зохицуулалт, түүний хөгжлийг бүрэн хамруулсан гэж хэлж болно.

Хоёрдугаарт, Цахим худалдааны эрх зүйн онцлог асуудал сэдвийн хүрээнд цахим худалдаатай холбоотой эрх зүйн асуудлын онцлог талыг илрүүлэх, цаашид анхаарах асуудлыг тодорхойлох зорилгоор судалсан. Цахим худалдааны талаарх дэвшилтэт хэмээн тооцогддог зарим тодорхойлолтыг авч үзэхээс гадна цахим худалдааны харилцаанд оролцогчид, уг харилцааны төрөл, ангилал болон бусад эрх зүйн асуудлууд болох мэдээллийг хамгаалах, татвар төлөх, гаалийн татвар ногдуулах, аюулгүй байдлыг хангах, оюуны өмчийн эрхийг хамгаалах, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, маргаан шийдвэрлэхтэй холбоотой асуудлыг цахим худалдааны эрх зүйн онцлог

¹ НҮБХХБ-ын (1999.05.04) “Цахим худалдааны эрх зүйн асуудлууд” сэдэвт TD/B/COM.3/EM.8/2 дугаартай тайланг үзнэ үү.



асуудал болгож тодорхойлсны үндсэн дээр маргаан шийдвэрлэхтэй холбоотой асуудлыг илүү дэлгэрүүлж судлав.

Гуравдугаарт, Цахим худалдааны эрх зүйн хөгжлийн асуудал ба Монгол Улс дахь цахим худалдааны эрх зүйн орчин сэдвийн хүрээнд цахим худалдааны өнөөгийн байдал ба хэтийн хөгжлийн асуудлыг судалж, үр дүнг Монгол Улс дахь цахим худалдааны өнөөгийн байдал, эрх зүйн асуудалтай холбож дүгнэсэн. Олон улсын байгууллагууд, хурал семинараас баталсан зөвлөмж, үр дүн, хөгжингүй болон хөгжиж буй орнууд дахь цахим худалдааны үндэсний хэмжээний ажлын хэсэг болон зөвлөх хороо, тэдгээрийн үүрэг оролцоо, туршлагыг танилцуулахын зэрэгцээ Монгол Улс дахь цахим худалдааны эрх зүйн орчинг судалж, Монгол Улсад хөгжиж эхэлсэн цахим худалдааны “бизнес эрхлэгч-Засгийн газар” буюу B2G, “бизнес эрхлэгч-хэрэглэгч” буюу B2C хэлбэрийн харилцааг тусгайлан авч үзлээ.

Монгол Улсад цахим худалдааны эрх зүйн орчинг бүрдүүлэх хэрэгцээ, шаардлага дээр тулгуурлан Цахим худалдааны салбарт хэрэглэх UNCITRAL-ийн Загвар Хууль, UNCITRAL-ийн болон бусад олон улсын байгууллагын боловсруулсан зөвлөмжийг ашиглах нь зүйтэй хэмээн санал дэвшүүлсэн. Судалгааны тайланд үндэсний түвшинд шийдэгдэх ёстой эрх зүйн зохицуулалтын хүрээг, Монгол Улс дахь эрх зүйн зохицуулалтын асуудалтай холбон судалсан болно.



АГУУЛГА

Өмнөх үг	2
Хураангуй	3
Товчилсон үгийн жагсаалт	5
Удиртгал	6
1. Цахим худалдаанд холбогдох олон улсын эрх зүйн зохицуулалт	
1.1 Цахим худалдааны тухай тодорхойлолт	10
1.2 Цахим худалдаанд оролцогчид, цахим худалдааны төрөл, ангилал	12
1.3. Цахим худалдаанд холбогдох олон улсын гэрээний хөгжил, онцлог	14
А. Бараа худалдах, худалдан авах олон улсын гэрээний тухай Венийн конвенц	14
Б. Иргэний болон арилжааны асуудлаарх шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөх тухай Брюсселийн конвенц	15
В. Иргэний болон арилжааны хэргийн асуудлаар гадаадын шүүхийн шийдвэр, маргаан шийдвэрлэх шүүхийн харьяаллын тухай Гаагийн конвенц	16
Г. Маргаан шийдвэрлэх шүүхийг сонгох зөвшилцлийн тухай Гаагийн конвенц	18
Д. Олон улсын гэрээнд цахим харилцааг ашиглах тухай конвенц	18
1.4. Цахим худалдаанд холбогдох олон улсын загвар хууль, түүний үндсэн үзэл баримтлал	20
2. Цахим худалдаа дахь эрх зүйн онцлог асуудал	
2.1. Цахим худалдааны эрх зүйн нийтлэг асуудал	25
2.2. Холбогдох хууль тогтоомж ба маргаан шийдвэрлэх үйл явц	31
3. Цахим худалдааг үндэсний эрх зүйгээр зохицуулсан байдал	
3.1. Хөгжингүй орнуудад цахим худалдаа зохицуулах туршлага, жишээ	36
3.2. Хөгжиж буй орнуудад цахим худалдаа зохицуулах туршлага, жишээ	38
3.3. Үндэсний түвшинд шийдэгдэх ёстой эрх зүйн зохицуулалтын хүрээ	45
3.4. Цахим худалдаатай холбоотой Монгол Улсын эрх зүйн зохицуулалт	48
НЭГДСЭН ДҮГНЭЛТ	59
Хавсралт 1. Цахим худалдааны тухай НҮБ-ын Загвар хууль /албан бус орчуулга/	62
Хавсралт 2. Цахим худалдаанд холбогдох Монгол Улсын нэгдэн орсон олон улсын эрх зүйн баримт бичиг	74
Ашигласан эх сурвалж	78



ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ОУЭЗС	- Олон улсын эрх зүйн сектор
ИЭЗЭЗС	- Иргэн, эдийн засгийн эрх зүйн сектор
Б-Х	- Бизнесийн байгууллага болон хэрэглэгчийн хоорондох харилцаа
Б-Б	- Бизнесийн байгууллага болон бизнесийн байгууллагын харилцаа
Б-ЗГ	- Бизнесийн байгууллага болон засгийн газар хоорондын харилцаа
B2G	- Business to Government
B2B	- Business to Business
B2C	- Business to Consumer
C2C	- Consumer to Consumer
EEC	- Европын эдийн засгийн холбоо
OECD	- Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага
UNCITRAL	- НҮБ-ын Олон улсын худалдааны эрх зүйн хороо
WIPO	- Дэлхийн оюуны өмчийн байгууллага



УДИРТГАЛ

Нэг. Зорилго

Энэхүү судалгааны ажлын зорилго нь цахим худалдааны олон улсын эрх зүйн зохицуулалтыг судалж, цахим худалдааны харилцаанд жишиг болохуйц холбогдох эрх зүйн онцлогийг илрүүлэх замаар цахим худалдааны дотоодын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох арга замыг тодорхойлоход оршино.

Хоёр. Зорилт

Судалгааны ажил дараах зорилттой. Үүнд:

1. Цахим худалдааны олон улсын эрх зүйн нийтлэг зохицуулалтыг судлах тухайд
 - Цахим худалдаанд холбогдох олон улсын гэрээний хөгжил, онцлог зохицуулалтын талаар тоймлон судлах
 - Цахим худалдаанд холбогдох олон улсын загвар хууль, түүний үндсэн үзэл баримтлалыг тодорхойлох
2. Цахим худалдааны эрх зүйн харилцааны онцлог асуудлыг тодорхойлох тухайд
 - Цахим худалдааны ангилал, төрлийг судлах
 - Цахим гарын үсгийн хэрэглээ
 - Цахим худалдаатай холбоотой үүссэн маргаан шийдвэрлэх аргууд
3. Цахим худалдааны дотоодын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох арга замыг тодорхойлох тухайд
 - Монгол Улсын цахим худалдаатай холбоотой эрх зүйн зохицуулалт, тулгамдсан асуудлыг тодруулах
 - Цахим худалдаатай холбоотой маргааныг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх эсэх, маргааны харьяалал тодорхойлох
 - Цахим худалдааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох талаар санал, дүгнэлт бэлтгэх

Судалгааны ажлын хүрээнд цахим худалдаатай холбоотой эрх зүйн зохицуулалт гэдэгт юуг ойлгох вэ, Монгол Улсад цахим худалдааны эрх зүйн орчин бүрэлдсэн үү, цахим худалдааны загвар хуулийг Монгол Улс батлах уу гэсэн асуултууд тавьж оновчтой зөв хариулт олохын тулд харьцуулан дүн шинжилгээ хийх арга ашиглалаа.



Гурав. Сэдвийн судлагдсан байдал

Цахим худалдаа, түүний эрх зүйн зохицуулалтын асуудлаар мэргэшин судалдаг эрдэмтэд, судлаачид олон улсын хэмжээнд цөөнгүй бий бөгөөд энэ сэдвээр нэг сэдэвт бүтээл нэлээдгүй хэвлэгдэн гарсан байдаг. Үүнээс доктор Файя Вангийн² бичсэн ном товхимолууд, тэр дундаа “Интернэтийн харьяаллын асуудал болон зөрчилдөөний хэм хэмжээ: АНУ, Европ болон БНХАУ-ын хууль зүйн туршлагын харьцуулалт” хэмээх ном хамгийн сайн бүтээлд тооцогддог байна.

Түүнчлэн Лорна Е. Гиллиесийн “Цахим худалдаа ба олон улсын хувийн эрх зүй, хэрэглэгчийн гэрээтэй холбоотой асуудал”³ бүтээл, профессор Майкл Гейстийн “Тэнд энд гэсэн ухагдахууны тухайд”⁴ гэх зэрэг бүтээлүүд, сурах бичиг болон олон нийтээр хэрэглэж болох интернэтэд суурилсан материалууд⁵ бий. Товчхондоо интернэт, түүний эрх зүйн орчны талаарх ном сурах бичигтэй харьцуулахад цахим худалдаа, түүний эрх зүйн зохицуулалтын асуудал чамгүй судлагдсан сэдэв болжээ. Харамсалтай нь Монгол Улсын хувьд Л.Галбаатар “Цахим эрх зүй” бүтээл болон хэд хэдэн магистрын ажлуудаас өөр цахим худалдааны эрх зүйн асуудалд холбогдох судалгаа хийгдээгүй байна.

Дөрөв. Судалгааны хүрээнд хийсэн ажил

д/д	Хийсэн ажил	Хариуцсан нэгж
I. Бэлтгэл үе шат /2012.02.01- 02.15/:		
1.1.	Судалгааны ажлын удирдамжийг боловсруулж, ХЗҮХ-ийн Эрдэмтэн нарийн бичгийн даргаар батлуулав.	ОУЭЗС
1.2.	Судалгааны ажлын нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулан Эрдэмтэн нарийн бичгийн даргаар батлуулж, судлах ажлын хүрээг тодорхойлон чиглэл авч, ажлын хуваарилалт хийв.	ОУЭЗС

²Дэлгэрэнгүй мэдээллийг http://www.cippm.org.uk/people/people_detail.php?ID=379 – оос үзэж танилцана уу. Сүүлд нэвтэрсэн огноо – 2012.06.07

³LORNA E. GILLIES, ELECTRONIC COMMERCE AND INTERNATIONAL PRIVATE LAW-A STUDY OF ELECTRONIC CONSUMER CONTRACTS.

⁴Professor Michael Geist' Is There a There There? <http://aix1.uottawa.ca/~geist/geistjurisdiction-us.pdf> -оог дэлгэрэнгүй танилцана уу. Сүүлд нэвтэрсэн огноо – 2012.06.07

⁵<http://gsbwww.uchicago.edu>, <http://www.altern.org/defense/euroloi.html>, <http://www.thestandard.net/articles/display/0,1449,3716,00.html>, <http://ebusiness.org/Public/Fil/1911.html>, <http://www.defaite-internet.org>, http://www.generation.net/pchantel/commerce_02.html, <http://www.internet.gouv.fr/francais/textesref/rapce98/rap4.htm>, <http://www.iris.sgdq.org/les-iris/li4.html>, <http://www.nytimes.com/library/tech/reference/indexcommerce.html>, http://www.oecd.org/subject/e_commerce/summary.htm, <http://www.pub.utdallas.edu/~liebowit/palgrave/network.html>.



II. Мэдээлэл цуглуулах, судлах үе шат /2012.02.15- 05.01/:		
2.1.	Олон улсын болон дотоодын эрх зүйн эх сурвалжуудийг тодорхойлж, цуглуулан судлав.	ОУЭЗС ИЭЗЭЗС
2.2.	Олон улсын эрх зүйн ба Монгол Улсын эрх зүйн холбогдох зохицуулалтыг тоймлон гаргасны үндсэн дээр судалгааны ажлын зорилго, зорилтын хүрээнд нийтлэг ба онцлог талыг судалж тодорхойлов.	ОУЭЗС ИЭЗЭЗС
III. Судалгааны дүнг нэгтгэн гаргах /2012.05.01-06.15/:		
3.1.	Эх сурвалжийн судалгааг нэгтгэж, дүгнэлт өгөн, санал боловсруулав. Үүнд олон улсын эрх зүйн зохицуулалтын талаар ОУЭЗС хариуцан судалж дүгнэлт, зөвлөмж боловсруулан тайлан бичив. Монгол Улсын эрх зүйн зохицуулалтын талаар ИЭЗЭЗС судалж, боловсронгуй болгох арга замын тухайд санал боловсруулж тайлан гаргав.	ОУЭЗС ИЭЗЭЗС
3.2.	Судалгааны тайлан бэлтгэж, судалгааны багийн удирдагчаар хянуулан, холбогдох нэмэлт, өөрчлөлтийг оруулан боловсронгуй болгов.	ОУЭЗС ИЭЗЭЗС
3.3.	Судалгааны тайланг холбогдох байгууллагуудад хүргүүлэв.	ОУЭЗС ИЭЗЭЗС
3.4.	Судалгааны тайлангийн үр дүнг олон нийтэд сурталчлан таниулах зорилгоор эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлүүлж, эрдэмтэн судлаачдын дэвшилтэт бүтээлийг орчуулж хэвлүүлэв.	ОУЭЗС
3.5.	Судалгааны үр дүнг олон нийтээр хэлэлцүүлэх зорилгоор МУИС-ийн Олон улсын харилцааны сургууль, Үндэсний Тагнуулын Академи, ХЗҮХ-ээс зохион байгуулагдах “Монгол Улс дахь олон улсын эрх зүйн хөгжлийн чиг хандлага” сэдэвт эрдэм шинжилгээний бага хуралд сэдвийн хүрээнд илтгэл бэлтгэж, хэлэлцүүлэхэд бэлэн болсон байна.	ОУЭЗС

Тав. Судалгаа явуулахад баримталсан зарчим



Судалгааг шинжлэх ухааны арга зүйг баримтлан дэвшүүлсэн санал, дүгнэлт нь тухайн судалгаагаар тогтоогдсон үр дүнд үндэслэн бодитойгоор гаргаж, саналаа онолын үндэслэлтэй боловсруулах зарчимд тулгуурласан.

Зургаа. Судалгааны арга

- ✓ Баримт бичгийн судалгааны арга;
- ✓ Задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх арга;
- ✓ Харьцуулалтын арга;
- ✓ Хууль зүйн техник, хууль тайлбарлах аргуудыг тус тус хэрэглэнэ.

Долоо. Судалгаанд хамрагдсан хүрээ, хязгаар

Судалгааг цахим худалдаанд холбогдох олон улсын эрх зүйн эх сурвалжууд, жишиг зохицуулалттай гадаад улсуудын эрх зүйн онцлог орчин, Монгол Улсын хууль, холбогдох онол арга зүй болон туршлагад тулгуурлалаа.



НЭГ. ЦАХИМ ХУДАЛДААНД ХОЛБОГДОХ ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Олон улсын эрх зүйд гэрээнээс үүсэлтэй харилцаа мөн эсэхээс үл хамааран худалдаа арилжааны мөн чанартай ямар ч харилцаанаас үүссэн асуудлуудад “худалдааны (commercial)” гэсэн нэр томъёог өргөн утгаар хэрэглэх болжээ. Худалдаа арилжааны мөн чанартай харилцаа гэдэг нь аливаа бараа үйлчилгээг хангах, солилцох хэлцэл, агентын буюу худалдааны зуучлал, факторинг, лизинг буюу санхүүгийн түрээс, банкны холбогдолтой хэлцлүүд, барилгын ажил гүйцэтгэх хэлцэл, зөвлөх үйлчилгээний хэлцэл, инженерийн төрлийн хэлцэл, тусгай зөвшөөрөлтэй холбоотой хэлцэл, хөрөнгө оруулалтын хэлцэл, санхүүгийн болон даатгалын хэлцэл, концесс болон олборлолтын хэлцэл, хамтарсан үйлдвэр болон үйлдвэрлэл эсвэл бизнесийн хамтын ажиллагааны хэлцэл, агаараар, далайгаар, төмөр зам болон газраар зорчигч болон бараа тээвэрлэлт зэрэг хэлцлүүдийг агуулах⁶ боловч зөвхөн эдгээр хэлцлүүдээр хязгаарлагдахгүй. Энэ хэсэгт цахим худалдааны талаарх нэлээд дэвшилттэй хэмээн тооцогддог зарим тодорхойлолтыг авч үзэхээс гадна цахим худалдааны харилцаанд оролцогчид, уг харилцааны төрөл, ангилал болон интернэтээр дамжуулж гэрээ байгуулах, мэдээлэл солилцох тухай хууль, цахим үйлчилгээ, цахим худалдааг зохицуулж буй олон улсын конвенцууд, олон улсын хурлын үр дүн, олон улсын байгууллагын зүгээс гаргасан хүчин чармайлт зэргийг энэ бүлэгт авч үзнэ.

1.1 Цахим худалдааны тухай тодорхойлолт

“Цахим худалдаа гэдэг нь ерөнхийдөө текст, дуу, дүрс зэрэг цахим өгөгдлийг боловсруулж дамжуулах ажиллагаан дээр үндэслэсэн байгууллага, хувь хүмүүс хоорондын бизнесийн арилжааны бүх хэлбэрийг хэлнэ” гэж Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага⁷ тодорхойлсон байхад Европын Мэдээллийн технологийн шинжлэх ухааны хүрээлэнгээс “Цахим худалдаа нь цахилгаан холбоо харилцааны сүлжээг ашиглан өртөг шилжүүлэх бизнесийн үйл ажиллагаа явуулах талбар юм⁸ гэж тодорхойлжээ.

Түүнчлэн “Цахим худалдаа гэдэг нь бизнесийг цахим хэлбэрээр явуулахыг хэлнэ. Энэ нь текст, дуу, дүрс зэрэг өгөгдлийг цахим аргаар боловсруулж дамжуулах ажиллагаанд суурилна. Бараа, үйлчилгээний цахим арилжаа, цахим мэдээллийг интернетээр дамжуулах, мөнгөний цахим гүйлгээ, шилжүүлэг, хувьцааны цахим арилжаа, цахим тээвэр, ачилтын баримт, бизнес хэлбэрийн дуудлага худалдаа, инженерийн зураг төсөл хамтарч боловсруулах,

⁶UNCITRAL Model Law on Electronic Commerce, <http://www.uncitral.org>, Цахим худалдааны тухай загвар хуулийн тодорхойлолтоос авав. Монгол хэлээр Хавсралт 1-ээс үзнэ үү.

⁷Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага, 1997

⁸Европын Мэдээллийн технологийн шинжлэх ухааны хүрээлэн, 1997



интернетээр бараа, түүхий эдийн захиалга өгөх, Засгийн газрын худалдан авах ажиллагаа, шууд хэрэглэгчид хандсан маркетинг, борлуулалтын дараа засвар, үйлчилгээ зэрэг олон төрлийн үйл ажиллагааг мөн энд хамруулна. Цахим худалдаанд бараа (хэрэглээний бараа, эмнэлгийн мэргэжлийн тоног төхөөрөмж), үйлчилгээ (мэдээллээр хангах үйлчилгээ, санхүүгийн болон хууль, эрх зүйн зөвлөгөө, үйлчилгээ), уламжлалт үйлчилгээ (эрүүлийг хамгаалах, боловсрол) болон шинэ үйлчилгээ (интернет орчны дэлгүүр) зэргийг багтаана” хэмээн Европын Комисс үзжээ.⁹ Харин АНУ-ын Ерөнхийлөгчийн Захиргааны албанаас “Интернет нь иргэдийн эрх, оролцоог нэмэгдүүлж, нийгмийн ардчиллыг бэхжүүлэхээс гадна эдийн засгийн уламжлалт загваруудыг хүртэл өөрчлөхөд хүргэж байна. Бизнес эрхлэгчид, хэрэглэгчид цахим зах зээлд оролцон түүнээсээ ашиг олохын хэрээр арилжаа, наймааны шинэ шинэ төрөл хэлбэр төрөн гарч ирж байна. Дэлхийн дахины мэдээллийн дэд бүтэц нь зардлыг дорвитойгоор бууруулж, бизнесийн шинэ төрлийн арилжааг хөнгөвчилж байгаагаараа дээрх болон бусад салбарын бизнес, арилжаанд эргэлт гаргах бололцоотой. Интернет нь жижиглэнгийн худалдааны зах зээлд ч эргэлт гаргах юм. Ирэх зууны босгон дээр интернетээр хийх худалдаа, арилжааны нийт эргэлт хэдэн арван тэрбум долларт хүрэх бололцоотой”¹⁰ хэмээн дурьджээ.

Японы Олон улсын худалдаа, аж үйлдвэрийн яамны зүгээс цахим худалдааг тодорхойлохдоо “Өмнө нь зөвхөн тусгайлсан хэдэн компаниар хязгаарлагддаг байсан цахим худалдаа нь эдүгээ шинэ эринд шилжих болж жирийн хэрэглэгч хүртэл интернет дээр ажиллах боллоо. Үүний дээр захиалга өгөх, хүлээж авах зэрэг энгийн өгөгдөл дамжуулах үйлдэл хийхээс гадна бизнест өргөн хэрэглэгддэг бусад үйл ажиллагаа болох олон нийттэй харилцах, сурталчилгаа явуулах, хэлэлцээ хийх, гэрээ байгуулах, төлбөр тооцоо гүйцэтгэх зэрэг ажиллагааг хамрах болжээ”¹¹ гэсэн бол Transatlantic Business Dialogue сэтгүүлийн Цахим худалдааны тухай тайланд¹² “Цахим худалдаа гэдэг нь хялбараар тодорхойлоход үйлчилгээг цахим аргаар арилжаалах хэлбэр юм” гэсэн байх юм.

Дээрх тодорхойлолтуудаас харахад цахим худалдаа гэсэн томъёоллын дор зөвхөн иргэний эрх зүйн хүрээнд ойлгогддог худалдаа арилжаа бус интернэт ашиглан гүйцэтгэж буй бизнесийн болон захиргааны ажил хэргийн бүхий л харилцааг хамтатган ойлгож болохоор өргөн агуулга бүхий ойлголт юм байна. Иймд интернэт ашиглан хийгдэж буй ажил хэргийн энэ харилцааны оролцогч субъект нь хэн байх, уг харилцааг хэрхэн ангилж, төрөлжүүлдэг талаар дор дурьдана.

⁹Европын Комисс, 1997 он

¹⁰АНУ-ын Ерөнхийлөгчийн Захиргааны алба, 1997 он

¹¹Японы Олон улсын худалдаа, аж үйлдвэрийн яам, 1996 он

¹²Transatlantic Business Dialogue - <http://www.tabd.com/> сүүлд нэвтэрсэн огноо – 2012.02.10




1.2 Цахим худалдаанд оролцогчид, цахим худалдааны төрөл, ангилал

Цахим худалдаанд хоёр буюу түүнээс дээш оролцогч байдаг боловч тэдгээр нь өөр хоорондоо харилцан адилгүй шинж чанартай байж болдог. Цахим худалдааны харилцаанд орох үндсэн гурван төрлийн этгээд байна. Үүнд, хувь хүн, хуулийн этгээд болон Засгийн газар багтдаг.

Цахим худалдаа үүссэн хөгжлийн эхний үед голдуу хуулийн этгээд, тэр дундаа компани болон хувь хүмүүсийн хооронд интернэт ашигласан харилцаа үүсч байсан (Amazon.com зэрэг худалдаа) бөгөөд үүнийг “бизнес-хэрэглэгч” (“Б-Х”) хэлбэрийн худалдаа гэдэг. Хэвлэл мэдээллээр төдийлөн гардаггүй компани, аж ахуйн нэгжүүдийн хооронд явагддаг байсан арилжаа жишээлбэл, үйлдвэрлэгч болон тэдгээрийн дэд гэрээлэгч хоорондын, эсвэл бизнесийн үйл ажиллагаанд зориулсан тоног төхөөрөмж үйлдвэрлэгч болон тэдгээрийн үйлчлүүлэгчдийн хоорондын гэх мэт буюу “Cisco” төрлийг “бизнес-бизнес” (“Б-Б”) гэнэ. Үүнээс гадна, ялангуяа хөгжиж буй орнуудын хувьд цахим худалдааг нэг талаас Засгийн газар, төрийн байгууллагууд, нөгөө талаас хувийн хэвшлийн хооронд Засгийн газрын худалдан авах ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор явуулж болдог. Үүнийг “бизнес-Засгийн газар” буюу “Б-ЗГ” гэж нэрлэнэ. Дараах Зураг 1-д

Зураг 1. “Эвтэй гурван амьтан”





Нэг өнцгөөс харахад, “Б-Х” хэлбэрийн худалдаа Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын гишүүн орнууд, тэр дундаа үндсэндээ АНУ-д түлхүү хөгжсөнөөрөө сүүлийн жилүүдэд анхаарал татах болсон. Гэхдээ “Б-Б” хэлбэрийн худалдаа, ялангуяа олон улсын худалдааны хувьд харахад цахим худалдааны ойрын ирээдүйд өргөжин хөгжих талбар болох нь тодорхой байна. Тиймээс ч хөгжиж буй орнууд энэ хэлбэрийн худалдааг тэргүүлэх чиглэлд авч үзэн эдүгээ эхлэлээ тавьж буй мэдээлэлд суурилсан дэлхийн эдийн засгийн тогтолцоонд нэгдэн орох нэгэн арга хэрэгсэл болгож ашиглах нь зүйтэй. Цахим худалдааны гурав дахь төрөл болох бизнес-Засгийн газар (Б-ЗГ) төрлийн худалдаа хөгжиж буй орнуудын хувьд худалдааны үр ашгийг дээшлүүлэх, туршлага хуримтлуулах гол хөдөлгөгч болох нь дамжиггүй. Засгийн газрын байгууллагууд цахим худалдаанд шууд оролцсоноороо өөрийн үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх (жишээлэхэд, Засгийн газрын худалдан авах ажиллагааны салбарт), мөн цахим худалдааны арга, ажиллагаа, асуудлын талаар туршлага, мэдлэгээ сайжруулах боломжтой юм. Ингэхийн хажуугаар төр, хувийн хэвшлийн хоорондын хамтын ажиллагаа, харилцан ойлголцлыг бэхжүүлэх бололцоотой.

Өнөөгийн байдлаар цахим худалдааны дараах хэлбэрүүд байна. Үүнд :

1. Засгийн газар - Бизнесийн байгууллага/B2G/
2. Бизнесийн байгууллага – Бизнесийн байгууллага (Microsoft) /B2B/
3. Бизнесийн байгууллага – Хэрэглэгч (Amazon), (ebay)/B2C/
4. Хэрэглэгч - Хэрэглэгч (www.classified2000.com) /C2C/
5. Бизнесийн бус (их дээд сургууль, төрийн байгууллага)

Цахим худалдааны дээрх үндсэн хэлбэрүүд нь тухайн харилцаанд аль оролцогчоос аль оролцогч руу чиглэсэн байгаагаасаа хамааран дотроо маш олон төрөл болж задардаг байна. Учир нь харилцаа холбооны дэвшилтэт технологиудыг ашиглан интернэт орох бололцоо улам бүр нэмэгдэж байгаа тул цахим худалдааны төрөл улам олон төрөлтэй болж байгаа нь тодорхой. Тухайлбал: business to consumer буюу бизнесийн байгууллагаболон хэрэглэгчийн харилцааг дотор нь 1/ Бизнес эрхлэгчээс хэрэглэгчид чиглэсэн, 2/Хэрэглэгчээсбизнес эрхлэгчид чиглэсэн цахим худалдаа гэж ангилах болжээ. Мөн түүнчлэн хүмүүс компьютерийн файл ба эх сурвалжтай холбоотой зүйлсийг төв вэб сэрвэргүйгээр хоорондоо солилцон наймаалцах Peer to peer /P2P/ худалдаа, эсвэл ухаалаг гар утас гэх мэт хөдөлгөөнт хэрэгслүүдийг ашиглан худалдаа хийх /M-commerce/ гэх цахим худалдааны шинэ төрлийг нэрлэж болно. Цаашид энэхүү төрөл зүйлийн ангиллыг ашиглан олон улсын хэмжээнд цахим худалдааны бодлогыг тодорхойлох, хэрэгжүүлэх стратеги, үйл ажиллагааны үндэс суурь болгосон¹³ байна.

¹³Э.Мягмардорж, “Интернэтийн орчин дахь, зохиогчийн эрхийн эрх зүйн зохицуулалт”, “Интернэтийн орчин дахь контент, зохиогчийн эрхийн зохицуулалтын асуудал” семинар, 2012. 02.15



Нэгэнт интернэтийн хил хязгааргүй хэрэглээ нь нэг улс, үндэстний түвшинд цахим худалдааны бодлогыг дангаар тодорхойлох боломжгүй болгосон тул эрх зүйн зохицуулалтын хувьд улс орон бүр тус тусдаа өөр өөрийнхөөрөө хандах нь цахим худалдааны хөгжилд сөргөөр нөлөөлдөг гэдэг нь хүлээн зөвшөөрөгдсөн билээ.

Дараагийн хэсэгт цахим худалдаатай холбоотой олон улсын эрх зүйн зохицуулалтууд хэрхэн бий болж хөгжсөн, өнөөгийн байдлаар эрх зүйн ямар ямар баримт бичиг, гэрээ, конвенцууд батлагдан үйлчилж байгаа талаар авч үзнэ.

1.3. Цахим худалдаанд холбогдох олон улсын гэрээний хөгжил, онцлог

Олон улсын загвар хууль тогтоомж, стандартыг бэлтгэх нь улс орны хэмжээнд дотоодын хууль тогтоомж бэлтгэхэд удирдамж болох бөгөөд энэ нь цахим худалдааг хөнгөвчилөхөд тустай. Олон тооны байгууллагууд, тэр дундаа Европын Эдийн засгийн Холбоо (ECE), Олон улсын Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD), НҮБ-ын Олон улсын Худалдааны эрх зүйн Хороо (UNCITRAL), Дэлхийн Оюуны Өмчийн Байгууллага (WIPO), Европын Байгууллагуудын Хороо нь цахим худалдааны талаархи загвар хуулиуд боловсруулах, олон улсын гэрээ хэлэлцээрийг хийх, удирдамжийг гаргахад идэвхтэй оролцож байна. Эдгээрээс ДОӨБ-ын Зохиогчийн эрхийн гэрээнүүд 1996, НҮБ-ийн Олон улсын худалдааны эрх зүйн хорооны Цахим худалдааны талаарх Загвар хууль 1996, Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Байгууллагын Нууцлалын бодлогын удирдамж 1997, НҮБ-ийн Ерөнхий Ассамблейгаас баталсан Олон улсын гэрээнд цахим харилцааг ашиглах тухай 2005 оны конвенц зэрэг олон улсын эрх зүйн баримт бичгүүд багтана. Дараах дэд хэсгүүдэд олон улсын байгууллагуудаас баталсан загвар хууль тогтоомж, гэрээний заалтуудыг авч үзэх болно.

Хавсралт 2-т Монгол Улсын нэгдэн орсон цахим худалдаанд хамаарах олон улсын гэрээ, конвенциудын жагсаалтыг орууллаа. Үүнээс энэхүү судалгаанд ач холбогдол ихтэй, цахим худалдаанд шууд хамаарах дараах конвенциудын талаар товч авч үзье.

А. БАРАА ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ОЛОН УЛСЫН ГЭРЭЭНИЙ ТУХАЙ ВЕНИЙН КОНВЕНЦ

“Бараа худалдах, худалдан авах олон улсын гэрээний тухай конвенц”-ийг 1980 онд Вена хотноо баталсан бөгөөд 1988 оны 1 дүгээр сарын 1-нээс хүчин төгөлдөр болсон. Конвенц нь дэлхийн олон улс оронд хүлээн зөвшөөрөгдөж ихэд дэлгэрсэн бөгөөд эх газрын болон англи саксоны эрх зүйн бүлийннийтлэг, зөвшилцөх шинжийг илэрхийлж чадсанаараа эрх зүйн онол, үзэл баримтлалын чухал ач холбогдолтой болсон билээ. Конвенцийн гол онцлог нь худалдааны байгууллагууд нь өөр өөр улс оронд оршиж байгаа талуудын хоорондох



худалдах, худалдан авах гэрээнд хамаарна. Энэ конвенц нь бараа худалдах, худалдан авах болон энэхүү гэрээгээр худалдагч, худалдан авагч нарын хүлээх эрх үүргийг зохицуулдаг. Өөрөөр хэлбэл, энэ баримт бичиг бол цахим худалдаанд оролцогчид гэрээ байгуулах, уг гэрээний дагуу үүсэх эрх үүргийг зохицуулж буй материаллаг эрх зүйн хэм хэмжээ юм. Бүтцийн хувьд тус конвенц нь бараа худалдах, худалдан авах олон улсын гэрээ байгуулах, гэрээг биелүүлэх ба биелүүлээгүйгээс үүсэх хариуцлагын талаарх зохицуулалтыг агуулна. Худалдагчийн үүрэг, худалдан авагчийн үүрэг, эрсдэл шилжих, худалдагч болон худалдан авагчийн нийтлэг зүйлс гэсэн бүлгүүдтэй.

Тус конвенцийн 96 дугаар зүйлд уг конвенцид нэгдэн орж буй улсын хууль тогтоомжоор бараа худалдах, худалдан авах гэрээг заавал бичгээр байгуулах шаардлагатай бол энэ конвенцийн 12 дугаар зүйлийн дагуу бараа худалдах, худалдан авах гэрээ, түүнийг өрчлөх буюу цуцлахад талууд хүсэл зоригоо бичгээр төдийгүй ямар ч хэлбэрээр зөвшилцөж болохыг зөвшөөрсөн. Өөрөөр хэлбэл харилцаа холбооны дэвшилтэт технологи ашиглан цаг хугацаа, зардал хэмнэн цахим хэлбэрээр гэрээ байгуулах хүсэл зоригоо илэрхийлэх нь худалдагч, худалдан авагчийн хувьд нээлттэй юм.

Монгол Улсын хувьд энэхүү конвенцид нэгдэн орох тухай хуулийг 1997 оны 7 дугаар сарын 9-нд баталсан. Тус конвенцид нэгдэн орохдоо 96 дугаар зүйлийн дагуу зөвхөн гэрээний бичгийн хэлбэрийг зөвшөөрч буй тайлбар хийсэн.

Б. ИРГЭНИЙ БОЛОН АРИЛЖААНЫ АСУУДЛААРХ ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ ТУХАЙ БРЮССЕЛИЙН КОНВЕНЦ

Иргэний болон арилжааны асуудлаарх шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөх тухай Брюсселийн 1968 оны Конвенц¹⁴ нь бүс нутгийн хүрээнд үйлчилдэг. Тухайн цахим хэлэлцээрт нэг тал болж буй хэрэглэгчийг эрх зүйн хувьд сул тал гэж үзэн түүний эрх ашгийг хамгаалахыг урьтал болгосон. Европын холбооны хувьд В2С цахим худалдааны эрх зүйн зохицуулалтыг Брусселийн Конвенцоор зохицуулж эхэлсэн. Цаг хугацааны хувьд энэхүү үе нь Европын бүс нутагт улс орны хууль тогтоомжийг харилцан уялдуулах, хооронд нь нийцүүлэх ажил идэвхитэй хийгдэж байсан үетэй холбоотой. Тодруулбал уг Конвенцийн 13 дугаар зүйлд хэрэглэгчтэй хийсэн гэрээний талаар маргаан гарвал харьяаллын асуудлыг хэрхэн шийдвэрлэхийг заасан. Технологийн шинэ шинэ боломж нээгдэн хөгжил хурдассан, хэрэглэгчийн эрхийг хамгаалах шинэ механизм бий болсны улмаас уг конвенцид хэд хэдэн удаа нэмэлт өөрчлөлт оруулж байсан. Тухайлбал, 1978 онд дээр дурьдсан 13 дугаар зүйлийн 4 дэх хэсэгтэй холбоотой нэмэлт өөрчлөлт орсон. Интернэт бий болон түүнийг

¹⁴Brussels Convention on jurisdiction and Recognition of Judgments in Civil and Commercial Matters, J.O. L 299/32 (1972), amended by O.J. L 304/77 (1978), amended by O.J. L 388/1 (1982), amended by O.J. L 285/1 (1989)



хэрэглэн худалдаа арилжаа хийж эхэлсэн нь В2С цахим худалдааны гэрээнээс үүдэлтэй маргаан, түүнийг аль улсад, аль шүүхэд шийдвэрлэх асуудлаар улс орнууд ярилцаж эхэлсэн¹⁵. Учир нь интернэтийн туслалцаатай арилжаа хийгдэж байхад “I Agree” гэсэн товчлуурыг дарахаас гарцаагүй байдалд ордог нь хэрэглэгчийн хэлэлцээр хийх боломжийг хязгаарладаг. Интернэтийн туслалцаатай хийж буй цахим худалдааны асуудлыг Брусселлийн Конвенц дангаар зохицуулахад хангалтгүй байсан тул Европын холбооны гишүүн улсууд дотоодын хууль тогтоомжоо уялдуулах үүднээс шинэ эрэл хайгуул хийж эхэлсэн. Үүний үр дүнд 2000 онд Луганогийн Конвенцийг баталснаар, Брусселлийн Конвенцтой хамтатган хэрэглэх болсон. Үүнийг Бруссель I Журам гэж нэрлэдэг. Европын нутаг дэвсгэрт цахим худалдааг өргөжүүлэх үүднээс Брусселлийн Конвенцийн 13 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан хэрэглэгчтэй байгуулсан гэрээ гэдгийг тодруулан 15 дугаар зүйлдээ тодорхойлолт оруулсан. Уг тодорхойлолтод “тухайн хэрэглэгчийн ажил мэргэжил, худалдаанаас гадуур хийгдэх зорилготойгоор аливаа этгээдийн байгуулж буй гэрээг хэрэглэгчийн гэрээ гэнэ” гэжээ. Ийнхүү тодорхойлж өгсөн нь Европын шүүхэд энэ төрлийн маргаан гарахад хэрэлэгч гэж хэнийг хэлэх вэ гэдгийг ойлгоход дөхөм үзүүлсэн. Учир нь онлайн худалдааны харилцаанд оролцож буй хэрэглэгч нь гэрээ байгуулж буй нөгөө талынхаа хувьд “сул, дорой” тал байдаг тул эрх зүйн хамгаалалтад орох шаардлагатай байсан. Эдийн засгийн утгаар нь ойлговол цахим худалдааны үед хийгдэж буй гэрээний гол онцлог нь эдийн засгийн хувьд тэнцвэргүй гэрээ байдаг бөгөөд нэг тал нь нөгөө талаасаа чөлөөт байдлыг сул эдэлдэг. Өөрөөр хэлбэл, талуудын тэгш байдлын зарчим хөндөгддөг.

В. “ИРГЭНИЙ БОЛОН АРИЛЖААНЫ ХЭРГИЙН АСУУДЛААР ГАДААДЫН ШҮҮХИЙН ШИЙДВЭР, МАРГААН ШИЙДВЭРЛЭХ ШҮҮХИЙН ХАРЬЯАЛЛЫН ТУХАЙ” ГААГИЙН КОНВЕНЦ

“Иргэний болон арилжааны хэргийн асуудлаар гадаадын шүүхийн шийдвэр, маргаан шийдвэрлэх шүүхийн харьяаллын тухай” Гаагийн конвенц (цаашид Гаагийн конвенц гэх)-ийг анх 1992 онд АНУ санаачилсан. Янз бүрийн харьяаллаар шийдсэн шүүхийн шийдвэрийг биелүүлэх, олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрүүлэх асуудлыг шийдвэрлэх зорилготой байсан.¹⁶ 1999 оны 10 дугаар сард тусгай комисс анхны төслийг бэлдэж дууссан тэр үеэс конвенцийг батлуулах анхны алхам хийгдсэн. Эхний төслийн талаар маш олон санал, шүүмж гарч байсан ба ялангуяа АНУ-ын зүгээс энэ байдал хүчтэй гарч байсан

¹⁵Хуо Шу И (2012№2-37) *Хил дамнаж хэрэглэгчтэй байгуулсан цахим хэлбэр бүхий гэрээний маргаанд шүүхийн харьяаллыг нэгдмэл байдлаар тогтоох боломж*/(орч Мөнхтуяа Н), Хууль дээдлэх ёс сэтгүүл, 35-40 дэх тал

¹⁶Худалдааны яамны АНУ-ын Патентын болон Барааны тэмдэгийн газар, RIN 0651-AB25, Иргэний болон арилжааны асуудлаарх гадаадын шүүхийн шийдвэр болон шүүхийн харьяаллын тухай конвенцийн анхны төслийн хэлэлцүүлгийн тэмдэглэлийг хүссэн өргөдөл <http://www.uspto.gov/web/offices/com/sol/notices/prdrconjud.html> (сүүлд нэвтэрсэн огноо 2010.01.24)



аж.¹⁷ Учир нь тус төслийн 7 дугаар зүйлд заасан хэрэглэгчтэй байгуулах гэрээний тухай заалт нь өмнө батлагдсан Брюсселийн Конвенц¹⁸-ийн 9 дүгээр зүйлийн хуулбар байсан ба энэ нь АНУ-д хэвшин тогтсон харьяаллын асуудлаарх хэм хэмжээнээс¹⁹ тэс ондоо, түүний эсрэг утгатай байсан. Иймд АНУ болон Европын улс орнуудын харьяаллын асуудлаар зарчмын шинжтэй энэхүү ялгаа нь уг төсөл амжилтад хүрээгүй гол шалтгаан болж, уг ажлыг цааш үргэжлүүлэхийн тулд төслийг өөрчлөх шаардлага тулгарсан. Энэ талаар Фаусто Покар “1999 оны төсөл нь хэт түргэн, маш их асуудлыг шийдвэрлэхийг оролдсон учраас амжилтад хүрээгүй” гэж цохон өгүүлсэн байдаг.²⁰ 2001 оны 6 дугаар сард Гаагийн дипломат хурал нь тааламжгүй тэмдэглэл хөтөлснөөр дуусгавар болсон юм. Хэдийгээр 2001 онд хийгдсэн дараагийн төсөл²¹ нь конвенцийн хэрэглэгдэх хүрээг улам нарийсгасан, шинэчилсэн хувилбар байсан боловч зарим нэг, тухайлбал, цахим худалдаатай холбоотой чухал асуудлуудад талууд зөвшилцөлд хүрч чадаагүйн улмаас бас л хэрэгжээгүй. Хэрэгцээ нь улам өсч буй цахим худалдааны хувьд хэрэглэгчтэй байгуулах гэрээнд хэрэглэх хууль болон маргаан шийдэх шүүхийн харьяаллын асуудлыг тусгасан 7 дугаар зүйлийн талаарх хэлэлцээр өнөөх сөрөг байдлыг дахиж үүсгэсэн. Өөр нэг бэрхшээл нь тухайн цахим хуудас ажиллуулагчид бараа, бүтээгдэхүүнийхээ сурталчилгаа, үзүүлж буй үйлчилгээгээ өөрийн хамаарах улсын хэл дээр танилцуулах нь шаардлагатай арга хэмжээ авч буйг харуулах хангалттай байдал мөн үү, хэрэглэгч маргаанаа шийдвэрлүүлэх шүүхээ гэрээ байгуулахаас өмнө сонгох, бизнес эрхлэгчийн хувьд ашиггүй өөр улсын шүүхийг сонгохоос хамгаалах зэргийг зарим технологийн дэвшлийн туслалцаатай шийдвэрлэх үү гэдэгт АНУ болон Европын улс орнуудын хувьд маргаан шийдвэрлүүлэх шүүхээ сонгох, түүний харьяаллыг тогтоох асуудал дээр зарчмын хувьд зөрүүтэй. Энэхүү бэрхшээлийн улмаас олон улсын хэмжээнд шүүхийн харьяаллын асуудлыг уялдуулах Гаагийн хурлын хүчин чармайлт талаар болсон.

Хэдийгээр конвенц батлагдаж чадаагүй ч олон улсын хувийн эрх зүйн харилцаанд олон улсын нийтийн эрх зүйн гэрээг ашиглах, технологийн хурдацтай хөгжилцахим худалдааны эрх зүйн орчинг улам уян хатан хоорондоо нийцсэн байхыг шаардаж байгаа хэрэгцээ зэргийг Гаагийн хурлуудын туршлага харуулсан юм.

¹⁷ Jeffrey D Kovar, US Department of State Assistant Legal Adviser for Private International Law, letter to Alasdair Wallace, Head of International and Common Law Services Division, Lord Chancellor's Department (Sep. 2000) <http://www.cptech.org/ecom/jurisdiction/kovarletter.html> (сүүлд нэвтэрсэн огноо 2010.01.24)

¹⁸ 1999 оны төсөл болон Брюссель Конвенц аль аль нь хүрэх газар нутгийн харьяаллаар асуудлыг шийдвэрлэх арга хэрэглэсэн. Хэрэглэгчтэй байгуулсан гэрээний тухай заалтууд уг төсөл болон конвенцид яг адил байна.

¹⁹ Jeffrey D Kovar, US Department of State Assistant Legal Adviser for Private International Law, letter to Alasdair Wallace, Head of International and Common Law Services Division, Lord Chancellor's Department (Sep. 2000), 124 дүгээр ишлэл, <http://www.cptech.org/ecom/jurisdiction/kovarletter.html> (сүүлд нэвтэрсэн огноо 2012.06.07)

²⁰ The Hague Preliminary Convention on Jurisdiction and Judgments, Edited by Jausto Pocar & Costanza Honorati, Wolters Kluwer Italia, 2005, p 370

²¹ <http://www.cptech.org/ecom/jurisdiction/hague.html> хаягнаас конвенцтой танилцана уу (сүүлд нэвтэрсэн огноо 2012.06.07)



Г. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ ШҮҮХИЙГ СОНГОХ ЗӨВШИЛЦЛИЙН ТУХАЙ ГААГИЙН КОНВЕНЦ

Иргэний болон худалдааны талаарх гадаадын шүүхийн шийдвэр, түүний харьяаллын тухай Гаагийн конвенц нь өөрийн зорилгод хүрч чадаагүй тул хурлыг зохион байгуулагчдын зүгээс иргэний болон арилжааны асуудлаар гадаадын шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрч, хэрэгжүүлэх, харьяаллын талаар нэгдсэн журам тогтоох²² асуудлаар 2005 онд өөр конвенцийн төслийг бэлтгэжээ. Уг конвенцийн нэр нь *“Маргаан шийдвэрлэх шүүхийг сонгох зөвшилцлийн тухай”* юм. Урьд гаргасан алдаагаа давтахгүйг хичээж 2005 оны конвенцийг 2001 оны конвенцтэй харьцуулахад мэдэгдэхүйц хэмжээгээр хамрах хүрээг нь хязгаарлаж өгсөн. Ямар нэг улс орон уг конвенцод гарын үсэг зураагүй байгаа учраас уг баримт бичиг хараахан хэрэгжиж эхлээгүй. “Маргаан шийдвэрлэх шүүхийг сонгох зөвшилцлийн тухай” Гаагийн конвенцийн ирээдүй тун бүрхэг харагдаж байгаа боловч 2001 оны конвенцийн бүтэлгүйтэл хамгийн их маргалдсан асуудлаар цахим харилцааг зохицуулах нэгдмэл хэм хэмжээг бий болгох, цахим гэрээнээс үүдсэн маргааныг шийдвэрлэх шүүхийн харьяаллалыг тогтоох хэм хэмжээг тодорхой болгохыг зорьсон. Харамсалтай нь В2С буюу бизнесээс хэрэглэгч рүү чиглэсэн харилцаанд хийгдэж буй цахим гэрээнийн хувьд уг конвенц хэрэглэгдэх нь бага байх болно. Учир нь тус конвенцийн 2 (а) дугаар зүйлд хэрэглэгчийг уг конвенц үйлчлэх бусад маргаан үүсгэж буй субъектүүдтэй адилтгаж үзэлгүй хассан.

Д. ОЛОН УЛСЫН ГЭРЭЭНД ЦАХИМ ХАРИЛЦААГ АШИГЛАХ ТУХАЙ КОНВЕНЦ

2005 оны 11 дүгээр сарын 23-нд НҮБ-ийн Ерөнхий Ассамблейгаас *“Олон улсын гэрээнд цахим харилцааг ашиглах тухай конвенц”*-ийг баталсан. Олон улсын цахим худалдааны эрх зүйн хөгжилд энэхүү конвенц чухал түлхэц болж байна. Энэхүү конвенцийн гол зорилго нь эрх зүйн тодорхой байдал, худалдаа арилжааны урьдчилан таамаглаж болохуйц байдал зэргийг улам тодруулахад оршино²³. Мэдээллийн системийн хөгжлийн тусламжтай бий болсон газар зүйн байршлын асуудлыг улам өргөн хүрээнд авч үзсэнд, уг конвенциос өмнө байгуулагдаж байсан гэрээний хэрэглэгдэх хүрээг улам өргөтгөж өгсөнд тус баримт бичгийн ач холбогдол оршино. Конвенцийн зорилго нь цахим харилцааны дүнд хийгдсэн гэрээ болон цаасан дээр буулган, гарын үсэг зурсан баримт бичгүүд ямар тохиолдолд адил тэгш байх шалгуур тавьсан.

Конвенц нь оршил, 25 зүйлээс бүрдэнэ. Уг баримт бичиг бүхэлдээ 4 бүлэг болж хуваагддаг. Эхний бүлэгт энэхүү баримт бичгийн үйлчлэх хүрээг тодорхойлсон бол хоёр дахь бүлэгт уг баримт бичигт хэрэглэсэн нэр томъёоны

²² Маргаан шийдвэрлэх шүүхийг сонгох зөвшилцлийн тухай (Convention on Hague Choice of Court). - http://www.hcch.net/index_en.php?act=conventions.text&cid=98 (сүүлд нэвтэрсэн огноо 2012. 06.07)

²³ Paul Przemyslaw Polanski (2006), 19th Bled eConference eValues, *“Convention on E-Contracting: The Rise of International law of Electronic Commerce”*, Bled, Slovenia, June 5-7.p.1-10



тодорхойлолтыг агуулсан. Гуравдугаар бүлэгт цахим харилцааг хууль зүйн үүднээс хүлээн зөвшөөрөх тухай заалтууд, цахим харилцаанд хэрэглэх газар, хугацаа, гэрээ болон цахим харилцаанд тавигдах хэлбэрийн шаардлага, гэрээний санал гаргах, гэрээ байгуулахад автомат систем ашиглах, гэрээний нөхцөлүүд болон “оролтын алдаа (input error)” –ын үед авах арга хэмжээний талаарх заалтууд орсон. Сүүлийн бүлэгт конвенцийн төгсгөлийн заалтуудыг оруулж өгсөн.

Энэхүү конвенцийн эхийг бэлтгэгчид 1980 оны Худалдах, Худалдан авах гэрээний тухай Венийн Конвенц, 1996 оны Цахим худалдааны тухай Загвар Хууль, 2001 оны Цахим гарын үсгийн тухай загвар хуулиудыг голлож баримтлан эхийг бэлтгэсэн. Конвенцийн үйлчлэх хүрээ нь өөр өөр улс оронд бизнесийн үйл ажиллагаа явуулж буй талууд, мөн талуудын аль аль нь эсвэл аль нэг этгээдийн бизнесийн үйл ажиллагаа явуулж буй газар нь тус конвенцийн гишүүн бус улс байсан ч цахим хэлбэрээр гэрээ хийж байгаа талуудад үйлчилнэ. Цахим худалдааны тухай конвенцийн хувьд гэрээнд оролцогч талуудын хувьд уг конвенц үйлдчилдэг байсантай харьцуулахад энэхүү конвенцийн үйлчлэх хүрээ илүү өргөн болж өгсөн.

Уг конвенц нь олон улсын арилжааны эрх зүйн хөгжлийн өмнөх үе шаттай нэг адил гагцхүү B2B цахим худалдаанд хэрэглэгдэхээр хязгаарлагдсанаараа өмнө дурьдсан конвенцуудаас ялгаатай. Тэгэхээр хэрэглэгчтэй (B2C, C2C, C2B) гэрээ байгуулан ажилладаг онлайн аж ахуйн нэгжүүдэд энэ конвенциос ямар нэг эрх, үүрэг үүсэхгүй. Орчин үед эрх зүйн аль ч системд хэрэглэгчийг хамгаалах асуудал маш өндөрт тавигддаг болсон. B2B цахим худалдаанд ашиглагдах энэхүү конвенцийн хүрээ өргөн гэж өмнө нь дурьдсан. Худалдааны гэрээнээс гадна, бартер буюу арилжааны төрлийн гэрээнд энэхүү конвенц үйлчилнэ. Мөн үйлчилгээ болон мэдээллийн чанартай хэлцэлд энэ конвенц үйлчилнэ. Тодруулбал, интернэт ашиглан хийж буй бараа, үйлчилгээ, мэдээллийн талаарх олон төрлийн хэлцэлд энэ конвенц үйлчилнэ. Эдгээр зохицуулалтын туслалцаатай олон улсын цахим үйлчилгээг эрх зүйн үүднээс хүлээн зөвшөөрсөн.

Конвенцийн зүгээс тавьж буй шаардлага бол цахим үйлчилгээ явуулж буй бизнесийн байгууллага нь өөр өөр улс оронд байрлаж байх явдал. Интернэт нь өөрөө улс төр, хууль эрх зүйгээр тогтоож буй хил хязгаараас хальсан ойлголт боловч конвенцид бизнесийн үйл ажиллагаа явуулах газар гэдгийг “тодорхой байршлаас үл хамаарсан бараа үйлчилгээний талаарх түр зуурын заалтаас гадна эдийн засгийн үйл ажиллагааг түр зуурын биш байдлаар эрхэлж буй талын газар”²⁴ гэж үзнэ. Талуудын бизнесийн үйл ажиллагаа явуулж буй газар нь тухайн талын оршин байгаа газрыг тодорхойлоход ач холбогдолтой. Талуудын бизнесийн үйл ажиллагаа хаана

²⁴ Paul Przemyslaw Polanski (2006), 19th Bled eConference eValues, “Convention on E-Contracting: The Rise of International law of Electronic Commerce”, Bled, Slovenia, June 5-7, p.1-10



байгаагаас үл хамаарч уг конвенциор гол хоёр зарчмыг тогтоож өгсөн. Нэгдүгээрт, сервер хаана байрлаж байгаа болон ямар домайн нэр ашиглаж байгаа нь чухал биш. Талуудын өөрсдийн тодорхойлсон, бодитойгоор оршин үйл ажиллагаа явуулж байгаа газрыг авч үзнэ. Хоёрдугаарт, уламжлалт болон онлайн байдлаар худалдаа эрхэлдэг “click-and-mortar” хэмээх компаниудыг юун түрүүн конвенцид хамааруулна. Онлайн худалдаа эрхэлдэг Amazon.com гэх мэтийн хуулийн этгээдүүдийн үйл ажиллагааг энэ конвенцоор зохицуулах боловч бодит байдалд оршин байдаггүй, гагцхүү интэрнэтээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудыг хамруулахгүй.

1.4. Цахим худалдаанд холбогдох олон улсын загвар хууль, түүний үндсэн үзэл баримтлал

1996 онд НҮБ-ын Олон улсын худалдааны эрх зүйг хариуцсан комиссоос “Цахим худалдааны загвар хууль”-ийг батлан гаргасан юм²⁵. НҮБ-ын Олон улсын худалдааны эрх зүйн комисс (UNCITRAL) нь олон улсын худалдааны хуулийг нэг мөр ойлгож, хэрэгжилтийг хангах зохион байгуулах чиг үүргийнхээ хүрээнд худалдааны хуулийг хэрэгжүүлэхэд гарч буй зөрүүтэй ойлголтууд болон зарим зохицуулагдаагүй, тодорхойгүй байгаа асуудлыг цэгцлэх зорилгоор энэхүү загвар хуулийг баталсан. Өөрөөр хэлбэл, бизнесийн талууд харилцаа холбоондоо компьютер болон орчин үеийн техникийн шийдлүүдийг өргөнөөр ашиглахтай холбоотойгоор гарч байгаа өөрчлөлтүүдтэй уялдуулж боловсруулсан. 1984 оны Комиссын 17 дугаар хуралдаанаар “Автомат мэдээлэл боловсруулалтын эрх зүйн асуудал” сэдвээр хэлэлцүүлэг болсон бөгөөд тус хэлэлцүүлгээр компьютерийн мэдээллийн аюулгүй байдал нь автомат мэдээллийн системийн эрх зүйн үр дагаварын асуудал юм байна гэсэн дүгнэлтэд хүрсэн. Компьютер болон тэдгээрийн хоорондын мэдээлэл дамжуулалт нь олон улсын худалдаанд тавих шаардлагыг (тухайлбал, худалдааны баримт бичиг нь заавал бичгэн хэлбэртэй бөгөөд гарын үсэг зурсан байх) хангахгүй байгаа нь гол асуудал болсон. 1985 оны Комиссын 18 дугаар хурлаас улс орнуудад худалдааны баримт бичгийн цаасан хэлбэрээс аль болох татгалзаж цахим баримт бичиг хэрэглэх, энэхүү цахим хэлбэрийн бичиг баримтыг нотлох баримтын түвшинд үнэлэх, худалдааны эрх зүйн орчин болон бусад дүрэм, журам боловсруулдаг байгууллагууд аль болох дээрх уриалгыг харгалзан үзэж эдгээр баримт бичгийг боловсруулахдаа баримталж байх талаар зөвлөмж гаргасан. Энэ зөвлөмжийн дагуу улс орнууд өөрийн хууль тогтоомжийг зөвлөмжтэй нийцүүлэх оролдлого хийхийг чармайж байсан ч хэрхэн өөрчлөлт хийх талаар зөвлөмжид тусгаагүй байсан. Ийнхүү улс орнууд хэрхэн өөрчлөлт хийх арга замын талаар дахин зөвлөмж өгөх хүсэлт тавьсаны дагуу Комиссоос цахим худалдааны загвар хууль батлах ёстой юм байна гэдэг асуудал дээр санал нэгдсэн. 1988 оноос судалгааны ажил хийжэхэлсэн ба 1991

²⁵Г.Халиунаа, Цахим худалдааны загвар хууль батлах болсон шалтгаан, нөхцөл, Хууль дээдлэх ёс, 2012 № 2 (37), ху 91-95



оны 24 дүгээр хуралдаанаар “Цахим мэдээллийн солилцоо”-ны асуудлын талаар хэлэлцэж хурлаар хууль зүйн хувьд ямар бэрхшээлтэй тулгарч байгааг олж тогтоосон. Интернэт орчинд янз бүрийн хэрэгцээ шаардлагатай, олон төрлийн хэрэглэгчид байдгаас шалтгаалан мэдээлэл нь өөр хоорондоо харилцан адилгүй байдаг. Иймд мэдээлэл солилцооны үндсэн хүрээгээ зөв тодорхойлж, нэг систем, нэгдсэн зарчим, ойлголттой болохын тулд загвар хуулийн эцсийн төслийг улс орнууд өөрийн хууль тогтоомждоо хэрхэн нийцүүлж, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлсон удирдамжийн хамт боловсруулжээ. Комиссын 29 дүгээр хуралдаанаар Хянан засах газраас бэлтгэсэн загвар хуулийн бичвэрийг авч үзсэний дараа 1996 оны 6 дугаар сарын 12-ны өдөр 605 дугаар цуглаан дээр дараах шийдвэрийг гаргасан.

Загвар хуулийн гол зорилго нь цахим худалдааг зохицуулах явдлыг хялбар болгоход чиглэгдсэн, одоогийн үйлчилж байгаа хууль зүйн шаардлагуудад нийцүүлэх, эрх зүйн суурь үнэлэмж, үнэ цэнийг гаргаж тавих, хууль зүйн хувьд тодорхой байдлыг бий болгох явдал юм. Талуудын бие даасан байдлын хувьд өөрсдийн хийж буй хэлцэлд тохирох аюулгүй байдал, хамгаалалтын түвшинг талууд өөрсдөө чөлөөтэй сонгох боломжийг олгосон. Түүнчлэн цахим худалдаандашиглагддаг харилцаа холбооны хэрэгсэл, техник, технологийг хэрхэн хэрэглэх талаар талуудын тохиролцоог юун түрүүнд чухалчлан авч үзэх ёстой.

Тус загвар хуулиар дараах чиг үүргийн шинжтэй шаардлагуудыг хүлээн зөвшөөрсөн. Эдгээр шаардлагуудыг тус бүрт нь товчлон дурьдвал²⁶:

Эх бичиг баримтыг “бичгээр” шаардах. Ихэнх улсын хууль тогтоомж болон олон улсын гэрээнд тодорхой нэг арилжаа худалдааг хийхдээ эх бичиг баримтаар баталгаажуулахыг шаарддаг. Ийнхүү эх бичиг баримтыг шаардах нь олон шалтгаантай холбоотой юм. Тухайлбал, хэрэв эх бичиг баримт нь тухайн гэрээг хүчинтэй болгох нөхцөл байх тохиолдолд эх бичиг баримтгүй арилжаа худалдаа нь хүчингүйд тооцогдоно. Нөгөөтэйгүүр, эх бичиг баримт нь заавал гэрээг хүчингүй болгох нөхцөл болохгүй ч маргаан үүсэх, шүүхэд хандах зэрэг тохиолдолд тухайн гэрээг хэрэгжүүлэх, гэрээнд тусгагдсан нөхцлүүдийг хангуулах гол нөхцөл болдог учраас хуулиар эх бичиг баримтыг нотолгоо болгох үүднээс шаарддаг юм.²⁷Тодруулбал цаасан дээр бичигдсэн/буулгасан болон цахим хэлбэрийн хэлцэлд адилхан хандах ёстой бөгөөд харилцаа холбооны ялгаатай хэрэгслэлүүдийг адилтган авч үзэх (EDI, e-mail, Internet, telegram, telex, fax – цахим шуудан, интернэт, телеграм, телекс, факс) нь чухал.

Дотоодын хууль тогтоомж болон олон улсын эрх зүйд “бичгээр” эсхүл “бичиг баримт” гэсэн нэр томъёог ихээхэн ашигладаг хэдий ч эдгээр нэр

²⁶ Худалдааны эрх зүйн асуудлуудын талаар илүү нарийн тодорхойлолт өгөх шаардлагатай. НҮБХХБ-ын Нарийн бичгийн дарга нарын газраас гаргасан “Цахим худалдаа: Хууль эрх зүйн асуудлууд”сэдэвт баримт бичиг, 91-179 дүгээр параграф.

²⁷ Мөн тэнд, 91 дүгээр параграф.



томъёоны тодорхойлолтыг бүрэн тайлбарладаггүй. Энэ тохиолдолд эх бичиг баримт нь нотолгоо болох учиртай.²⁸ Мэдээлэл нь бичмэл хэлбэртэй байна гэж хуульд хэлбэрийн шаардлага тавьсан нөхцөлд хэрэв агуулагдаж буй мэдээлэл нь хэрэглэж болохуйц мөн тухайн холбогдох баримт бичгийн хувьд ашиглагдахуйц байвал зурвас мэдээлэл нь энэхүү шаардлагыг хангасан гэж үзнэ хэмээн хуулийн 6 дугаар зүйлд заасан.

Эх “гарын үсэг” шаардах. Ихэнх тохиолдолд тухайн бичиг баримтанд гарын үсэг зурах эсхүл үүнтэй тэнцэх бусад төрлийн нотолгоо нь тухайн баримтанд гарын үсэг зурсан этгээд уг баримтын агуулгад тусгагдсан эрхийг эдлэх, үүргийг хүлээх нотолгоо болдог. Хууль ёсны дагуу бичиг баримтын нотолгоонд эх гарын үсгийг тооцдог. Сүүлийн үеийн дотоодын хууль тогтоомж болон олон улсын гэрээнд нотолгоог гарын үсгээс гадна бусад төрлийн тухайлбал, тамга, цоолбор, факс эсхүл цахим хэлбэрээр гаргахыг хүлээн зөвшөөрөх болсон.²⁹ Зурвас мэдээлэл нь гарын үсэг гэдгийг илэрхийлэх ямар нэг аргыг хэрэглэсэн бөгөөд зурвас мэдээлэл дэх мэдээллийн агуулгыг хүлээн зөвшөөрч буйг илтгэн харуулж байгаа, мөн тухайн арга нь зурвас мэдээлэл дэх харилцаа холбооны зорилгод нийцсэн тохиромжтой, найдвартай байвал гарын үсгийн хууль зүйн шаардлагуудыг хангаж байна гэж үзэх тухай загвар хуулийн 7 дугаар зүйлээр зохицуулжээ.

“Эх” бичиг баримт буюу “Эх хувь”-ийг шаардах. Тодорхой бичиг баримтыг эх хувиар нь байхыг шаардах нь мөн л цахим худалдааны хөгжилд ихээхэн саад тотгор учруулж байна гэж тооцогддог. “Бичгээр”, “гарын үсэг”, “эх” гэсэн гэсэн ойлголтууд нь харилцан уялдаа холбоотой тул ихэнх тохиолдолд бичиг баримтанд гарын үсэг бүхий эх бичиг баримтыг бичгээр баталгаажуулсан байх шаардлагыг тавьдаг юм. Эх бичиг баримтыг шаардах нь тухайн бичиг баримтыг хуурамч бус, хууль ёсны дагуу хийгдсэн гэдгийг нотлох зорилготой юм.³⁰ Загвар хуулийн 8 дугаар зүйлээр зурвас мэдээлэл байдлаар эцсийн хэлбэр болгон анх удаа ерөнхийлөгдсөн тэр цаг мөчид уг мэдээлэл нэгдмэл цогц нэг зүйл боллоо гэдгийг найдвартай батлах нотолгоо байгаа нөхцөлд, эсвэл уг мэдээлэл нь хүлээн авч буй хүнд очихдоо жижиг хэсгүүд болон задрахгүйгээр харагдах боломжтой байгаа нөхцөлд уг зурвас мэдээллийг эх хувийн хувьд тавигдах хууль зүйн шаардлагыг хангасан гэж үзнэ.

Нотлох баримт, нотолгоо болох. Мэдээллийн аюулгүй байдал болон цахим илгээмж (electronic message) бүхий нотолгоо нь цахим худалдаанд амин чухал ач холбогдолтой байдаг. Цахим ертөнцөд цаасан дээр бичсэн бичиг баримт болон гараар бичсэн баримтыг ашиглах боломжгүй байдаг нь цахим илгээмжийг хуурамчаас ялгахад саад учруулдаг. Интернет сүлжээ гэх мэт цахим харилцаа холбооны нээлттэй системийн өнөө үед аюулгүй байдлыг

²⁸ Мөн тэнд, 93 дугаар параграф.

²⁹ Мөн тэнд, 102 дугаар параграф.

³⁰ Мөн тэнд, 114 дүгээр параграф.



хангах асуудал нь ихээхэн дарамт, хүнд сорилт болж байна.³¹ Ийм ч учраас загвар хуулийн 9 дүгээр зүйлээр аливаа эрх зүйн ажиллагаанд зурвас мэдээлэл учраас нотлох баримтын хэмжээнд авч үзэхээс татгалзахгүй байх эсвэл нотлох баримттай холбоотой аливаа дүрэм журам үйлчлэхгүй байх ёсгүй хэмээн зохицуулсан байна.

Цахим илгээмжийг баталгаажуулах үнэ цэнэ. Хууль эрх зүйн орчинд цахим илгээмжийг нотолгоо бичиг баримтанд хүлээн зөвшөөрөх явдал цахим худалдааны хөгжлийн гол түлхүүр нь болоод байна. Хэдийгээр зарим улсуудын уян хатан хууль тогтоомж цахим илгээмжийг нотолгоо бичиг баримтанд тооцдог ч хатуу хууль тогтоомжтой бусад улсууд цахим илгээмжийг нотолгоо бичиг баримт гэж үздэггүй юм.³²

Цахим илгээмжийг хадгалах. Нягтлан бодох бүртгэл, татвар, аудит, нотолгооны зорилгоор болон бусад хууль тогтоомжид тавьсан шаардлагын үүднээс тодорхой баримтыг эсхүл мэдээллийг цаасан хэлбэрээр хадгалах шаардлага нь цахим худалдааны хөгжилд нэмэлт саад тотгор болж байна.

Баримтыг орлуулах. Хүлээн авагчийн нэр дээр бичигдэх ачилтын баримт зэрэг арилжааны баримтыг цахим хувилбараар орлох нь олон улсын худалдааны хүрээнд цахим худалдааг хэрэгжүүлэхэд тулгарах хамгийн ээдрээтэй асуудал юм. Энэ нь арилжааны баримтын шилжүүлэх, бодитоор харах, мэдрэх боломжтой зэрэг шинж чанартай холбоотой юм. Арилжааны баримт (Хүлээн авагчийн нэр дээр бичигдэх ачилтын баримт зэрэг)-нд үйлчлэх хууль тогтоомж нь бичиг баримтын эх хувийг биет байдлаар эзэмшсэнээр тухайн бараа бүтээгдэхүүнтэй холбоотой эрхийг эдлэхэд оршдог. Арилжааны баримтыг орлуулахдаа цаасан хэлбэрийн баримтын хуулиар хүлээн зөвшөөрөгдсөн бүхий л шинж чанарыг хадгалж үлдэх явдал юм. Иймээс хууль тогтоомжоор цахим илгээмж солилцох хэлбэрээр бараа бүтээгдэхүүний өмчлөх зэрэг хууль ёсны эрхүүдийг шилжүүлэх боломжийг талуудад хүлээн зөвшөөрөх шаардлагатай байна.

Гэрээ хэлцэл байгуулах, хүчинтэй болох. Амаар байгуулсан гэрээ хэлцлийг ихэнх эрх зүйн тогтолцоонд хүчинтэй гэрээ хэлцэлд тооцдог хэдий ч цахим хэлбэрээр хийгдсэн гэрээ хэлцэлтэй холбогдуулан олон хүндрэлтэй асуудал, тодорхой бус нөхцөл байдал үүсдэг. Эдгээр асуудал нь гэрээ хэлцэл хүчинтэй болох нөхцөлүүд тухайлбал, бичгээр, гарын үсэг, гэрээ хэлцэл байгуулсан хугацаа ба байршил, шүүх маргааны үед гэрээ хэлцлийн нөхцлийг баталгаажуулах нотолгоо зэрэгтэй холбоотой юм. Гэрээ хэлцэл байгуулах үед өмч шилжүүлэх, бараа бүтээгдэхүүнийг борлуулснаас үүсэх алдагдал, эрсдлийг хэрхэн шилжүүлэхийг тодорхойлох нь чухал ач холбогдолтой. Анх зурвас мэдээллийг бэлтгэсэн этгээд (originator)-ийн хяналтаас гарч мэдээллийн

³¹ Мөн тэнд, 60 дугаар параграф.

³² Мөн тэнд, 121 дүгээр параграф.



системд нэвтрэн орсон тохиолдолд зурвас мэдээлэл илгээгдсэн гэж үзнэ. Харин а/ хэрэв хариуцсан системд мэдээлэл нэвтэрч орсон үед мессэж мэдээллийг хаяглагч буюу мэдээлэл хүлээн авагч шинээр сонгогдсон мэдээллийн системээр зурвасыг хүлээн авсан гэж, б/хэрэв мессэж мэдээлэллийг хаяглагч буцаан хүлээн авсан үед хариуцсан системээс өөр мэдээллийн системд мессэж мэдээлэл илгээгдсэн бол зурвас мэдээллийг хүлээн авсан гэж тус тус тооцно.

Гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжихийн хэрээр уг харилцааг олон улсын хэмжээнд нэгдмэл зохицуулалтад оруулах хэрэгцээ нэмэгдэж, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, ялангуяа шинээр гарч ирж байгаа худалдааны хэлбэрийг нэгдсэн зохицуулалтад оруулан олон улсын эрх зүйн хүрээнд хуульчилсны нэгээхэн хэсэг нь дээр өгүүлсэн Цахим худалдааны загвар хууль юм.

Дүгнэлт

Нэгдүгээр бүлгийн хувьд дүгнэж авч үзвэл цахим худалдааг өргөн ба явцуу хүрээнд янз бүрээр тодорхойлж байна. Өргөн утгаараа текст, дуу, дүрс зэрэг өгөгдлийг цахим аргаар боловсруулж дэвшилтэт техник, технологи ашиглан интернэт орчинд дамжуулах ажиллагаанд суурилан хийгдэж буй бизнес, ажил хэрэггэж ойлгож болохоор байна. Харин явцуу утгаараа интернэт ашиглан цахим аргаар хийж гүйцэтгэж буй худалдах худалдан авах гэрээг, түүнтэй холбогдон үүсч буй гэрээний бус бусад харилцаа гэж ойлгодог аж.

UNCITRAL³³, OECD³⁴, ICC³⁵ зэрэг дэлхийн худалдааны байгууллагуудаас гаргасан загвар хууль болон зөвлөмжүүд нь цахим худалдааны олон улсын эрх зүйг бүрэлдүүлж байдгийг энэ бүлэгт авч үзлээ. Эдгээр баримт бичгүүдээс тухайлан цахим худалдааны хөгжилтэй уялдуулан дээрх байгууллагуудаас олон улсын түвшинд 1996 онд НҮБ-ын Олон улсын худалдааны эрх зүйг хариуцсан комиссоос “Цахим худалдааны загвар хууль”-ийг, 11 дүгээр сарын 23-ны НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 2005 оны “Олон улсын гэрээнд цахим харилцааг ашиглах тухай тухай конвенц” зэргийг баталсан нь цахим худалдааны олон улсын эрх зүйн хөгжилд томоохон хувь нэмэр болсон.

³³ НҮБ-ын олон улсын худалдааны байгууллага.

³⁴ Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага.

³⁵ Олон улсын худалдааны танхим.



ХОЁР. ЦАХИМ ХУДАЛДАА ДАХЬ ЭРХ ЗҮЙН ОНЦЛОГ АСУУДАЛ

Цахим худалдаа нь эрх зүйн олон асуудлыг хөнддөг. Тухайлбал, цахим хэлбэрээр хийгдсэн арилжаа эрх зүйн хүчинтэй байх асуудал, хууль зүйн үр дагавар зэргийг дурдаж болно.

2.1. Цахим худалдааны эрх зүйн нийтлэг асуудал

Эрдэмтэд, судлаачдын судалгаагаар ийнхүү уялдуулан нийцүүлэх нь их ач холбогдолтой хэмээн хүлээн зөвшөөрч, энэ ажлын чухлыг онцолсон байна. Тухайлбал, олон улсын хувийн эрх зүйн хөгжилд томоохон хувь нэмэр оруулж байсан уламжлалт онолуудын талаар тэр дундаа “партикуляризм” буюу нэг зүйлийг тухайлан авч үзэх болон “юниверсализм” буюу ерөнхийлөн авч үзэх онолын талаар эрдэмтэн Лорны И.Геллис тэмдэглэхдээ “цахим худалдааны гэрээнд хэрэглэх хууль, маргаан гарсан тохиолдолд маргаанаа шийдвэрлүүлэх шүүхийн харьяаллыг тогтоох журмыг хөгжүүлэхэд “партикуляризм”-ын онолыг үргэжлүүлэн хэрэглэх нь одоо нэгэнт цагаа өнгөрөөжээ” хэмээсэн байдаг.³⁶ Онлайнаар хийж буй хэрэглэгчийн гэрээнд янз бүрийн, уян хатан биш, үндэсний хэмжээнд хэрэглэдэг арга замуудаас илүүтэй хоорондоо нягт тодорхой байдлаар уялдсан журам нэн шаардлагатай байна. Учир нь даяаршсан, хүрээ хязгаар нь тодорхой биш зах зээлд орж үйл ажиллагаа явуулахаасаа өмнө бизнесийн тооцоо хийж, тодорхой зохицуулалтын горим, журмыг тогтоохыг хүсэхийн зэрэгцээ хууль зүйн хувьд тодорхой байдлыг маш өндөр түвшинд хангасан хэрэглэгчдийн сэтгэл ханамж, итгэлийг төрүүлэх нь бизнес эрхлэгчдэд юу юунаас чухал болсон³⁷.

Хэдийгээр цахим худалдааны шинэ орчин бий болсонтой холбогдуулан одоо мөрдөгдөж буй хууль тогтоомжийг хүчингүй болгож, шинэ хууль тогтоомж боловсруулах шаардлагагүй гэдэг дээр санал нэгддэг ч шинээр бий болсон нөхцөл байдалд нийцүүлэн цахим худалдааны талаарх хууль тогтоомжийг өөрчилж, холбогдох нэмэлт өөрчлөлтүүдийг хууль тогтоомжид зайлшгүй тусгах нь зүйтэй гэдэг дээр нэгдсэн нэг ойлголтонд хүрсэн байна.

Энэхүү хэсэгт цахим ертөнцөд саад бэрхшээл үзүүлж байгаа онцлог асуудлуудыг ерөнхийд нь авч үзэх болно.

Үндэсний болон олон улсын эрх зүй олон улсын худалдаанд цахим арилжааг гүйцэтгэхэд эх бичиг баримт эсхүл эх гарын үсгийг шаарддаг нь дэлхийн түвшинд цахим худалдааг хөгжүүлэхэд гол бэрхшээлд тооцогдож байна.³⁸ Цахим арилжааны бусад хууль эрх зүйн асуудлуудад мэдээллийг

³⁶ LORNA E. GILLIES, ELECTRONIC COMMERCE AND INTERNATIONAL PRIVATE LAW-A STUDY OF ELECTRONIC CONSUMER CONTRACTS (Ashgate Publishing Limited 2008) 4 дүгээр ишлэл, 50 х.

³⁷ Хуо Шу И (2012№2-37) Хил дамнаж хэрэглэгчтэй байгуулсан цахим хэлбэр бүхий гэрээний маргаанд шүүхийн харьяаллыг нэгдмэл байдлаар тогтоох боломж/, (орч Мөнхтуяа Н), Хууль дээдлэх ёс сэтгүүл, 35-40 дэх тал

³⁸ “Цахим худалдаа: Хууль эрх зүйн асуудлууд” UNCTAD/SDTE/BFB/1 дугаартай 1998 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн 87 дугаар параграф дахь нийтлэлийг үзнэ үү.



хамгаалах, татвар төлөх, гаалийн татвар ногдуулах, аюулгүй байдлыг хангах, оюуны өмчийн эрхийг хамгаалах, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, маргааныг шийдвэрлэхтэй холбоотой асуудлууд болон сахиж мөрдөх шаардлагатай хууль тогтоомж, хууль эрх зүй, интернет үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын хариуцлага, хууль бус болон гэмт хэрэг, интернетийн засаглал, цахим арилжаа явуулах төлбөр тооцооны тогтолцоо зэрэгтэй холбоотой асуудлууд багтана.³⁹

Оюуны өмчийн асуудал

Цахим орчинд барааны тэмдэг, зохиогчийн эрх, патентыг хамгаалах нь цахим худалдааны хөгжилд ноцтой хүндрэл учруулахаар байна. Цахим худалдаанаас үүдэн гарах оюуны өмчийн зарим асуудлыг шийдвэрлэх зорилгоор Дэлхийн Оюуны өмчийн байгууллага (ДООБ)-аас 1996 оны 12 дугаар сард Зохиогчийн эрхийн тухай, Үзүүлбэр, фонограммын тухай хэлэлцээрүүдийг тус тус баталсан байна.⁴⁰ Дэлхийн Оюуны өмчийн байгууллагын эдгээр конвенцүүд нь интернетээр үзүүлбэр үзүүлэгч, фонограм зохиогчдын эрх, зохиогчийн эрхийг олон улсын түвшинд хамгаалах хууль, эрх зүйн зарчмуудыг агуулж тэдгээрийг байнга шинэчилж байдаг. Үүний дээр интернетийн хүртээмж дэлхийн даяар болж дэлхийн хаанаас ч зохиогчийн бүтээлийг татаж авах бололцоотой болсныг харгалзан үзэж тэдгээрийг хууль бусаар татах, хэрэглэхийг хориглохыг дотоодын хууль тогтоомжоор тодотгохоор тусгажээ. Одоогоор Дэлхийн Оюуны өмчийн байгууллагад Аудио-видео үзүүлбэрийн тухай протокол, Мэдээллийн сангийн оюуны өмчийн хэлэлцээрийг байгуулах талаар хэлэлцүүлгийг өрнүүлж байна.

Оюуны өмчийн дараагийн нэг чухал зүйл бол домэйны нэрийг хуваарилах асуудал юм. ДООБ Интернетийн домэйны нэрийн оюуны өмч, холбогдох маргааныг шийдвэрлэхтэй холбоотой асуудлаар зөвлөмж боловсруулах олон улсын хэлэлцүүлгийг 1988 онд эхлүүлсэн байна.⁴¹

ДООБ-ын Арбитр, зуучлалын төвөөс цахим худалдаанд гарах маргааныг шийдвэрлэх интернет дээр суурилсан маргаан шийдвэрлэх төвийг сахисан, хурдан бөгөөд хямд системийг боловсруулсан байна. Цаашилбал, “Домэйн

³⁹ НҮБХХБ-ын “Цахим худалдааны эрх зүйн асуудлууд” сэдэвт TD/B/COM.3/EM.8/2 дугаартай тайланг үзнэ үү.

⁴⁰ Конвенцүүдийг бүрэн эхээр нь <http://ecommerce.wipo.int/activities> гэсэн хаягаар орж үзнэ үү. Конвенцүүд хүчин төгөлдөр болохын тулд дор хаяж 30 орон түүнд нэгдэн орж, хүлээн зөвшөөрөх ёстой. Дэлхийн Оюуны өмчийн байгууллагын оюуны өмч болон цахим худалдаатай холбоотой мэдээллийг <http://ecommerce.wipo.int> гэсэн хаягаар орж үзнэ үү.

⁴¹ Оноосон нэр, дугаарын интернетийн корпорацид (ОНДИК - Internet Corporation for Assigned Names and Numbers, ICANN) нь интернетээр бизнес эрхлэгч, техник мэргэжлийн болон шинжлэх ухааны өргөн төлөөлөл оролцсон холбооноос санаачилж 1998 оны 11 дүгээр сард байгуулагдсан ашгийн бус, хувийн компани юм. ОНДИК нь Домэйны нэрийн систем (Domain Name System)-ийг удирдлагаар хангаж ажилладаг бөгөөд энэ нь интернет хаягууд (вэбсайтын нэр, и-мэйл хаяг)-ыг дугаараар бус санахад амархан нэрээр хайж олоход тусалдаг юм. АНУ-ын Засгийн газар ОНДИК-т өөрийн домэйн нэрийн системийг удирдах, интернетийн протокол (IP)-ын хаягийг хуваарилах зай, протоколын үзүүлэлтүүдийг тогтоох болон суурь серверийн системийг удирдах эрхээ шилжүүлж, түүнийг энэ асуудлыг дэлхийн хэмжээнд зохицуулах байгууллагаар томилжээ. Интернетийн домэйн нэр олгох, ашиглах үйл явцын талаар нэмэлт мэдээллийг <http://ecommerce.wipo.int/domains/process> хаягаас үзнэ үү.



нэрийн маргааныг шийдвэрлэх үйлчилгээ"-г⁴² интернетийн домэйн нэрийг зүй бусаар бүртгүүлж, ашиглахаас үүдсэн маргааныг шийдвэрлэх зорилгоор нэвтрүүлсэн юм.

Цахим худалдаа нь оюуны өмчийн эрхийн хамгааллын хувьд эдийн засгийн болоод бодлогын ихээхэн ач холбогдолтойг хүлээн зөвшөөрч ДООБ-ын Ерөнхий Ассамблейгээс ДООБ-ын Цахим төлөвлөгөөг 1999 оны 9 дүгээр сард баталжээ.⁴³

Хэрэглэгчийн эрх ашиг хамгаалах

Цахим худалдаа нь гадаадаас бараа, үйлчилгээ худалдан авах урьд өмнө нь байгаагүй тийм боломжийг хэрэглэгчдэд олгох болсон. Энэ нь хэрэглэгчийн итгэл болон хэрэглэгчийг хамгаалах дүрэмтэй холбоотой шинэ асуудал гаргаж ирж байна. Хэдийгээр эдгээр асуудлыг дийлэнх нь агуулгаараа шинэ биш боловч хэрэглэгч, гадаадын компани хоорондын арилжаа үлэмж хэмжээгээр нэмэгдсэн нь асуудлыг шинэ түвшинд авч очсон байна. Компани, хэрэглэгч хоёр хооронд нүүр тулж уулзах нь хязгаарлагдмал, эсвэл бүр огт байхгүй болсон нь хэрэглэгчийн эрх ашиг хамгаалах асуудлыг дэлхийн түвшинд үр дүнтэйгээр шийдвэрлэх арга замыг эрэлхийлэхийг шаардаж байна.⁴⁴ Энэ утгаараа хэрэглэгчид интернетийг худалдаа, арилжаа хийхэд аюулгүй, тогтвортой орчин гэдэгт итгэж чадсан цагт цахим худалдаа бүрэн утгаараа хэрэгжиж чадна гэдгийг ерөнхийдөө хүлээн зөвшөөрсөн байдаг. Үүнтэй холбогдуулан хэрэглэгчийн эрх ашиг хамгаалах бодлого, хууль тогтоомж, арга ажиллагаа бүгд хэрэглэгчийг шуударга бус, луйврын үйлдэл, ажиллагаанаас хамгаалах замаар хэрэглэгчийн итгэлийг бэхжүүлж бизнесийн арилжааны орчинд борлуулагч, хэрэглэгч хоёрын хооронд илүү тогтвортой харилцаа бүрдүүлэхэд чиглэгдэнэ.⁴⁵ Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалахад туслалцаа дэмжлэг үзүүлж, цахим худалдаанд итгэх илтгэлийг бэхжүүлэх үүднээс ЭЗХАХБ-ын зүгээс одоогоор улс үндэстний хэмжээнд хэрэгжүүлэх арга хэмжээний багц удирдамжийг боловсруулж байна.

Татвар

Татварыг тогтолцоог бүрдүүлэх нь Засгийн газар, хувийн хэвшлийн алинд ч чухал асуудал байдаг. Татварын тогтолцоо нь шударга, тогтвортой бөгөөд бизнесийн хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүй байх нь чухал. Цахим

⁴² Арбитр, зуучлалын төвийн домэйн нэрийн маргаан шийдвэрлэх үйлчилгээг нэвтрүүлж хэрэгжүүлсний дүнд ОНДИК "Домэйн нэрийн маргаан шийдвэрлэх нэгдсэн удирдамж"-ийг 1999 оны 8 дугаар сарын 26-нд баталж, улмаар 1999 оны 10 дугаар сарын 24-нд "Домэйн нэрийн маргаан шийдвэрлэх нэгдсэн удирдамжийн дүрэм"-ийг гаргасан байна. <http://arbitr.wipo.int> хаягаар холбогдох мэдээллийг үзнэ үү.

⁴³ <http://ecommerce.wipo.int/agenda/index.html> хаягаар үзнэ үү.

⁴⁴ Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас гаргасан "Цахим зах зээлд хэрэглэгчийн эрх ашиг хамгаалах нь", ЭЗХАХБ-ын товхимол, 1998 оны 9 дүгээр сарын 28-ны дугаар DSTI/CP(98) 13Rev. 2.

⁴⁵ Европын Холбооны одоогийн байгаа хэрэглэгчийн эрх ашиг хамгаалах талын хууль тогтоомж нь ерөнхийдөө цахим худалдаанд үйлчилдэг бөгөөд бараа, үйлчилгээний бизнес харилцаа (зар сурталчилгаа, маркетинг), гэрээний (болон гэрээ байгуулахаас өмнөх) мэдээлэл, мэдээллийг ил тод болгох, гэрээ хэлцэл байгуулах, төлбөр, хүргэлт, баталгаа, борлуулалтын дараах засвар, үйлчилгээ, цаашилбал, гомдол барагдуулах зэрэг компани, хэрэглэгч хоорондын бизнесийн харилцааны бүхий л үе шатыг хамаарч байдаг.



худалдааны татварын тогтолцоо, түүнийг дэмжих захиргааны зохицуулалтыг нэвтрүүлж хэрэгжүүлэх нь ЭЗХАХБ-ын Төсвийн асуудал эрхэлсэн хорооны тэргүүлэх чиглэлийн асуудал юм. Төрийн зүгээс уламжлалт бизнесийн хувьд хэрэглэдэг татварын зарчмыг цахим худалдаанд мөн хэрэглэх нь зүйтэй гэсэн ерөнхий нэгдмэл ойлголт байдаг. Энэ хандлага нь цахим худалдааны шинэ захиргааны болон хууль, эрх зүйн зохицуулалтыг хэрэгжүүлэхийг хязгаарлахгүй бөгөөд эдгээр зохицуулалтыг одоогийн байгаа татварын зарчмуудыг хэрэгжүүлэхэд ашиглаж, цахим худалдаанд ялгаварчилсан татвар ногдуулахгүй байх шаардлагатай.⁴⁶

Цахим худалдааны орлогоос олон улсын татвар хураах шалгуур, олон улсын татварын тогтолцооны дэглэм ерөнхийдөө хоёр хүчин зүйлд суурилдаг: 1. Нутаг дэвсгэр (аливаа нэг улсын оршин суугчийн дэлхийн зах зээлээс олсон орлогоос татвар авах) 2. Эх сурвалж (аль улсаас орлого орсон тэр улс нь татвар авах)

Энэхүү хоёр татварын дэглэм давхар татварт хүргэж болзошгүй байдаг.

А. Хэрэгжих боломжтой шалгуур: Таарч тохирох байдал нь учир дутагдалтай болсон үед хэрэгжих боломжтой шалгуурыг удирдлага болгодог:

1. Орлогын хуваарилалт- Интернэт дээр ажиллаж олсон орлогыг “худалдааны” болон “үйлчилгээний” гэсэн 2 ойлголтоор ангилан авч үздэг.

2. Эх сурвалжийн журам: орлого олсон бол үнэнчээр татвар төлөх ёстой ба аль нутаг дэвсгэрийн татварын тогтолцоонд хамаарч байна вэ гэдгийг эх сурвалжийн журмаар шалгах ёстой.

3. Тогтоох байнгын үйл ажиллагаа: бүтээгдэхүүн үйлчилгээ дэлхийн хаана ч худалдагдаж болно харин татвар хураах асуудал бараг боломжгүй болдог.

4. Оршин сууж буй хаяг: цахим худалдаа эрхлэж буй компани бодитоор хаана оршин байдаг эсэх нь тодорхойгүй учраас оршин суугаа нутаг дэвсгэрийн нутаг дэвсгэрийг тогтоох боломж байдаггүй.

5. Биелэлт: цахим худалдааны глобал дүрэмд цахим худалдаанаас олсон орлогоос аль нэг улс татвар хураана гэдэг бэрхшээлтэй асуудал хэмээн тусгагдсан байна.

Б. Заавал байх ёстой шалгуур

Заавал байх ёстой шалгуур нь цахим худалдаанаас олсон орлогоос татвар хураах зохистой дэглэм мөн үү гэдгийг тогтооно. Энэхүү шалгуур нь цахим худалдаа эрхэлж татвар төлөгч, цахим бус худалдаа эрхэлж татвар

⁴⁶ ЭЗХАХБ-ын Сайд нарын бага хуралд танилцуулсан “Цахим худалдаа: Татварын тогтолцооны нөхцөл” сэдэвт тайланг үзнэ үү. “Хил хязгааргүй ертөнц: Дэлхий дахины цахим худалдааны боломжийг ашиглах нь” бүлэг, Оттава хот, 1999 оны 10 дугаар сарын 8.



төлөгч хэн бүхэнд ижил тэгш байна. Цахим худалдаанд олон улсын татварын дэглэм тогтоох нь эдийн засгийн үр ашигтай байдлыг бууруулдаг.

В.Хүлээн зөвшөөрөхүйц шалгуур: ерөнхий татварын дэглэм тогтоож олон улсын түвшинд тохиролцох боломжтой.

Өгөгдөл, мэдээллийн хамгаалалт

Өгөгдөл цуглуулах, түүнийг боловсруулах нь цахим ертөнцийн салшгүй хэсэг. Өгөгдөл боловсруулах нь ашиг тустай байдаг ч интернетийн орчин дахь үйл ажиллагааг араас нь дагаж мөрдөх хэрэглэгчийн тухай нарийвчилсан намтарыг нь гаргаж авах, хувийн нууцад халтай цахим гүйлгээ хийх бололцоог нээж өгдөг. ЭЗХАХБ хувийн хэвшилтэй зөвшилцөн дэлхийн дахины цахим сүлжээтэй холбоотойгоор ЭЗХАХБ-ын 1980 оны Хувийн нууц, хил дамжсан хувийн мэдээллийн урсгалыг хамгаалах удирдамжийн хувийн нууцыг хамгаалах үндсэн зарчмаас үүдэлтэй тодорхой хэдэн асуудлуудыг авч үзэх болсон. Өнөөгийн интернетчлэгдсэн ертөнцөд дээрх удирдамжийг үр дүнтэй хэрэгжүүлэх нь цахим худалдаанд итгэх итгэлийг бэхжүүлэхэд тулгарах өөр нэгэн асуудал юм.⁴⁷

Худалдаатай холбоотой асуудал

Хэдийгээр интернетээр худалдан авч, захиалагчид биет байдлаараа хүргэгддэг барааны хувьд одоогийн байгаа ДХБ-ын барааны худалдаанд баримталж буй дүрэм журам үйлчлэх боловч интернетээр цахим мэдээллийн хэлбэрээр хүргэгддэг барааны хувьд байдал нилээд ээдрээтэй болдог. Цахим худалдаа цаашид үлэмж хэмжээгээр өргөжин тэлэх хандлагаас аваад үзэхэд цахим худалдааны ДХБ-ын зарим зүйл заалтыг тодотгох шаардлагатай эсэхийг тодорхойлох зорилгоор ДХБ-аас тавьж буй нөхцөл шаардлага нь цахим арилжааны олон төрөлд хэрхэн үйлчлэх вэ гэдгийг тогтоох нь чухал. Цахим худалдаанд холбогдох бас нэг асуудал бол худалдаатай холбоотой улс орны дотоодын хууль тогтоомжид хамаардаг ДХБ-ын дүрэм журмыг авч үзэх хэрэгтэй болно. Гэвч ДХБ-ын дүрмээс гадуур онцлог нөхцлүүд нь хувийн нууцыг хамгаалах, луйвраас сэргийлэх, нийгмийн ёс суртахууныг хамгаалах зэрэг цахим худалдаатай холбоотой эмзэг асуудалтай холбогдох талтай.⁴⁸

Маргааныг шийдвэрлэх зохистой механизм болон тухайн арилжааны хувьд ямар хууль тогтоомж үйлчлэх вэ гэдгийг урьдчилан мэдэх боломж олгодог тогтолцоог хөгжүүлэх явдал нь цахим худалдааг хөгжүүлэх үндсэн асуудлын голд байна. Одоогийн байгаа маргаан зохицуулах тогтолцоо нь цахим худалдаанаас үүдэлтэй маргааныг шийдвэрлэх шаардлага хангахуйц шийдлийг

⁴⁷ ЭЗХАХБ-ын Цахим худалдааны асуудлаарх зөвлөгөөний тайланг үзнэ үү. х.14. 1999 оны 10 дугаар сарын 12-13, Парис хот.

⁴⁸ Л.Түтил, "Хэрэглэгчдэд зориулсан цахим худалдаа: Дэлхийн зах зээлийг өргөжүүлэх нь – цаашдын замнал", ЭЗХАХБ-ын тайлан №33.



тэр болгон гаргаж өгч чаддаггүй юм.⁴⁹ Энэ нь хэрэглэгчийн хийх арилжаа, гүйлгээнд гарах бөгөөд хэрэглэгч өөрийн оршин буй орны хууль тогтоомжийн дагуу шүүхэд нэхэмжлэл гаргаж болох улс орон⁵⁰ цөөнгүй байна. Энэхүү зохицуулалт нь цахим худалдааны мөн чанараас болоод дэлхий даяар бүтээгдэхүүн, үйчилгээгээ борлуулдаг компаниудын хувьд ашиггүй бөгөөд тэдгээрт дэлхийн аль ч өнцгөөс нэхэмжлэл ирж магадгүй юм. Нөгөө талаас нь харахад хэрэглэгчийн хийсэн бага хэмжээний үний дүнтэй гүйлгээнд арбитрыг маргаан шийдвэрлэх механизм болгож ашиглах нь бас асуудалтай.⁵¹ Цахим орчинд хамаарах хууль, эрх зүй, харьяа газрын эрх зүйн тохиромжтой байдлыг тогтоох зорилгоор Олон улсын хувийн эрх зүйн Гаага дахь хурлын Байнгын хороо Цахим худалдаа, олон улсын хувийн эрх зүйн дугуйн ширээний уулзалтыг 1999 оны 9 дүгээр сард Женев хотноо зохион байгуулжээ.

Фосетт, Харрис болон Бридж нар цахим худалдааны орчинд хэрэглэгдэх эрх зүйн хэм хэмжээний шинэчлэл, түүнийг боловсронгуй болгох 3 загварыг тодорхойлсон байдаг. Эдгээр загварт “Нэгд, шүүхэд хуулийг боловсронгуй болгох үүргийг оногдуулж, ердийн эрх зүйн хэм хэмжээг хэрэгжүүлэх, хоёрт ердийн эрх зүйн хэм хэмжээг төрөлжүүлэх байдлаар хуулийг шинэчлэн өөрчлөх, гуравт цахим худалдааны хэрэгт хэрэглэгдэх эрх зүйн хэм хэмжээний тусгай дэглэмийн төсөл боловсруулах замаар хуулийг шинэчлэх”⁵² зэрэг орно.

Эдгээр гурван загвар нь хил дамнасан цахим худалдааны эрх зүйн ээдрээ төвөгтэй байдлыг зохицуулахад тэр бүр үр өгөөжтэй байж чаддаггүй. Эхний загварын хувьд шүүхэд хуулийг тайлбарлах, хэрэгжүүлэх үүрэг хүлээлгэснээр эргээд тэрээр хуулийг шинэтгэх, хөгжүүлэх, боловсронгуй болгох ажлыг төвөгтэй болгосон. Үүний үр дүнд тодорхойгүй байдал үүсч, хууль хэрэглэх талаар нэгэн хэвийн бус, эргэлзээтэй байдал бий болж байгаа юм. Эрх зүйн шинэтгэл хийх, хуулийг боловсронгуй болгоход хувь нэмрээ оруулахад шүүхийн зүгээс боломж бололцоотой байсан ч гэсэн ийнхүү боловсронгуй болгох ажлыг хийх нь хугацаа шаардсан, үр өгөөж багатай ажил болох магадлал их. Энэ байдал “шүүхэд хуулийг боловсронгуй болгох үүрэг

⁴⁹ “Хаалттай сүлжээнд” бол тухайн асуудалд холбогдох хууль тогтоомж, маргаан шийдвэрлэх арга нь талуудын хооронд байгуулсан “харилцан солилцох хэлцэлд” шийдэл нь байдаг (тухайлбал, Европын эдийн засгийн комиссоос гаргасан Харилцан солилцох загвар хэлцэлийн 7.1 дэхь заалт “Хамаарах хууль тогтоомж”, 7.7 дахь заалт “Маргааныг шийдвэрлэх” зэргийг дурдаж болно). Интернет мэтийн “нээлттэй сүлжээнд” байдал илүү төвөгтэй бөгөөд талуудын тухай мэдээлэл, тэдгээрийн байршил тодорхой бус байх нь чухал хүчин зүйл болдог байна.

⁵⁰ Иргэний болон худалдааны хэрэгт хамаарах харьяа нутгийн эрх зүй, шүүхийн шийдвэр биелүүлэх тухай 1968 оны 9 дүгээр сарын 27-ны Брюсселийн конвенци болон 1988 оны 9 дүгээр сарын 16-ны Луганогийн конвенцийн дагуу энэхүү зарчмыг ашигладаг байна.

⁵¹ Нью-Йоркийн Дээд шүүх 1998 онд авч хэлэлцсэн Бровэр Гэйтвэй 2000 компаний эсрэг шүүх хэрэг (676 N.Y.S. 2d 569, 1998 N.Y. App. Div. Lexis 8872) нь хэрэглэгчийн худалдан авсан тодорхой хэмжээний үнэтэй бараа (2000, эсвэл 3000 ам.доллар)-ны гомдлын нэхэмжлэл байсан ба арбитрын шүүх хэрэг явуулахын тулд арбитрын үйлчилгээ авах барьцаа мөнгөний хэмжээ нэхэмжлэл болоод гүйлгээний дүнгээс өөрөөс нь илүү болсон тул байгаа Дээд шүүх Олон улсын худалдааны арбитрыг оролцуулах нь хэт даварсан зүйл болно.

⁵² J.J. FAWCETT ET AL., INTERNATIONAL SALE OF GOODS IN THE CONFLICT OF LAWS 589 (Oxford University Press 2005)



ногдуулсан”⁵³ АНУ-ын жишиг эрх зүйд маш сайн туссаныг харуулах бөгөөд бизнесээс хэрэглэгч рүү чиглэсэн харилцаан дахь цахим худалдааны асуудлуудыг дээд шүүхээс тогтоосон жишиг эрх зүйгээс ангид байдлаар шийдвэрлэхдээ шүүх бүр янз бүрийн хандлага баримталж улмаар урьдчилан тааварлаж болохуйц байх тэр зарчим үгүйсгэгдэнэ. Гуравдахь загвар нь “цахим худалдаатай холбоотой хэрэг маргаанд хэрэглэгдэх эрх зүйн хэм хэмжээний тусгай дэглэм”⁵⁴-ийн төслийг санал болгодог. Энэ загварын хувьд тулгарч буй бэрхшээлтэй асуудал бол харилцаа холбоонд гарч буй шинэ технологиудыг цахим худалдаанд ашиглах боломжгүй байдалд хүргэдэгт оршино. Эрх зүйн шинэ дэглэмийг бий болгох нь хялбар зохицуулалт байх боловч түүний хөгжил нь технологийн үсрэнгүй хөгжлийг гүйцэхгүй, түүний ард байсаар байх болно. Нэмж хэлэхэд, интернэттэй холбоотойгоор бий болж буй технологийн нарийн төвөгтэй, үсрэнгүй хөгжиж байгаа дэвшлийг гүйцэн интернэт орчинг зохицуулах, харьяаллыг тогтоох, хэрэглэх хуулийн асуудлыг шийдвэрлэх зэрэг нь үнэндээ боломжгүй бас маш хэцүү ажил гэдэг нь ойлгомжтой.

2.2. Холбогдох хууль тогтоомж ба маргаан шийдвэрлэх үйл явц

Өмнөх бүлэгт цахим худалдаатай холбоотой зарим асуудал, тэр дундаа хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тал дээр талууд зөвшилцөлд хүрч чадаагүйн улмаас олон улсын түвшинд хийгдсэн гэрээ, конвенцууд зарим улс орны дэмжлэгийг хүлээгээгүй талаар дурьдсан. Хэрэгцээ нь улам өсч буй цахим худалдааны хувьд хэрэглэгчтэй байгуулах гэрээнд хэрэглэх хууль болон маргаан шийдэх шүүхийн харьяаллын асуудлыг тусгасан 7 дугаар зүйлийн талаарх хэлэлцээр өнөөх сөрөг байдлыг дахиж үүсгэв. Учир нь Европын улс, орнууд хэрэглэгчийн эрх ашгийг илүүд үздэг систем ба АНУ-ын бизнес эрхлэгч аж ахуйн нэгжүүдийн эрх ашгийг илүүд үзэж хэрэглэгчтэй байгуулж буй гэрээний асуудалд ханддаг байдал нь үл ойлголцлын үндэс болж байв. 2001 онд болсон бага хурлын дараа АНУ-ын зүгээс маргаан гарахаас өмнө хэрэглэх хууль, маргаан шийдүүлэх харьяаллын асуудлаа сонгож, үүнийг хэрэглэгчтэй хэлэлцээр хийхгүй шууд гарын үсэг зурдаг гэрээний хувьд заавал биелэгдэх шинжтэй байх ёстой гэх заалтын талаар санаа зовниж буйгаа илэрхийлсэн. Урд засгийн эрхийг барьж байсан Клинтонь засаг захиргааны хариуцлагатай албан тушаалтан Барбара С Уэлбэрри өгүүлэхдээ “Европын улс, орнуудад тогтсон эрх зүйн уламжлал ёсоор бол гэрээнд юу гэж зааснаас үл хамааран хэрэглэгч нь маргаанаа өөрийн оршин байгаа газрын шүүхээр шийдвэрлүүлэхийг зөвшөөрдөг. Гэтэл дэлхийн аль ч өнцөг булангаас хэн ч чөлөөтэй нэвтрэх боломжтой, онцгой мөн чанартай бизнес хийж буй АНУ-ын интернэтээр бизнес

⁵³ Хуо Шу И (2012№2-37) *Хил дамнаж хэрэглэгчтэй байгуулсан цахим хэлбэр бүхий гэрээний маргаанд шүүхийн харьяаллыг нэгдмэл байдлаар тогтоох боломж*, (орч Мөнхтуяа. Н), Хууль дээдлэх ёс сэтгүүл, 35-40 дэх тал

⁵⁴ *Мөн тэнд*



эрхлэгчдийн хувьд дээрх уламжлал асуудал дагуулдаг.”⁵⁵Мэдээж хэрэг “хэрэглэгчийн эрх ашгийг” илүүтэй хамгаалах асуудлыг онцолдог Европын улс орнуудын хувьд энэхүү хамгаалалтын түвшинг бууруулах нь тааламжтай санагдахгүй нь тодорхой, энэ тухай өмнө хийгдэж байсан Оттавагийн уулзалтын⁵⁶ үед ч дурдагдаж байсан.⁵⁷ Гэхдээ 2001 онд хийгдсэн төсөл бүхэлдээ нуран унаагүй, хэлэлцээрт оролцсон улс гүрнүүд нэг асуудалд санал нэгдсэн. “Хэрэв аж ахуйн нэгжүүд хэрэглэгчийн байнга оршин суудаг улсын хуулийг хэрэглэгчтэй байгуулсан гэрээнд хэрэглэхээс татгалзсан бол хэрэглэгчийн өөрийн улсын шүүхээр асуудлыг шийдвэрлүүлэх боломжгүй” гэдэг дээр нэгдмэл байр суурьтай болсон. Хил дамнасан цахим худалдаа эрхлэх сонирхолтой худалдагч талын хувьд энэ заалт ихээхэн үр ашигтай байсан гэдгийг дурдах нь зүйтэй. Энэ нь зөвхөн өөрийн улсын нутаг дэвсгэрт бизнес явуулж байснаа олон улсын түвшинд бизнесээ өргөжүүлэх сонирхолтой, эрх зүйн тодорхой байдалтай, аж ахуй эрхлэгчдийг дэмжсэн заалт болж чадсан. Мөн түүнчлэн гадаадын худалдагчдаас онлайн хэлбэрээр бараа бүтээгдэхүүн авах боломжийг хэрэглэгчдэд бүрдүүлснээрээ чадсанаараа замбараагүй, баталгаагүй байдал бий болсон. Тухайлбал, хэрэв Францад байгаа хэрэглэгч онлайнар Америкт байгаа худалдагчаас бараа худалдан авлаа гэж үзье. Энэ тохиолдолд Гаагийн конвенцийн дагуу уг хэрэглэгч маргаан гарсан тохиодолд түүнийг шийдвэрлүүлэхээр Францад нэхэмжлэл гаргах баталгаа байхгүй. Хэрэглэгчийн хувьд байгуулж буй гэрээнд маргаан гарахаас өмнө хэлэлцэх эрхгүйгээр маргаан шийдвэрлэх шүүхийн харьяаллыг тогтоосон нь учирч буй бэрхшээлүүд дотроос хамгийн томоохон нь юм. Өөр нэг бэрхшээл нь тухайн цахим хуудас ажиллуулагчид “зайлшгүй шаардлагатай арга хэмжээ авсан”⁵⁸ гэдгийг ямар хэмжээгээр, ямар байдлаар тодорхойлох вэ гэсэн асуудал. Бүр тодруулбал, бараа, бүтээгдэхүүнийхээ сурталчилгаа, үзүүлж буй үйлчилгээгээ өөрийн хамаарах улсын хэл дээр танилцуулах нь шаардлагатай арга хэмжээ авч буйг харуулах хангалттай байдал мөн үү, хэрэглэгч маргаанаа шийдвэрлүүлэх шүүхээ гэрээ байгуулахаас өмнө сонгох, бизнес эрхлэгчийн хувьд ашиггүй өөр улсын шүүхийг сонгохоос хамгаалах зэргийг зарим технологийн дэвшлийн туслалцаатай шийдвэрлэх үү гэдэгт АНУ болон Европын улс орнуудын хувьд маргаан шийдвэрлүүлэх шүүхээ сонгох, түүний харьяаллыг тогтоох асуудал дээр зарчмын хувьд зөрүүтэй байдал байсаар байна.

Олон улсын практикт ADR (alternative dispute resolution) буюу маргаан шийдвэрлэх сонголтот аргууд гэсэн нэр томъёог хэрэглэж эхэлсээр багагүй

⁵⁵ Anandashankar Mazumdar. Jurisdiction Diplomatic Conference Draws Out Problems Implicated by Proposed Jurisdiction Treaty. BNA - <http://www.cptech.org/ecom/jurisdiction/hague.html> - (сүүлд нэвтэрсэн огноо 2012.06.07)

⁵⁶ ELECTRONIC COMMERCE AND INTERNATIONAL JURISDICTION Ottawa, 2000.02.28-ноос 2000.01.03 хүртэл (<http://www.cptech.org/ecom/hague/ottawa2000sum.pdf> - сүүлд нэвтэрсэн огноо 01/25/2010)

⁵⁷ James Love. Hague Diplomatic Conference ends, Badly for now. (2001.06.20) (АНУ болон Европт хэрэглэгчтэй байгуулсан гэрээг хэрхэн зохицуулсан байдаг талаар дурдсан.)

⁵⁸ Summary of the Outcome of the Discussion in Commission II of the First Part of the Diplomatic Conference 6 – 20 June 2001 Interim Text



хугацаа өнгөрсөн. Нийгмийн харилцаа өргөжин, эдийн засгийн харилцаа гүнзгийрэхийн хэрээр маргааны төрөл олширч түүнийг шийдвэрлэдэг аргууд улам олон янз болсоор байна. Маргаан шийдвэрлэх үндсэн арга бол шүүхээр маргаанаа шийдвэрлүүлэх явдал байдаг, харин маргаан шийдвэрлэх сонголтот аргууд гэдэгт шүүхээр бус, шүүхээс гадна түүнтэй зэрэгцэн оршиж байдаг тогтолцоонууд бөгөөд маргалдаж буй талуудын сонголтын үндсэн дээр хэрэглэдэг аргуудыг хэлж байгаа юм. Үүний хамгийн түгээмэл жишээ бол арбитраар маргаанаа шийдвэрлүүлэх арга. Сүүлийн үед маргаан шийдвэрлэхдээ зуучлалын аргыг хэрэглэх явдлыг хөгжүүлэх, энэ байдлыг дэмжихэд дэлхий даяар анхаарал хандуулж эхэлсэн. Цахим худалдааны хувьд ADR гэхээс илүүтэй ODR буюу онлайнаар маргаан шийдвэрлэх аргын тухай илүүтэй сонирхох болсон. Мөн түүнчлэн маш олон худалдагч өөрт ашигтайгаар шийдвэрлэх хуулиа гэрээ байгуулахаасаа өмнө сонгочихсон байдаг байхад худалдан авагч уг гэрээнд давуу байдлыг олж авч чадахгүй байх нь бий. Үүнээс улбаалж шударга бус хэлэлцээрийн тухай яригддаг. Тийм учраас нэгэнт алдах алдагдлаас арай бага алдагдал хүлээх боломжит хууль худалдан авагчийн хувьд юу байж болох вэ гэдэг нь маш чухал. Иймээс ч цахим худалдааны маргааныг шүүхийн танхимд шийдвэрлэх нь учир дутагдалтай. Тиймээс цахим худалдаа өсч буй өнөө үед цаг хугацаа хэмнэх үүднээс харилцан буулт хийх арга замыг эрэлхийлэх нь илүү зардалд хэмнэлттэй, оновчтой маргаан шийдвэрлэх арга зам болно. Уг шийдлийг ODR буюу онлайнаар маргаан шийдвэрлэх арга гэдэг. Үр нөлөөтэй байдал түүн дээр нэмээд зардлын бууралт энэ бол маргааныг шийдвэрлэх боломжит хувилбар юм. Яагаад ODR үр нөлөөтэй вэ? Интернэтийн илүү их хэрэглээ нь улам олон хэлцэл хийх боломж олгож, улмаар үүнээс үүдэлтэй онлайн хэрэг маргаан ихээр гарах болно. Тиймээс маргаан гарэх нөхцөл боломжийг бууруулахын тулд цахим худалдаанд тулгарч буй бизнесийн тодорхой бус байдлыг арилгах хэрэгтэй. Шүүхийн аргаар цахим худалдаатай холбоотой маргаан шийдвэрлэх нь тийм ч тохиромжтой больж хэтэрхий их зардал, их хугацаа шаардах болсон байна. Интернэтийн хэрэглээ эрчимтэй өсөж, цахим худалдаа маш хурдтай нэмэгдэж байна. Эдгээр хүчин зүйлүүдийг дагаад шуурхай байх, эдийн засгийн чадавхитай байх, хүлээн авах боломжтой байх зэрэг асуудлыг хөндөх шаардлага нэмэгдсээр байна.

Дүгнэлт

Дахин зохицуулалт хийгдэж байгаа, нээлттэй бодлого (харилцаа холбоо, Интернетэд нэвтрэх боломжоор хангадаг, холбогдох үйлчилгээтэй) баримталж байгаа орнуудад бусад орнуудыгаа бодвол мэдээллийн дэд бүтцийг тэлэх, нэвтрэх үнийг бууруулах, цахим худалдааг дэмжих тал дээр хамаагүй ахицтай байгаа бөгөөд Засгийн газар нь цахим худалдааг (илүү мэдээлэл, мэдээллийн технологийн) бий болгоход гол хариуцлага хүлээхгүй гэж үзэх нь буруу үзэл, харин ч нийт хүн амд ялангуяа хөдөө, орон нутагт эдийн засгийн үр өгөөж, нийгмийн байдлыг сайжруулахад чухал үүрэгтэй оролцоно.



Хэрвээ үндэсний хэмжээнд цахим худалдааг урамшуулах үйл ажиллагаа явуулж байгаа бол энэ нь холбогдох газрууд, улсын болон хувийн салбарынханд ч чухал бөгөөд тэдгээрийн хүчин чармайлт нь орон нутгийн “цахим худалдааны соёл”-ыг бий болгоход чиглэгдэх ёстой. Эдийн засаг дахь холбогдох бүх бүрэлдэхүүн хэсгүүдийг оролцуулах (мэдээллийн өргөн үйл ажиллагаа, илүү уламжлалт хэсгүүдийг ч оруулаад), түүнчлэн орон нутгийн санаачлагууд, санал бодлыг урамшуулах нь энэхүү үйл ажиллагааны ач холбогдол, тогтвортой байдлын хамгийн чухал нөхцөл юм.

Хил дамнасан шинжтэй хэрэглэгчтэй байгуулсан гэрээний шүүхийн харьяаллын асуудлыг уялдуулах ажил амаргүй. Бизнесээс хэрэглэгч рүү чиглэсэн (B2C) харилцаан дахь цахим худалдааны өсөлтийг дэмжих чармайлт гаргахдаа дэлхийн улс орнууд гол нь хэрэглэгчдийн сэтгэл ханамжийг бий болгосон, итгэл хүлээсэн, хил дамнасан тоон систем бүхий хэлцлийг зохицуулах уян хатан, нэгдмэл багц хэм хэмжээг бий болгон батлах зайлшгүй шаардлагатай байгаа гэдгийг ойлгосон. Нэг талаас авч үзвэл аж ахуйн нэгжүүд тэр дундаа вэб хуудас ашиглан үйл ажиллагаагаа сурталчлан явуулдаг жижиг дунд бизнес эрхлэгчдийн хувьд дэлхийн аль нэг өнцөг булангаас уг вэб хуудас руу нь нэвтрэх боломжтой байгаагийн төлөө бүх улс орны шүүхэд дуудагдан маргаан шийдвэрлүүлэх нь боломжгүй бөгөөд ийм байдалд хүргэхгүй байх баталгаа хэрэгтэй байгаа юм. Нөгөө талаас хэлэлцээ хийхэд давуу биш байр суурьтай байдаг хэрэглэгчдийн хувьд аливаа нэг маргаан гарахад уг маргаанаа шийдвэрлүүлэх шүүхийн харьяалал нь тэдний хувьд тодорхой байх шаардлагатай. Шүүхийн практикт интернетийн үйл ажиллагаанд хамааралтай хэрэг, маргааныг шүүхээс шийдвэрлэж байгаа олон жилийн туршлагын үр дүнд Америкийн Нэгдсэн Улс дахь хил дамнасан цахим харилцааг зохицуулах хэм хэмжээг бий болгосон. Харин Европын улс, орнуудын хувьд эрх зүйн ялгаатай зохицуулалт бүхий хууль тогтоомжуудыг шинэчлэн өөрчлөх болон өөр өөр улс үндэстний эрх зүйн ялгаатай хэм хэмжээнүүдийг нийцүүлэх оролдлого хийж цахим харилцаанд дагаж мөрдөх хэм хэмжээг бий болгох арга хэмжээ авдаг. Бизнесээс хэрэглэгч рүү чиглэсэн (B2C) харилцаан дахь цахим худалдаатай холбоотой маргааныг шийдвэрлэх шүүхийн харьяаллыг үндэстэн дамнасан түвшинд тогтоох асуудлыг зохицуулах тал дээр Европын арга нь илүү үр дүнтэй байна. Ямар нэг төрөлжүүлсэн хууль тогтоомжийг баримтлахгүйгээр шүүхийн удирдлага дор тухайн нэг хэрэгт гол анхаарал хандуулж, технологийн тодорхой шийдлийг хүлээн зөвшөөрсөн арга зам хэрэглэх, дээд шүүхээс жишиг тогтоох зэрэг байдал нь хууль зүйн хувьд тодорхой байдал, эрх зүйн орчинг урьдчилан харах бололцоог тодорхойгүй, баталгаагүй болгож, хэрэглэгчдийг хамгаалалтгүй орхидог.

Цахим худалдаатай холбоотой маргаан зохицуулах сүүлийн үеийн шинэлэг зохицуулалт бол шүүхийн бус маргаан шийдвэрлэх сонголтот аргууд буюу ADR. Түүнчлэн онлайнаар маргаан шийдвэрлэх ODR арга байдгийн талаар тус бүлэгт товч авч үзсэн болно.



ГУРАВ. ЦАХИМ ХУДАЛДААГ ҮНДЭСНИЙ ЭРХ ЗҮЙГЭЭР ЗОХИЦУУЛСАН БАЙДАЛ

3.1. Хөгжингүй орнуудад цахим худалдаа зохицуулах туршлага, жишээ

Цахим худалдааг хариуцаж ажиллах Ажлын хэсэг байгуулах эсвэл зохицуулалтыг хийхдээ улс төрийн шууд нөлөөний хүрээнд (АНУ-д Ира Магазинер, Францад Франсиз Лоренц) эсвэл тусгай төрлийн институтын хүрээнд (Канад) үүсгэдэг байна. Үүнийг Канад зэрэг зарим орны жишээн дээр, түүнчлэн Ирланд, Венесуэл, Тунис, Перу, Шри Ланка, Өмнөд Африк зэрэг улсуудын тэргүүн туршлага, бодлого зохицуулалт, хөгжүүлэх санал санаачлага, баталж мөрдсөн хууль тогтоомжийн талаар судаллаа.

Канад

Цахим худалдаанд Канад Улс нь төр, хувийн хэвшлийн харилцааны хүрээнд үндэслэсэн стратегийг дагаж мөрдсөөр иржээ. Хувийн салбар нь хөгжлийн гол хөдөлгөгч хүч бөгөөд цахим худалдааны хэрэглээг бий болгодог, харин Засгийн газар нь хувийн салбарыг а) цахим худалдааг дэмжихүйц, мэдрэмжтэй дотоодын орчинг бий болгох бодлогоор хангах; б) бусад Засгийн газрын байгууллагууд, олон улсын байгууллагуудтай хамтран мэдээллийн уялдаа холбоог хангасан, загвар хийж болохуйц дэлхийн хэмжээний дүрэм журмын тогтолцоог бий болгох; в) шинэ технологиин загвар хэрэглэгч болох, цахим худалдааны давуу талыг үзүүлэх, бизнесийн болон хэрэглэгчдийн хооронд итгэх итгэл бий болгох тал дээр чиглэл үзүүлэх замаар дэмжинэ.

Уг стратегид Канадын Засгийн газар дараах 4 тэргүүлэх чиглэлийг тодорхойлон гаргасан. Үүнд:

- а/ Хувь хүний мэдээлэл, хэрэглэгчийг хамгаалах болон ажил гүйлгээний аюулгүй байдлыг хангах замаар дижитал эдийн засагт итгэх итгэлийг бий болгох;
- б/ Бизнесийн байгууллага болон Засгийн газрын ажил гүйлгээг хэрхэн явуулах талаар дүрэм боловсруулах;
- в/ Сүлжээнд нэвтрэх боломж, хүртээмжтэй байдал, нээлттэй стандарт зэргийг оролцуулсан мэдээллийн хүчтэй дэд бүтцийг бий болгох;
- г/ Цахим худалдааны бий болгох боломжуудын талаар мэдлэгийг нэмэгдүүлэх, чадварыг хөгжүүлэх, Засгийн газар загвар хэрэглэгч болж манлайлах.

Цахим худалдааны чиглэлээр Канад хэд хэдэн төрлийн онцгой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн. Аюулгүй байдлыг хамгаалах хүрээнд, 1998 онд криптографийн (нууц бичээс тайлалт) хэлэлцүүлгийн баримт бичгийг



гаргаж, тус улсын криптографийн бодлогыг тус улсын цахим худалдаанд манлайлагч болно гэсэн зорилтдоо нийлүүлэн шинэчилж, сайжруулалтыг хийсэн.

Түүнчлэн 1998 онд хувь хүний мэдээллийг олж авах, хэрэглэгчийн эрхийг хамгаалах зорилгоор хувийн салбарын мэдээллийн нууцлалын талаарх хууль эрх зүйн орчныг санаачилж, хувийн мэдээллийг цуглуулах, хэрэглэх зохицуулалтыг бий болгож чадсан. Засгийн газар нь нууцлалыг нэмэгдүүлэх зорилгоор криптограф, хамгаалалтын бүрээс, хана, нууцлалын хэрэгслүүдийг бий болгодог технологийн хөгжлийг дэмжиж урамшуулсаар байна. Олон нийтийг нууцлалын асуудлаар сургах, боловсруулах чиглэлээр арга хэмжээ авсан.

Хэрэглэгчид, бизнесийн холбоод, Засгийн газраас бүрдсэн Хэрэглэгчдийн болон Цахим худалдааны Ажлын хэсэг байгуулж цахим худалдааны явцад хэрэглэгчийг хэрхэн хамгаалах талаар удирдамж гаргасан. Мөн Засгийн газар цахим худалдааны үед хэрэглэгчийг хамгаалах чиглэлээр хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан.

Цаасгүй ажил гүйлгээний асуудлыг хөндөн Канад Улс цахим харилцааг ашиглахыг хүлээн зөвшөөрсөн ерөнхий заалтуудыг боловсруулсан байгууллагуудад цахим баримт бичгийн хуулийг боловсруулсан. Цаасан баримт бичгийг ашиглах одоогийн байгаа хуулийг цахим худалдаанд нийцүүлэн нэмэлт өөрчлөлтийг ч хийж байна. Засгийн газар өөр бусад төрлийн цахим худалдаатай асуудлуудад мөн анхаарлаа хандуулж эхэлсэн. Жишээ нь: Интернеттэй холбогдох өр төлбөрийн судалгааг хийх; “Цахим худалдаа болон Канадын Татварын удирдлага” тайланг гаргах; цахим худалдаанаас гарах гаалийн татварын талаар ДХБ-д санал зөвлөмж бэлтгэх; үндэсний хэмжээний Оюуны Өмчийн хууль тогтоомжийг олон улсын үүргийнхээ дагуу нэмэлт өөрчлөлт оруулж, шинэчлэх; Канадын домайн-нэрний системийг шинэчлэх; Канадын Өрсөлдөөний хууль хүчин төгөлдөр болсноор өмч эзэмшигчдэд тэдгээрийн эрх хэрхэн өөрчлөгдөж болох, түүнийг хэрхэн ойлгох талаар удирдамж боловсруулах.

Мэдээллийн дэд бүтцийн хувьд, Канадын Засгийн газар нь зах зээлийг чөлөөлөх бодлогыг боловсруулан хөрөнгө оруулалт, шинэ санаачлагыг дэмжих хэрэгсэл болгосон. Мөн институтууд болон олон нийтийн нийгэмлэгүүдэд судалгааны сүлжээ, Интернетэд нэвтрэх боломжийг олгосон.

Эцэст нь хэлэхэд, цахим худалдааны давуу талыг харуулахад гол үүрэг гүйцэтгэхийн тулд бараа үйлчилгээг худалдан авах, цахим хэрэгслээр засгийн газрын үйлчилгээг үзүүлэх зэрэг олон тооны төслүүдийг санаачилжээ.



Ирланд

1998 онд Ирланд Улс дэвшилтэт харилцаа холбоо, Интернет, цахим худалдааны салбарт дэлхийн гол төв болно гэсэн зорилтыг биелүүлэх зорилгоор стратегийг боловсруулсан. Энэ чиглэлээр энэхүү стратегид Засгийн газарт зөвлөгөө өгөх үүрэгтэй Харилцаа холбооны Зөвлөх Хороог Ирландын Засгийн газар бий болгосон. Энэ хорооны онцлог нь хувийн болон төрийн байгууллагаас гадаадын мэргэжилтнүүд, шинжээчид оролцсонд оршино.

Уг Хороо нь Засгийн газарт дараах зорилтуудыг дэвшүүлэхийг зөвлөсөн. Үүнд: үр дүнтэй, харилцаа холбооны зах зээлийг маш хурдтай чөлөөлөх, дэлхийн хэмжээний харилцаа холбооны болон Интернет операторуудыг урамшуулах; Ирландыг цахим худалдаагаар дэлхийд манлайлагч болгоход идэвхитэй ажиллах зэрэг асуудал орно.

Дээрх зорилтуудад хүрэхийн тулд уг Хорооноос 4 чиглэлд үйл ажиллагаа явуулах зөвлөмж гаргасан. Энэ нь харилцаа холбооны өрсөлдөөн, интернетд нэвтрэх болон холбогдох, цахим худалдаа, иргэдийн нэвтрэх боломж болон хүний нөөцийг сайжруулах тухай болно.

Хороо нь харилцаа холбооны салбарт өрсөлдөөн бий болгохыг тодорхойлсон. Түүнчлэн цахим худалдааны аюулгүй байдал, түүнд итгэх итгэлийг төрүүлэх үүднээс Ирландад төвтэй цахим худалдаанд оролцдог фирмүүдэд магадлан итгэмжлэлийн тогтолцоог бий болгох; цахим худалдааны бодлогыг хэрэгжүүлэх, цахим худалдааны бэлэн байдлыг босго үзүүлэлтүүдээр хэмжих; цахим худалдааг түгээх зорилгоор засгийн газар манлайллын үүргийг гүйцэтгэн, хэвлэл, мэдээллийг ашиглан вебсайтуудыг бий болгох; мөн засгийн газар-бизнесийн харилцаа холбоон дээр төслүүдийг хэрэгжүүлэхийг мөн санал болгосон.

Эцэст нь дүгнэхэд, цахим худалдааны шинэ төрлийг бий болгоход шаардлагатай мэдээллээр хангах, аж ахуй эрхлэх соёлыг урамшуулах, боловсролын тогтолцоонд компьютерийн мэдлэг, интернетийг нэвтрүүлэхэд онцгой анхаарах зэрэг болно.

3.2. Хөгжиж буй орнуудад цахим худалдаа зохицуулах туршлага, жишээ

Олон тооны хөгжиж буй орнууд цахим худалдааг өөрийн оронд нэмэгдүүлэх төрөл бүрийн санаачлагуудыг авч хэрэгжүүлж байна. Жишээ нь Венесуэл, Тунис, Перу, Шри-Ланка, Өмнөд Африк зэрэг орнуудад туршлагатай жишээнүүд байдаг.



Венесуэл

Төрийн албаны ажилтнууд, хувийн салбарын бизнес эрхлэгчид хамтран Венесуэлд Венесуэлийн Цахим худалдааны Танхим нэртэй байгууллагыг байгуулсан⁵⁹ ба товчоор CAVECOM гэж болно. Энэхүү бие даасан байгууллага нь хэд хэдэн тэргүүлэх чиглэлийн үйл ажиллагаатай. Үүнд: (а) Венесуэлийн үйлдвэрлэл эрхлэгчдийн эрхэлдэг цахим худалдааг дотооддоо болон гадаадад дэмжих, (b) Венесуэл болон гадаад орнуудад цахим худалдааг эдийн засгийн хүлээн зөвшөөрөгдсөн үйл ажиллагаа болгох; (с) цахим худалдааны хөгжлийг өргөжүүлэхийн тулд орон нутагт эрх зүйн болон норматив хэм хэмжээг сайжруулахад дэмжлэг үзүүлэх (d) цахим худалдаатай холбоотой судалгаа, шинжилгээ, сургалтыг сайжруулах (е) цахим худалдаанд оролцох хувийн болон улсын салбарын оролцогч талуудыг үндэсний болон олон улсын түвшинд холбох үүрэг гүйцэтгэн, эдгээр оролцогчдод зориулж ярилцлага, хэлэлцүүлэг зохион байгуулах зэрэг орно.

Тунис

1997 оны 11 дүгээр сарын эхээр Тунисын Засгийн газар Цахим худалдаа болон Цахим мэдээлэл солилцооны Үндэсний Хороог байгуулсан. Хэд хэдэн ажлын хэсгээс бүрдэх уг Хороо нь цахим худалдааны стратеги, дэд бүтцийн хөгжлийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх зорилготой. Ажлын хэсгүүд нь цахим худалдаанаас үүсэх олон талуудыг судалдаг. (эрх зүйн, худалдааны, санхүүгийн, аюулгүй байдлын гэх мэт) Хорооны зөвлөмжүүдийг агуулсан хоёр тайланг Засгийн газарт танилцуулсан. Дээрх зөвлөмжүүдийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж, Тунисд цахим худалдааг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн хэд хэдэн гол шийдвэрүүдийг гаргасан. Тэдгээр нь:

- Экспортын хэмжээг Интернет сүлжээгээр нэмэгдүүлэх мөн цахим худалдааны операторуудын үйл ажиллагааг дэмжих зорилгоор гадаад худалдаатай холбоотой процедуруудыг шинэчлэх;
- Жуулчдад зориулсан бүтээгдэхүүнүүд, гар эдлэл, тодорхой төрлийн бэлэн бүтээгдэхүүн, хөдөө аж ахуй болон аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнүүдийг экспортлоход зориулж нээлттэй виртуаль дэлгүүрүүд, төвүүдийг нээх туршилтын хөтөлбөрийг гүйцэтгэх;
- “мэдлэгийн болон сургалтын стратеги” хүрээнд цахим худалдааны талаар байнгын семинар, сургалтыг зохион байгуулах замаар хэрэгжүүлэх;
- Үндэсний хэмжээний харилцаа холбооны сүлжээг цахим мэдээлэл солилцооны эрэлт, хэрэгцээнд зохицуулан, өгөгдлийг дамжуулах хурд зэрэгтэй уялдуулж дахин боловсруулах, э-мэйл үйлчилгээ болон тээврийн үйлчилгээг нэгэн зэрэг хөгжүүлэхэд ажиллах;

⁵⁹ <http://cavecom-e.org.ve> харна уу – (сүүлд нэвтэрсэн огноо 2012.06.07)



- Энэ үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчныг судлах, ингэснээр Тунисын хуулиуд цахим ажил гүйлгээний шинэ загвартай зохицно, ялангуяа хувь хүний тодорхойлолт (дижитал гарын үсэг болон баримтжуулалт) болон итгэмжлэгдсэн гуравдагч этгээдүүдийг тодорхойлох цахим арга хэрэгслүүдэд эрх зүйн орчинг бий болгох;
- Шинжээчид болон мэргэжилтнүүдээс бүрдсэн байнгын зөвлөлийг бий болгох, ингэснээр эдгээр зөвлөмжүүдийг хэрэгжүүлэхэд хяналт тавьж, бүх оролцогчдын дунд зохицуулалтыг бий болгох.

6 төрлийн шинэ туршилтийн төслүүдийг баталж, үйл ажиллагааг нь эхлүүлсэн. Тэдгээрт Тунисд үйлдвэрлэдэг бүтээгдэхүүнүүдийг борлуулдаг виртуал дэлгүүрүүдийг бий болгох, тухайлбал, гар эдлэл, бүтээгдэхүүн, хувцас хунар, хүнсний зүйлс, жуулчдын хэрэгсэл, зочид буудлын захиалга зэрэг багтаж байдаг. Эдгээр дэлгүүрүүдэд “Тунисын Е-Дэлгүүрүүдийн Төв” вебсайтаар нэвтэрч орох бөгөөд энэ нь VeriSign системийг ашиглан найдвартай кредит картаар үйлчилдэг.

ЦМС төслүүдийг төрөл бүрийн салбарт тухайлбал, банк, нэхмэл эдлэл, харилцаа холбооны салбаруудад хэрэгжүүлж эхэлж байна. ЦМС-ийн гол төслүүдийн нэг нь “Single Batch” төсөл бөгөөд энэ нь гадаад худалдааны процедуруудыг ЦМС Сервер төвийг байгуулах замаар хөнгөвчлөх ба ингэснээр гадаад худалдааны үйл ажиллагааны баримт бичгүүдийг солилцох, төрөл бүрийн агентуудад (худалдааны байгууллагууд, гааль, банкууд, дамжуулан тээвэрлэгчид) орох боломжийг олгодог.

Перу

Эскапортыг урамшуулах Перугийн Зөвлөл (Prompex)⁶⁰-ийн санаачлагаар Перугийн Цахим худалдааны Институт байгуулагдсан бөгөөд (IPCE)⁶¹ олон төрлийн үйл ажиллагааг гүйцэтгэхээр ажиллаж байна. Үүнд:

- Үндэсний болон олон улсын хэмжээний төслүүдэд оролцогч байх, олон улсын байгууллагууд, адил төстэй байгууллагуудтай хамтран ажиллах, дотоодын болон гадаадын санаачлагууд, хөрөнгө оруулалтыг дэмжих, хамтран ажиллах;
- Хууль эрх зүйн болон бусад зохицуулалтыг бий болгох, уялдуулах чиглэлд голлон анхаарах, дотоодын Хуулийн Тогтолцоог уялдуулах талаар зөвлөмж боловсруулах. Энэ чиглэлээр IPCE нь уламжлалт худалдаанд тулгарч байгаа хууль эрх зүйн саад тотгорыг арилгах талаар зөвлөмж боловсруулсан. Үүнийг хийхийн тулд одоогийн байгаа эрх зүйн

⁶⁰ <http://www.prompex.gob.pe> харна уу – (сүүлд нэвтэрсэн огноо 2012.06.07)

⁶¹ <http://www.prompex.gob.pe/ipce.htm> харна уу – (сүүлд нэвтэрсэн огноо 2012.06.07)



зохицуулалтын саад тотгорыг тодорхойлон, мөн дараах үйл ажиллагааг эхлүүлсэн:

-цахим худалдааны хөгжилд саад болох зүйлсээс хамгаалах, залруулах;

-е-худалдааны нягтлан бодох бүртгэлийг хийх, аудитыг гүйцэтгэхэд шаардагдах улсын дүрэм, журмуудыг уялдуулах, боломжит хувилбаруудыг бий болгох;

-дараах чиглэлээр гарч байгаа шинэ санаа, санаачлагыг дэмжих (а) худалдааны чиглэлийн хуулиудыг цахим сүлжээгээр худалдаа хийхэд нийцүүлэх (b) цахим худалдаанд Засгийн газраас зохицуулалтын бус бодлогуудыг боловсруулах, маргааны үед дунджыг зөвлөх; Перугийн Cyber tribunal-ийг бий болгоход дэмжлэг үзүүлэх, Цахим Мэдээлэл Солилцоог сайжруулах үүднээс холбогдох төрийн байгууллагуудад зөвлөмж өгөх, тэдгээрийн хооронд зохицуулалт хийх.

- Цахим маркетингийн стратегыг хийх, цахим маркетинг, харилцан уялдаатай маркетингийн стратегиуд боловсруулах, бизнесийн дугуй ширээний ярилцлага зэргийг зохион байгуулах, дэмжих;
- “үргэлж нээлттэй” ойлголтын хүрээнд үндэсний үйлдвэрлэгчдэд чиглэсэн механизмыг бий болгох; бизнесийн туршлагад үндэслэсэн санаачлагуудыг хэрэглэхийг дэмжих; амжилттай үр дүнг олж авахын тулд бизнесийн түншлэлийг бий болгох;
- Интернетэд суурилсан ажил гүйлгээг дэмжих, цахим ажил гүйлгээг урамшуулах, хил даван гүйцэтгэсэн харилцан хүлээн зөвшөөрөх дижитал эдийн засагт оролцогч талуудын хяналт, хөрвөх чадварыг тодорхойлж чадах механизмыг бий болгох.
- Үндэсний хэмжээний cyber-зуучлагчид, Перугийн цахим брокеруудыг ажиллуулан, зуучлалын үйл ажиллагаануудыг дэмжих, нэмүү өртөг шингэсэн үйлчилгээ (брокер, түншлэл хайх зэрэг) виртуаль зуучлагчдыг судалж, дүн шинжилгээ хийх;
- Е-худалдааны зөв шийдлүүдийг урамшуулах; одоогийн байгаа стандартуудад олон улсын шинэчлэл, өөрчлөлтийг санал болгох, стандартчилалын чиглэлээр олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах; е-худалдааны программ хангамжийн шинэ шийдлүүдийг хөгжүүлэх; шинэ интерактив технологиудыг сонгон туршилт хийх;
- Итгэх итгэлийг төрүүлэх, мэдлэгийг бий болгох, эдийн засгийн тоглогчдын дунд шинэ дижитал даяаршлалын талаар мэдлэгийг бий болгох, е-худалдааны хэрэгсэлүүдэд, үйл явц, сүлжээнд итгэх итгэлийг бий



- болгох, төрийн байгууллагууд, мэдээллийн хэрэгсэлүүд, нэр хүндтэй бренд, компаниудаас цахим худалдааг хэрэглэхэд дэмжлэг авах;
- Нийгмийн үр нөлөө, нийтийн сонирхлыг бий болгох; хувийн нууцлал, оюуны болон аж үйлдвэрлэлийн өмчийн эрх, хэрэглэгчийн эрхийг хамгаалахад зэрэгт анхаарлаа хандуулах; шинэ ажлын байрыг бий болгоход е-худалдааны хувь нэмрийг оруулах;
 - Цахим худалдаанд Испани хэлний хэрэглээг урамшуулах; Интернетэд е-худалдааны хэрэглээнд Испани хэлийг дэмжих, дэлхийд Испани хэлээр ярьдаг орнуудыг татан оруулах;
 - Худалдааны мэдээллийг худалдан авах, сонголттой байдлаар сурталчлахад Интернетийн хэрэглээг урамшуулах, Перуд одоогийн байгаа Интернетэд суурилсан тогтолцоо, сүлжээг е-худалдаанд чиглүүлэх, тэдгээрийн хооронд нэгдмэл байдлыг бий болгох.

Дээр дурьдсан үүргүүдийн үр дүнд, IPCE нь дэлхийн Е-худалдааны хандлагыг байнга судалж, Перу Улсыг үүнд зохицуулах талаар байнга арга хэмжээ авч ажиллана. IPCE нь хагас төрийн байгууллага бөгөөд хувийн аж ахуйн нэгжүүд, орон нутгийн засаг захиргаа, олон улсын шинжээчид энд оролцож ажилладаг.

Шри Ланка

1995 онд Шри Ланкын Худалдаа мэдээллийн сүлжээ (TrandenetSL)⁶² байгуулагдаж, Дотоод болон Гадаад Худалдаа, Хүнсний яамтай хамтран Шри Ланкын Экспортын Хөгжлийн Зөвлөлийн доор (SLEDB) үйл ажиллагаагаа эхлүүлсэн. Энэ байгууллага нь дараах 3 зорилготой. Үүнд: (а) худалдаа, хөрөнгө оруулалтын талаарх хамгийн сүүлийн үеийн мэдээ, мэдээллийг янз бүрийн хэрэглэгчдэд, экспортлогчид, бизнес эрхлэгчид, засгийн газрын байгууллагууд, судлаачид, худалдааны танхимийнханд түгээх, тараах, (b) цахим харилцаа холбооны/Интернетийн үйлчилгээг ялангуяа жижиг, дунд үйлдвэрлэгчдэд тараах (с) Шри Ланкад е-худалдааг олон нийтэд таниулах. Эдгээр зорилтыг хэрэгжүүлэхээр одоогоор Cyber-Trader ажиллаж байна- энэ нь TradenetSL-ийн е-бизнесийн гол хэрэгжүүлэгч, “үйлчилгээний гар” нь юм. Худалдааны талаархи мэдээ, мэдээллийг Cyber Trader-ийн веб серверээр дамжуулан түгээх бөгөөд үүний веб сайтны үйл ажиллагаа нь тухайн компанид шаардлагатай бүхий л хэрэгцээтэй мэдээллийн “нэг цэгийн үйлчилгээ” юм. Үүнд 1750- аас дээш тооны аж ахуйн нэгжийн ерөнхий мэдээлэл, 350 гаруй Шри Ланкын бүтээгдэхүүний талаарх мэдээ, худалдааны статистикийг агуулдаг; мөн худалдааны яармагуудын мэдээлэл, хөрөнгө оруулалт, худалдааны бодлогууд, олон улсын болон дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн бараа бүтээгдэхүүний үнүүд, түүнчлэн EDB-ийн зохион байгуулдаг сургалт, үйл ажиллагааны талаарх

⁶² <http://www.tradenetsl.lk> харна уу – (сүүлд нэвтэрсэн огноо 2012.06.07)



баялаг мэдээллийг багтаадаг. Cyber Trader нь бизнесийн зөвлөлгөө өгдөг бага өртөгтэй үйлчилгээг ч санал болгодог. Экспортлогчид эндээс бизнесийн мэдээллийн мэргэжлийн байгууллагуудын холбогдох хаягийг олж авах боломжтой. Тэдгээр нь бизнесийн худалдааны боломжууд, зорилтот зах зээл дээр болж байгаа үйл явдлууд, бүтээгдэхүүний стандартууд, импортлогч орнуудын хэрэглэдэг зохицуулалт, Олон Улсын Худалдааны Гэрээнүүдэд тулгарч байгаа асуудлууд зэрэг бизнесийн асуудлуудтай холбоотой асуултуудад мэргэжлийн зөвлөгөө өгдөг.

Бизнесийн холбоодын хооронд цахим харилцаа холбоог тогтмол хэрэглэн эмэйл болон Интернет үйлчилгээгээр, жижиг дунд үйлдвэрүүдийг хангах замаар Cyber Trader нь Жижиг Дунд Үйлдвэрүүдийг урамшуулдаг. EDB нь харилцаа холбооны хэрэглээг зөвхөн Коломбоогоор- Шри Ланкийн худалдааны төвөөр хязгаарлахгүй байна. EDB нь зарим гол газруудад Матара, Хамбантота, Галле, Канди, Курунегала зэрэг газарт ЖДҮ-д зориулан харилцаа холбооны үндсэн сургалт явуулдаг бүс нутгийн е-худалдааны төвүүдийг нээсэн. Cyber Trader- ийн үйлчилгээний чухал хэсэг болох веб хуудас нээх, нэт дээр сурталчилгаа байршуулах, компаниудад, бизнесийн байгууллагад зориулан CD ROMs бэлтгэж өгөх үйлчилгээг эрхэлдэг. Cyber Trader-ийн дэмжих үйл ажиллагаа нь зөвхөн компанийн түвшинд ч хязгаарлагддаггүй. Шри Ланка дахь томоохон хэмжээний худалдааны үйл явдлууд, бүс нутгийн болон олон улсын худалдааны яармагууд, өөо бусад худалдааг урамшуулах үйл явдлуудыг веб дээр сурталчилдаг; эдгээр үйл явдлуудад зориулсан CD-ROMs-уудыг гадаад худалдааны танхимаар, олон үндэстний компаниудаар, Шри Ланкын гадаадад ажилладаг байгууллагуудаар түгээдэг.

Цахим худалдааны дэд бүтцийг бий болгох нь Шри Ланкын Засгийн газрын гол тэргүүлэх чиглэл байдаг. Энэ зорилтыг хэрэгжүүлэхийн тулд EDB нь TradenetSL-ээр дамжуулан олон тооны төрийн болон хувийн байгууллагуудтай (Шри Ланкын Гаалийн байгууллага, Шри Ланкын Усан боомтын Газар, Шри Ланкын Хөрөнгө оруулалтын Зөвлөл, Хөлөг онгоцнуудын Агентуудын Цейлоны Холбоо) хамтран техник эдийн засгийн үндэслэлийг хийдэг. Эдгээр нь улс орон даяар өртөг багатай вебэд суурилсан Цахим Мэдээлэл Солилцооны Сүлжээг бий болгоход дэмжлэг үзүүлдэг.

Өмнөд Африк

Сүүлийн хэдэн жилд Өмнөд Африк нь е-худалдааны олон чиглэлд дэвшилт гаргаж байна. Ихэнхдээ хувийн салбарт илүү амжилт гаргаж байна. ISDN зэрэг гар утас болон бусад дэвшилтэт харилцаа холбооны үйлчилгээ маш хурдан тархаж, бизнесийн байгууллагуудад Интернетийг өргөнөөр хэрэглэж байна. Co.za домайн дор 40000 гаран корпорацийн хаягууд бүртгэгдсэн, олон тооны сурталчилгааг URL-ээр хийж, ихэнх телевиз, радио нь өөрсдийн вебсайтай болж, ойролцоогоор 20 төрлийн өдөр тутмын болон долоо хоногийн



сонин нь онлайн хувилбартай байдаг. Цахим банкны үйлчилгээ авах, урьдаас захиалга өгөх, билет авах, гол нэр төрлийн бүтээгдэхүүнийг онлайнаар худалдан авахад орон нутгийн Интернет үйлчилгээгээр авч болно.

Сүүлийн жилүүдэд Засгийн газрын олон байгууллагууд өөрийн харилцаа холбооны технологитой холбоотой бодлого, хөтөлбөрүүдийг боловсруулж байна. Өмнөд Африкийн засгийн газар, Шуудан, Харилцаа Холбоо, Дамжуулалтын Яамны Харилцаа холбооны Газраас (ХХГ) үндэсний хэмжээний мэдээлэл холбооны технологийн талаар баримтлах стратегийг боловсруулж 1998 оны 3 дугаар сард мэдээлэл, харилцаа холбооны технологийн талаар баримтлах үндэсний баримт бичгийг анхлан гаргасан. Уг стратегийн боловсруулалтыг зохицуулахад ХХГ нь Худалдаа, Аж үйлдвэрийн яам, Сангийн яам, Дотоод Хэргийн Яам, Боловсрол, Шинжлэх Ухаан, Технологийн яамдууд болон төрийн үйлчилгээний газруудтай хамтран газар хоорондын төрөл бүрийн уулзалтуудыг хийсэн.

ХХГ нь олон тооны харилцаа холбооны технологийн төслүүд, бодлогын санаачлагуудад оролцдог, эдгээрийг саяхан нэгтгэн “Info.Com 2025” болгож, е-худалдааны хэрэглээг сайжруулах бодлогын талаар олон нийтийн хэлэлцүүлгийг ч хийсэн. Үүний зорилт нь татвар, дижитал гарын үсэг, баталгаажуулалт, хувийн нууцлал, оюуны өмч, нууцлалын зэрэг асуудлуудыг шийдвэрлэх суурь бүтэц, зохицуулалтыг бий болгох явдал байдаг юм. Эдгээр асуудлууд дээр олон тооны ажлын хэсгүүдийг бий болгож, олон нийт, Интернет дээр⁶³ хэлэлцүүлгүүд үргэлжилсэн.

Өнгөрсөн жил смарт картыг нийтэд олгох зорилгоор хувийн салбар, Дотоод хэргийн яам, Тээврийн Яам, Сангийн Яам⁶⁴ болон Эрүүл мэндийн Яам зэрэг холбогдох яамдуудын дунд Хороо байгуулагдаж оролцогч талууд (Банкуудын Зөвлөл) смарт картны нийтлэг хэлбэрийг бий болгох чиглэлээр санамж бичигт гарын үсэг зурсан.

Улсын Интернет Буудлын (PiT) хөгжлийн гол зорилт нь нийтэд зориулж touch-screen, компьютерийн гар, принтер, смарт-карт уншигчдад зориулж “нэг цэгийн дэлгүүр”-ийг бий болгосон. Интернет, эмэйлээр хангахаас гадна олон нийтэд вебээр дамжуулан хувийн салбарын болон засгийн газрын үйлчилгээг авах боломжтой, тухайлбал, баримт бичгүүд, жолооны үнэмлэх, зайны боловсрол, тендер, ажил эрхлэлт, эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээний талаарх бүхий л мэдээллийг авч болно. Шуудангийн үйлчилгээний сүлжээ нь PiT-ийг онлайн дэлгүүр, бусад е-худалдааг хөгжүүлэхэд чухал.

⁶³ Энд зориулсан тусгай веб сайт хийгдсэн <http://www.ecomm-debate.co.za> (сүүлд нэвтэрсэн огноо 2012.06.07)

⁶⁴ <http://www.pit.co.za> харна уу – (сүүлд нэвтэрсэн огноо 2012.06.07)



PiT төсөл нь өнгөрсөн жилд парламентэд танилцуулсан Цагаан номонд багтсан шуудангийн бодлоготой нягт холбоотой. Шуудангийн үндсэн үйлчилгээнд нэвтрэх боломжтой байх нь хүний эрх хэмээн тодорхойлогдож, хөдөө орон нутаг, алслагдсан нутгуудад үйлчилгээг сайжруулахаар засгийн газрын хөтөлбөрт мөн тодорхойлсон. Шинэ Зеландын оператороор хийгддэг олон улсын шуудангийн консорциумтай стратегийн түншлэлтэй байхаар тохиролцсон. Одоогоор 2000 шуудангийн салбаруудыг улам өргөтгөхөөр төлөвлөж, үүнд шуудангийн франзайчингийн системийн хөгжлийг ч багтаажээ.

3.4. Үндэсний түвшинд шийдэгдэх ёстой эрх зүйн зохицуулалтын хүрээ

Ойлгомжтой, оновчтой хууль эрх зүйн орчинтой байх нь цахим худалдаанд итгэх итгэлийг нэмэгдүүлэх, цаашилбал түүний хөгжлийг урамшуулахад чухал үндсэн нөхцөл болно. Хэдийгээр одоогийн байгаа эрх зүйн бүтэц нь цахим худалдаанд ерөнхийдөө ашиглагдаж болох боловч ихэнх үндэсний хэмжээний хууль тогтоомжуудыг цахим систем байхгүй үед боловсруулсан. Одоогийн байгаа цаасан дээр суурилсан зарим эрх зүйн систем нь цахим худалдааг зохицуулах боломжгүй, дэлхийн цахим худалдаанд сөргөөр нөлөөлөх тодорхой бус байдлыг бий болгох талтай эсэх нь Бизнесийнхэн болон хэрэглэгчдийн дунд цахим худалдаанд итгэх итгэлийг нэмэгдүүлж чадах хууль эрх зүйн тааламжтай байдал байгаа эсэхээс ихээхэн хамаарна. Тохиромжтой хууль эрх зүйн орчин чухал гэдгийг хүлээн зөвшөөрснөөр улс орнуудын Засгийн газар цахим худалдаанд нийцсэн хууль эрх зүйг боловсронгуй болгох шинэчлэлийг хийж байна.

Олон улсын эрх зүйн болон зохицуулалтын хөгжил⁶⁵ нь хөгжиж буй орнуудад хэрхэн нөлөөлж байгааг үнэлэх зорилгоор 1999 оны 7 дугаар сард⁶⁶ Женевд НҮБХХХ-ны доор Цахим худалдааны Хууль эрх зүйн талаар шинжээчдийн уулзалтыг зохион байгуулсан. Шинжээчдийн уулзалтаар, ерөнхийдөө одоогийн байгаа ихэнх дүрэм журам, хууль тогтоомж нь цахим худалдаанд хэрэглэж болно гэдгийг хүлээн зөвшөөрсөн боловч одоогийн цаасан дээр суурилсан эрх зүйн тогтолцоо нь цахим худалдааг бүрэн хэрэгжүүлэхэд хангалттай бус, зарим тодорхой бус байдлыг үүсгэж болох талтай гэж үздэг. Ялангуяа аливаа хуулийн “бичигдсэн байх”, “гарын үсэг зурсан”, “анхны хувь” байх гэсэн шаардлагууд нь цахим худалдааны хөгжилд саад учруулах талтай байна. Цахим гарын үсэг болон баталгаажуулалтын хувьд олон улсын хүлээн зөвшөөрөгдсөн эрх зүйн хүрээг бий болгох асуудлыг Шинжээчид илүү онцлон авч үзсэн. Уулзалтын үеэр хөгжиж буй орнуудын хувьд дараах асуудлуудад илүү анхаарлаа төвлөрүүлж байсан:

⁶⁵ Цахим худалдааны талаар чадавхийг бэхжүүлэх Шинжээчдийн Уулзалтын тайлан: Хууль эрх зүйн болон зохицуулалтын хэм хэмжээнүүд, TD/B/COM.3/28, НҮБХХХ-ны 8 дугаар сарын 11-ны өдрийн тайлан “Цахим худалдааны эрх зүйн хэм хэмжээ”, TD/B/COM.3/EM.8/2. 1999 оны 5 дугаар сарын 4

⁶⁶ Цахим худалдааны талаар чадавхийг бэхжүүлэх Шинжээчдийн Уулзалтын тайлан: Хууль эрх зүйн болон зохицуулалтын Хэмжүүрүүд, TD/B/COM.3/28, 1999 оны 8 сарын 11



- Цахим гарын үсэг, дижитал гарын үсэг, гэрчилгээжүүлэх газрыг хүлээн зөвшөөрөх олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн дүрэм журам, удирдамж дутагдалтай;
- Технологийг экспортлоход, ялангуяа төрийн нууцлалын стандарттай холбоотой хязгаарлалтууд гарч байгааг анхаарах;
- Домайн нэрнүүдийг бүртгэхэд олон улсын схемийг дагах;
- Цахим орчинд шаардагдах хууль, эрхзүйд уламжлалт зарчмуудыг хэрэглэхтэй холбогдох асуудлууд;
- Цахим худалдаатай холбоотой хууль эрхзүй, зохицуулалттай холбогдох олон улсын түвшний мэдээллийг түгээх шаардлага, түүнчлэн жижиг дунд үйлдвэрүүдэд зориулан сургалт хийх, боловсрол олгох;
- Хөгжиж буй орнуудад техникийн туслалцаа үзүүлэх, ялангуяа бага хөгжилтэй орнуудад цахим худалдааг нэвтрүүлэх үндэсний хууль тогтоомжийг тохируулах, зохицуулах.

Эдгээр асуудлуудад хандаж Шинжээчдийн Уулзалтаас нь засгийн газрууд болон олон улсын байгууллагууд, НҮБХХХ-д хандаж олон тооны санал зөвлөмжүүдийг⁶⁷ боловсруулсан. Улс орнуудын Засгийн газарт зориулж дараах зөвлөмжүүдийг боловсруулсан:

- Цаасан дээр суурилсан шаардлагууд нь цахим худалдааг хэрэглэхэд саад болж байгаа эсэхийг үнэлэх зорилгоор одоогийн байгаа хууль эрх зүйг нягтлан үзэж, эдгээр хууль тогтоомжуудыг технологи-төвийг сахисан болгож өөрчлөн шаардлагуудыг тодорхойлон, цахим орчинд тэдгээрийн тайлбар, хэрэглээг зөвшөөрөх
- Хууль эрх зүйг шинэчлэх явцдаа, Засгийн газар нь Цахим худалдаанд хэрэглэх UNCITRAL Загвар Хуулийг ашиглах, UNCITRAL-ийн болон бусад байгууллагуудын боловсруулсан цахим худалдаанд авч үздэг бусад хэрэгсэлүүдийг хэрэглэх, энэ нь одоогийн хууль тогтоомжийг уялдуулахад эсвэл шинэ хууль тогтоомж гаргахад суурь нь болдог. Технологийн төвийг сахисан эрх зүйн хүрээнд тодорхой төрлийн технологийг хэрэглэснээс үүдэх хууль эрхзүйн үр дагаварын талаар илүү тодорхой болгоход журам Засгийн газар анхаарах.
- Хөгжилтэй орнуудын Засгийн газар нь хөгжиж буй орнуудад цахим худалдааг нэвтрүүлэхэд технологийн экспортод тавигддаг хязгаарлалтуудыг арилгах тал дээр яаралтай ажиллах шаардлагатай, ялангуяа, улсын нууцлалын систем, холбогдох технологи, компьютерийн системтэй холбоотой саадыг арилгах.
- Хөгжилтэй болон хөгжиж буй орнуудын ялангуяа бүс нутгийн эдийн засгийн бүлэглэлийн гишүүн орнуудын Засгийн газар нь мэдээлэл, харилцаа холбооны технологийн хөгжилтэй холбогдон гарах асуудлыг

⁶⁷ Шинжээчдийн Уулзалтын Тайлан, 32-35 параграфуудыг харна уу.



шийдвэрлэж чадах чадавхиа нэмэгдүүлэх чиглэлээр хамтын ажиллагаа бий болгох. Эдгээр асуудлуудад татварын, гаалийн, оюуны өмчийн, домайн нэрний, компьютерийн хулгайн, Интернет агуулгын зохицуулалт, нууцлал болон мэдээллийг хамгаалах, хэрэглэгчийг хамгаалах, гэрчилгээг баталгаажуулах, итгэмжлэлийн болон стандартчилалын үүрэг гүйцэтгэгч байгууллагын асуудлууд орж байна.

- Хөгжиж буй орнуудын засгийн газраас олон улсын түвшинд хэрэглэгдэх төрөл бүрийн хууль эрх зүйн хэрэгсэлүүдийг хэрхэн бэлтгэх талаарх уулзалт, ярилцлагад оролцож, цахим худалдаа, түүний давуу талууд, ашигтай талуудын талаарх нийтийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх чиглэлээр ажиллаж байна.
- Эцэст нь хэлэхэд, олон улсын байгууллагаад хөгжиж буй орнуудад цахим худалдааг хэрэгжүүлэхэд тэдгээрийн хууль тогтоомжийг шинэчлэх, уялдуулахад тусламж үзүүлэх, түүнчлэн цахим худалдаанд нөлөөлөх хууль эрхзүйн болон зохицуулалтыг хэрхэн хийх талаар сургах, түүний талаар мэдлэгийг дээшлүүлэхэд тусламж дэмжлэг үзүүлж байна.

Цахим худалдааг хөгжүүлснээр үр ашгийг дээшлүүлж, зардал бууруулна. Энэ нь

- ✓ Засгийн газрын хувьд (захиргааны үйл ажиллагаа, тендерийн асуудал)
- ✓ Хувийн сектор болон банкны асуудал (B2B, B2C)

Цахим худалдааны бодит байдал, хөгжиж буй улс орнуудад байгаа нөөц боломж⁶⁸.

Бизнесийн шинэ боломж нөхцөл

- ✓ Шинэ үйл ажиллагаа болон зах зээл
 - o Мэдээлэл болон бүртгэлийн (records) үйл ажиллагаа;
 - o Хэрэглэгчид хандсан үйлчилгээ, телемаркетинг, утасны дуудлагын төвүүд;
 - o Программ хангамжийн хөгжил;
- ✓ Гадаад зах зээлд нэвтрэх боломжийг өсгөх
 - o Интернэтээр экспорт худалдаа хийх;
 - o Жуулчлал.

Цахим худалдаа амжилттай байх технологийн биш хүчин зүйлст:

- ✓ Эдийн засгийн хүчин зүйлс
 - o Эдийн засгийн хөгжил;
 - o Зах зээлийн багтаамж;
 - o Цахим худалдааны бодлого.
- ✓ Институцийн болон нийгмийн хүчин зүйлс

⁶⁸Raising confidence in E-commerce: the legal framework, UNITED NATIONS COMMISSION ON INTERNATIONAL TRADE LAW (UNCITRAL), www.uncitral.com – (сүүлд нэвтэрсэн огноо 2012.02.10)



- o Улс төрийн тогтвортой байдал;
- o Эрх зүйн болон бусад зохицуулалтууд.

Хөгжиж байгаа болон хөгжилтэй улс орны хувьд цахим худалдааг хөгжүүлэхэд анхаарах асуудалд дараах зүйлс орно⁶⁹. Үүнд:

- ✓ Цахилгаан холбооны суурь байх, интернэтэд нэвтрэх анхан шатны боломж нээлттэй байх;
- ✓ Хүний нөөцийг бүрдүүлж чаддаг байх;
- ✓ Үндэсний хэмжээний бодлого болон төлөвлөгөө;
- ✓ Тохиромжтой програм хангамж;
- ✓ Орон нутгийн хэл дээр компьютерийн хэллэг, агуулга орчуулагдаж, хэрэглэж болохуйц байх;
- ✓ Портал сайтуудтай байх;
- ✓ Цахим засаглал – гүйцэтгэх засаглалын үйл ажиллагааг хялбарчилсан байх;
- ✓ Үйлдвэрлэл, аюулгүй байдал, эрүүл мэндийн стандартуудыг тодорхойлсон байх;
- ✓ IT хууль тогтоомжтой байх (цахим-хэлцэл, цахим-гарын үсэг, компьютер ашиглан гэмт хэрэг үйлдэх асуудлыг зохицуулсан байх);
- ✓ Мэдээллийн, системийн, сүлжээний аюулгүй байдал;
- ✓ Сертификатчлах, албан ёсоор зөвшөөрөл олгох асуудал;
- ✓ Бүх нийтээр хэрэглэж болохуйц байх (компанийн хувьд, өрхийн хувьд);
- ✓ IT хүний нөөцийн асуудал;
- ✓ Бүс нутгийн сүлжээ;
- ✓ Либерал байдлаар болон бүс нутгийн хэмжээнд асуудлыг хэлэлцэх боломж;
- ✓ Цахим зах зээл;
- ✓ Цахим хэлбэрээр төлбөр төлөх боломж;
- ✓ Хэрэглэгчийг хамгаалах, нууцлалын асуудал;
- ✓ Хил дамнасан сертификацлал;
- ✓ Оюуны өмчийн эрхийг хамгаалж буй байдал

3.4. Цахим худалдаатай холбоотой Монгол Улсын эрх зүйн зохицуулалт

Цаасан дээр бичсэн бичиг баримтыг гарын үсгээр баталгаажуулсан байх шаардлага нь цахим худалдааны хөгжилд гол саад бэрхшээл болж байна.⁷⁰

⁶⁹ UNCTAD (2003) *E-Commerce and Development Report*, p. 66. 66

⁷⁰ Дэлгэрэнгүйг “Худалдаа явуулахад шаардлагатай элементүүд” нийтлэл, ECE, III дугаар Боть, “Худалдааны бичиг баримтуудыг гарын үсгээс бусад хэлбэрээр баталгаажуулах нь” сэдэвт нийтлэл, ECE/TRADE/200, 86-94 дүгээр хуудас, Мөн түүнчлэн, UNCITRAL материалууд A/CN.9/265, 49-58 дугаар параграф, A/CN.9/933, 50-59 дугаар параграф, A/CN.9/390, 86-89 дугаар параграф, A/CN.9/W6.IV/WP.53, 61-66 дугаар параграфаас үзнэ үү.



Гэсэн хэдий ч цахим худалдааг зохицуулах явдлыг илүүтэй хялбар болгоход чиглэгдсэн, олон улсын түвшинд одоогоор үйлчилж байгаа хууль зүйн шаардлагуудад нийцсэн, эрх зүйн суурь үнэлэмж, үнэ цэнийг гаргаж тавих, хууль зүйн хувьд тодорхой байдлыг бий болгосон цахим худалдааны хуультай болохын тулд улс орнууд эн тэргүүнд цахим гарын үсгийн эрх зүйн зохицуулалтыг хийж өгдөг нийтлэг хэв маяг байна. Манай улсын хувьд ч мөн Цахим гарын үсгийн тухай хуулийг 2011 оны 12 сарын 15-ны өдөр батлан гаргасан билээ.

Монгол Улсын хувьд цахим худалдаа эрхэлдэг www.dalai.mn, www.eshopping.mn, www.tomato.mn зэрэг сайтууд байдаг бол өөрийн блогоор дамжуулан худалдаа эрхэлдэг www.blog.naver.com блог байдаг. Энэ нь Монгол Улсад цахим худалдааны харилцаа үүссэн гэдгийг харуулж байна. Гэвч эдгээр сайтуудын худалдаа, үйлчилгээний үйл ажиллагааг зохицуулсан тусгайлсан хууль, эрх зүйн акт одоогийн байдлаар байхгүй байна. Мөн цахим худалдаа эрхлэгчдийн талаар нэгдсэн бүртгэл, статистик баримт байхгүй, энэ төрлийн харилцаатай холбоотой үүссэн эрүү, иргэн, захиргааны хэрэг маргаан шүүхийн практикт гараагүй байна. Дээрх байдлыг тоймлон Монгол Улсад цахим худалдаа эрхлэх хууль зүйн боломж бүрдсэн эсэхийг дараах хэсэгт авч үзье.

Цахим худалдаа эрхлэх хууль зүйн үндэслэл

Цахим худалдаа эрхлэгчид нь худалдаа арилжаатай холбоотой гэрээ хэлцэл байгуулах, өөрчлөх, нэмэлт оруулах, цуцлах, хүчингүйд тооцох, хамтран ажиллах, хадгалалт, тээвэрлэлт, төлбөр тооцоо, тооцоо нийлэх, даалгавар, франчайзтай холбоотой харилцааг Иргэний хуульд⁷¹ зааснаар зохицуулж ирсэн. Харин сайтаар дамжуулан худалдаа эрхлэх хууль зүйн боломжийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Харилцаа холбооны тухай хуулиар иргэн, хуулийн этгээдүүдэд олгосон.

Харилцаа холбооны тухай⁷² хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу Харилцаа холбооны зохицуулах хорооноос цахим худалдааны журмыг боловсруулна гэжээ. 2011 оны 11 дүгээр сард “Харилцаа холбооны сүлжээгээр вэб сайтын үйлчилгээг эрхлэхэд баримтлах түр журам”⁷³ баталсан бөгөөд түүний зорилго нь вэб сайтын тусгай зөвшөөрөл олгох журам болон тэдгээр үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэхэд оршино. Үүний дагуу зохицуулах хороо нь вэб сайтын тусгай зөвшөөрөл олгодог боловч үйл ажиллагааны төрлөөр ангилдаггүй тул цахим худалдаа эрхэлж буй иргэн, хуулийн этгээдийн бүртгэл, мэдээлэл байдаггүй байна. Дээр дурьдсанчлан үйл

⁷¹ “Төрийн мэдээлэл” 2002 он. №7 - <http://www.legalinfo.mn/insys/lawmain.php?vlawid=3> (хамгийн сүүлд 2012. 06. 07)

⁷² “Төрийн мэдээлэл” 2001 он. №3- <http://www.legalinfo.mn/insys/lawmain.php?vlawid=1789> (хамгийн сүүлд 2012. 06. 07)

⁷³ Монгол Улсын Их хурлын 2010 оны 48 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан иргэн, хуулийн этгээдийн харилцаа холбооны сүлжээгээр вэб сайтын үйлчилгээг эрхлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.



ажиллагаа эрхлэх хууль зүйн үндэслэлээс гадна анхаарах нэг асуудал бол цахим хэлцэл юм.

Цахим хэлцэл

Монгол Улсын Иргэний хуулийн⁷⁴ 189 дүгээр зүйлийн 189.1-д “Гэрээний талууд хуулийн хүрээнд гэрээг чөлөөтэй байгуулах, түүний агуулгыг өөрсдөө тодорхойлох эрхтэй”. Мөн хуулийн 43 дугаар зүйлийн 43.2.2-т “Хэлцэл хийх тухай саналыг зөвшөөрсөн талын хүсэл зоригийг илэрхийлсэн захидал, цахилгаан, албан бичиг, телефакс эдгээртэй адилтгах бусад баримт бичгийг нөгөө тал нь хүлээн авсан” тохиолдолд хэлцлийг бичгээр хийсэн гэж үзэх, 196 дугаар зүйлийн 196.1.2-т “Гэрээг бичгээр байгуулахаар хуульд заасан буюу талууд тохиролцсон бол талууд нэг баримт бичиг үйлдэж, гарын үсэг зурах буюу гэрээний саналыг зөвшөөрснөө илэрхийлсэн тал гарын үсгээ зурсан захидал, албан бичиг, телефакс эдгээртэй адилтгах бусад баримт бичгийг нөгөө тал нь хүлээн авснаар” гэрээ байгуулсанд тооцно. Цахим гарын үсгийн тухай⁷⁵ хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т “Иргэний хуульд зааснаар бүртгүүлэх буюу нотариатаар гэрчлүүлбэл зохих хэлцэл /гэрээ/-ээс бусад, хуульд бичгээр хийхээр заасан хэлцэл /гэрээ/-г цахим хэлбэрээр хийж болно” гэснээс үзвэл цахим гарын үсэг ашиглаж худалдах, худалдан авах гэрээ байгуулах, хэлцэл хүчин төгөлдөр болох эрх зүйн үндсийг тодохойлж байна. Цахим гэрээ байгуулахад бусад төрлийн гэрээнээс ялгарах хэд хэдэн онцлогтой. Үүнд:

1. Цахим хэлцэл нь бусад төрлийн гэрээг бодвол цаасан хэлбэрээр бус техник, технологи ашиглаж байгуулдаг;
2. Гэрээний талууд цахим гарын үсэг ашиглан гэрээг баталгаажуулдаг;
3. Бусад төрлийн гэрээг бодвол акцепт буюу гэрээ байгуулах саналын хариу нь өөр байж болдог;
4. Талууд гэрээг хадгалах хэлбэр нь өөр байж болдог. Өөрөөр хэлбэл, бичмэл хэлбэрийн гэрээг талууд тус бүр авч хадгалдаг бол цахим гэрээг цахим хэлбэрээр хадгалдаг;
5. Цахим гэрээнд хоёр тал, олон тал оролцож болно. Жишээлбэл, худалдагч, худалдан авагчаас гадна тээвэрлэгч, зуучлагч гэх мэт;
6. Орчин үеийн техник технологийг ашиглан төлбөр тооцоо хийгддэг.

Цахим гэрээ нь бусад төрлийн гэрээтэй дараах шинжээрээ төстэй байна. Үүнд:

1. Гэрээ нь маш тодорхой, хоёрдмол утга агуулаагүй байх;
2. Энгийн ойлгомжтой байх;
3. Гэрээний зүйл, үнэ, хугацаа, төлбөр тооцоо, маргаан шийдэрлэх аргын талаар талууд гэрээ байгуулахаас өмнө урьдчилан мэдсэн байна.⁷⁶

⁷⁴ “Төрийн мэдээлэл” сэтгүүл. 2002 он. №7 - <http://www.legalinfo.mn/insys/lawmain.php?vlawid=3> (хамгийн сүүлд 2012. 06. 07)

⁷⁵ “Төрийн мэдээлэл” сэтгүүл. 2012 он. №1, х 39

⁷⁶ Рассолов. И. М. Информационное право. Учеб, 2011. С.300.



Өргөн утгаараа цахим хэлцэл нь интернэтийн сүлжээ ашиглан цахим баримт бичиг солилцох замаар бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдах, худалдан авах, тээвэрлэх зэрэг эдийн засгийн болон бусад зорилгоор хүсэл зоригоо илэрхийлсэн иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын үйлдлийг хэлнэ.⁷⁷ Өөрөөр хэлбэл, гэрээний нэг тал гэрээ байгуулах хүсэл зоригоо уламжлалт хэлбэрээр гаргаж, хүсэл зоригийг хүлээн авагч тал хүсэл зоригийг хүлээн зөвшөөрсөн тухайгаа цахим хэлбэрээр хариу өгч болно. Энэ тохиолдолд гэрээний санал offline хэлбэрээр, саналын хариу нь online хэлбэрээр хэлбэржсэн боловч гэрээ цахим хэлбэрээр байгуулагдсан гэж үзнэ. Харин гэрээний нэг тал гэрээ байгуулах тухай саналаа цахим хэлбэрээр бусдад илгээсэн, гэрээний нөгөө тал гэрээ байгуулах саналыг хүлээн зөвшөөрсөн тухайгаа уламжлалт хэлбэрээр илэрхийлсэн бол гэрээг интернэтээр байгуулсан гэж үзэхгүй.⁷⁸

Харин явцуу утгаар нь авч үзвэл, бараа бүтээгдэхүүний солилцоонд тулгуурласан цахим харилцааг хэлнэ.⁷⁹ Дээрхи байдлуудаас дүгнэн үзвэл цахим хэлцэл нь бараа бүтээгдэхүүн худалдах, худалдан авах, зуучлах, тээвэрлэх болон сүлжээ ашиглан үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон харилцаа гэж үзэж болох юм.

Монгол Улсын хувьд цахим хэлцлийг тайлбарлаж зохицуулсан эрх зүйн акт одоогоор байхгүй бөгөөд тус асуудлыг Иргэний хуулийн дагуу зохицуулагдаж байна. Бусад зарим улс орнууд цахим хэлцлийн тухай тусгайлсан хуультай байдаг бөгөөд тухайлбал, Оросын Холбооны Улс “Цахим хэрэгсэл ашиглан гэрээ байгуулах тухай хууль”-тай. Энэ хууль нь цорын ганц цахим худалдааг зохицуулсан хууль биш бөгөөд сүлжээ ашиглан гэрээ байгуулах бүхий л боломжийг зохицуулсан. Өөрөөр хэлбэл, олон төрлийн гэрээг сүлжээ ашиглан хийж болох эрх зүйн үндсийг тодорхойлсон. Үүний сонгодог жишээ бол интернэт банкны үйлчилгээ юм.

Мөн ОХУ-д Цахим худалдааны тухай хууль байдаг бөгөөд хуулийн 5 дугаар зүйлд зааснаар хувь хүн, хуулийн этгээд нь өөрийн хүсэл сонирхолоо илэрхийлэн цахим худалдааны салбарт эрх, үүрэг хэрэгжүүлж болохоор заасан нь түүний хууль зүйн хүчин чадалыг хүлээн зөвшөөрсөн жишиг болно.⁸⁰

Монгол Улсын хувьд цахим харилцаа, худалдаа, үйлчилгээний харилцаа эрх үүссэн ч цахим худалдаа эрхлэгчид дараах зүйлийг анхаарч үзэх нь зүйтэй.

✓ Монгол Улс барууны улсуудтай харьцуулбал мэдээлэл холбооны технологи, дэд бүтэц сул хөгжсөн;

⁷⁷ “Хууль дээдлэх ёс” сэтгүүл. 2007 он, №2. 64 дэх тал.

⁷⁸ Мөн тэнд.

⁷⁹ Рассолов. И. М. Информационное право. Учеб. 2011. С.301.

⁸⁰ Федеральный закон “Об электронной торговле” /Российский Федерации/



✓ Эрх зүйн зохицуулалт хангалттай биш. Тухайлбал, Мэдээллийн аюулгүй байдлын тухай, Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тухай хуульд холбогдох өөрчлөлт оруулах;

✓ Цахим худалдааны талаарх олон нийтийн мэдлэг сул;

✓ Монгол Улсын гадаад худалдааг хөгжүүлэхэд цахим худалдааны үзүүлж буй нөлөөлөл байхгүй;

✓ Интернет үйлчилгээний импорт байнга нэмэгдэж байгаа;

✓ Аж ахуйн нэгж байгууллагууд мэдээллийн аюулгүй байдлын талаар ойлголт тааруу.

✓ Дотоод зах зээлийг нээлттэй болох, гадаадын өрсөлдөх чадвартай бараа таваарын нийлүүлэлт, түүний дотор Интернетээр дамжуулан нийлүүлэх нийлүүлэлт нэмэгдэхэд дотоодын үйлдвэрлэгчдийн нийлүүлэлтэд нөлөөлдөг⁸¹ зэрэг асуудлууд байна. Харин тухайн харилцаанд оролцогч субъектүүдийн хувьд цахим худалдаа хийхэд хэд хэдэн зүйлийг анхаарах нь зүйтэй. Тухайлбал,

- Гэрээ байгуулж буй субъект нь уг мэдээллийн сүлжээг ашиглах бүрэн эрхтэй эсэх;

- Гэрээ байгуулах эрх зүйн чадвар, чадамжтай эсэх;

- Өөрийн хүсэл зоригийн дагуу гэрээ байгуулж буй эсэх зэрэг асуудлууд юм.

Домайн нэр буюу “.mn” хаяг газар нутгийн харъяаллыг тодорхойлж болох уу? Хэрэв энэ домайн хаяг кибер орчинг уламжлалт буюу газар зүйн байршилтай адилтгах боломж олгож байгаа тохиолдолд маргаан шийдвэрлэх харъяаллалыг Монгол улсын шүүх гэж тодорхойлж болох уу гэсэн асуудалд судлаач Ц.Нямхүү “Домайн нэрний маргааныг Монголын хувьд⁸² шийдвэрлэсэн тохиолдол байхгүй” хэмээн тэмдэглэн энэ төрлийн маргаан гарахад шийдэх магадлан итгэмжлэгдсэн арбитрын байгууллага Монгол Улсад байхгүй тул энэ чиглэлээр мэргэшсэн гадаадын арбитра хандах, эсвэл шүүхэд хандах арга зам бий гэжээ.⁸³ Түүнчлэн тэрээр Монголын Худалдаа аж Үйлдвэрийн дэргэдэх Үндэсний арбитраг олон улсын домайн нэр болон үндэсний домайн нэртэй холбоотой маргаан шийдвэрлүүлэх чиглэлээр магадлан итгэмжлүүлэх алхам хийх хэрэгтэй хэмээн дүгнэсэн байна.

Монгол Улсын “Цахим гарын үсгийн тухай хууль”

Дэлхийн улс орнуудад аж үйлдвэржсэн эринээс мэдээлэлжсэн эринд шилжих үйл явц эрчимжиж мэдлэгт тулгуурласан нийгмийг цогцлоон байгуулж нийгмийн баялаг, үнэт зүйлсийг бүтээх эх сурвалж нь мэдлэг, мэдээлэл гэдгийг дэлхий нийтээр хүлээн зөвшөөрч улс төр, эдийн засаг, нийгмийн бүхий л

⁸¹ Мөн тэнд.

⁸² Ц.Нямхүү, Домайн нэрийн зүй бус ашиглалт, шийдвэрлэх арга зам
<http://www.soros.org/mn/pdf/feature/20050906Nyamhuu.pdf> (сүүлд нэвтэрсэн 2012.05.16)

⁸³ Мөн тэнд, ху 3



хүрээнд мэдээлэл, харилцаа холбооны технологи (МХХТ)-ийг өргөн нэвтрүүлж байгаа⁸⁴.

Манай улс ч мөн адил мэдээлэл, харилцаа холбооны технологийг нийгмийн бүхий л хүрээнд нэвтрүүлэх зорилт тавин ажиллаж 2004 онд үндэсний хэмжээний хөтөлбөр баталсан⁸⁵ байна. Энэхүү хөтөлбөрийн зорилго нь мэдээлэл, харилцаа холбооны технологи (МХХТ)-ийн салбарт төрөөс баримтлах дунд хугацааны (2005-2012) хөгжлийн бодлого, авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлоход оршино.

Мөн Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 78 дугаар тогтоолоор⁸⁶ “Цахим гарын үсгийн тухай хууль”-ийг шинээр боловсруулж, батлуулахаар болсон нь дээрх хөтөлбөрийн хүрээнд хийгдэж буй ажлын нэг юм.

Уг тогтоолын хэрэгжилт болж 2011 оны 12 дугаар сарын 15-ны өдөр “Цахим гарын үсгийн тухай хууль” батлагдсан бөгөөд энэхүү хууль нь 2013 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн үйлчилж эхлэх юм.

Уг хуулийн гол зорилго нь:

- ✓ Цахим гарын үсгийг бүтээх, хамгаалах, ашиглахтай холбоотой эрх зүйн орчныг бүрдүүлэх;
- ✓ Албан хэрэгцээндээ хэрэглэж буй файл, и-мэйлийг албан ёсны мэдээлэл гэж үзэх;
- ✓ Одоогийн интернэт орчинд хийж буй ажлыг хүчин төгөлдөр гэж үзэх боломжийг бүрдүүлэх;
- ✓ Төрийн үйл ажиллагааг илүү хялбар, чирэгдэлгүйгээр иргэддээ хүргэдэг болгоход оршино.

Цахим гарын үсгийн тухай хуулийг батлах болсон хэрэгцээ, шаардлага:

Интернэт хэрэглэгчдийн тоо нэмэгдэж байгаагийн хэрээр иргэд, байгууллагууд интернэтийн сүлжээг ашиглан гэрээ хэлцэл байгуулах, худалдаа үйлчилгээ эрхлэх зэргээр бизнесийн ашиг орлогоо нэмэгдүүлж байна. Гэвч шинээр бий болсон энэхүү харилцааг зохицуулах хууль зүйн зохицуулалт нь манай улсад байхгүй байгаа нь интернэтийн сүлжээнд суурилсан хөгжил, дэвшлийн боломжийг бүрэн ашиглаж чадахгүй байдлыг үүсгэж байна.

⁸⁴ Электрон монгол үндэсний хөтөлбөр. УБ., 2004 он

⁸⁵ 2004 онд Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газраас “Электрон Монгол” хөтөлбөрийг боловсруулан гаргасан.

⁸⁶ Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 78 дугаар тогтоол. “Монгол Улсад бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бий болгох үндэсний хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх тэргүүлэх ач холбогдол бүхий төсөл, арга хэмжээ”-ний 1.1.3.



Иргэд интернэтийн сүлжээг ашиглан хоорондоо цахим хэлбэрээр хийсэн хэлцлийн талаар маргаан үүссэн тохиолдолд шүүх тухайн хэлцлийг хүчин төгөлдөр хэлцэл гэж үзэх эсэх нь тодорхойгүй байсан. Тиймээс өнөөдрийг хүртэл цахим хэлцэлтэй холбогдуулж шүүхээр шийдвэрлэгдсэн хэрэг шүүхийн практикт байхгүй байгаа юм.

Мөн интернэтийн сүлжээг ашиглан хоорондоо харилцаж байсан файл, и-мэйлийг нотлох баримтын хэмжээнд үнэлж болох эсэх нь мөн зохицуулалтгүй байна. Учир нь цахим хэлбэрээр тухайн этгээд гарын үсгээ зурсан тохиолдолд тухайн гарын үсгийг ямар тохиолдолд хүчин төгөлдөр гэж үзэх эсэх нь мөн л тодорхойгүй байсан.

Дээрх асуудлуудыг зохицуулахаар төрөөс цахим гарын үсгийг энгийн гарын үсгийн нэгэн адил хүчинтэйд тооцож баталгаажуулах, түүнийг ашиглах журмыг тодорхой болгох, тоон гарын үсгийн нийтийн түлхүүрийн дэд бүтцийг бий болгохтой холбоотой харилцааг зохицуулах шаардлага бий болсон учраас цахим гарын үсгийн тухай хуулийг батлан гаргах болсон юм.

Цахим гарын үсгийн тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулж хийгдэх шаардлагатай байгаа ажлууд:

Цахим гарын үсгийн тухай хуулийг хэрэгжүүлж эхлэхийн өмнө дараах ажлыг хийх шаардлагатай байдаг байна. Үүнд:

- нийтийн түлхүүрийн дэд бүтцийг⁸⁷ бий болгох;
- мэдээлийн аюулгүй байдлыг бий болгох;
- цахим засаглалын тогтолцоо эрүүл байх зэрэг олон зүйлсийг хийх шаардлага тулгардаг.

Учир нь цахим гарын үсэгт шилжихэд мөнгөн гүйлгээ болоод худалдаа, арилжаа, гуйвуулга зэрэг зүйлс бүгд цахим хэлбэрт шилжинэ. Мөн бизнесийн орчин ч энэ байдлаар үүсч хөгжинэ. Тиймээс энэ бүхнийг нэгтгэсэн нэгдсэн нэг систем хэрэгтэй байдаг ба энэ нь нийтийн түлхүүрийн дэд бүтэц болдог байна.

“Нийтийн түлхүүр” гэдэг нь цахим гарын үсгийн зөвшөөрлийг хэрхэн олгох, түүнийг зохицуулахтай холбогдсон ойлголт юм.

Манай улсын хувьд “нийтийн түлхүүрийн дэд бүтэц бий болгох асуудлыг тусгай зөвшөөрөлтэй эрх бүхий этгээд хийнэ⁸⁸” гэж цахим гарын үсгийн тухай хуульд тусгасан учраас нийтийн түлхүүрийн дэд бүтцийг ашиглах талаар төрөөс баримтлах бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага бий болно.

⁸⁷ Цахим гарын үсгийн тухай хуулийн 4.1.11. Нийтийн түлхүүрийн дэд бүтэц гэж тоон гарын үсгийн хувийн болон нийтийн түлхүүрийг үүсгэх, зохион байгуулах, хуваарилах, хэрэглэх, хадгалах болон хүчингүй болгох, түүнийг цахим харилцаанд нэвтрүүлж ашиглахтай холбогдсон тогтолцоог хэлнэ.

⁸⁸ Цахим гарын үсгийн тухай хуулийн 18.1. Гэрчилгээ олгох үйл ажиллагааг харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага /цаашид “төрийн захиргааны байгууллага” гэх/-аас олгосон тусгай зөвшөөрөлтэйгээр эрхэлнэ.



Тийм учраас манай улс нийтийн түлхүүрийн дэд бүтцийг байгуулах төслийг Дэлхийн банктай хамтран хэрэгжүүлж байна.

Мөн түүнчлэн цахим гарын үсгийг гэрчилгээжүүлэх байгууллага байгуулагдсанаар энэхүү гарын үсэг хэрэгжинэ. Энэ байгууллага нь бие даасан байгууллага учраас тогтолцоо, техник, эдийн засгийн шаардлагууд, программ хангамж, тусгай зөвшөөрлийг боловсруулах хэрэг гарна. Зөвхөн байгууллага байгуулагдаад зогсохгүй тоон гарын үсгийн хэрэглээг төрийн удирдлагад нэвтрүүлэх, төрийн албан хаагчдыг сургах, нийгмийн бусад харилцаанд нэвтрүүлэх, сурталчлах зэрэг олон үйл ажиллагаа хэрэгжүүлэх шат дараалсан олон ажлууд хийгдэнэ⁸⁹.

Цахим гарын үсгийн тухай хууль батлагдсантай холбогдуулан бусад хуульд орсон нэмэлт, өөрчлөлтүүд:

Цахим гарын үсгийн тухай хууль батлагдсантай холбогдуулан дараах хуулиудад нэмэлт, өөрчлөлт орсон байна. Үүнд:

1. Иргэнийхууль;
2. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль;
3. Татварын ерөнхий хууль;
4. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль;
5. Иргэний бүртгэлийн тухай хууль;
6. Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль;
7. Захиргааны хариуцлагын тухай хууль.

Дээрх хуулиудын нэмэлт, өөрчлөлт цахим гарын үсгийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн үйлчилж эхлэх юм.

Эдгээр нэмэлт, өөрчлөлт орсон хуулиудаас Харилцаа холбооны тухай хууль, Татварын ерөнхий хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулиуд нь цахим гарын үсгийг хэрэгжүүлэгч байгууллагуудын дотоод үйл ажиллагааг зохицуулахтай холбоотой нэмэлт, өөрчлөлтүүд байсан.

Харин дараах хуулийн нэмэлт, өөрчлөлтүүдэд цахим гарын үсгийг иргэд хэрхэн хэрэглэж болохыг илүү тодорхой зааж өгсөн байна. Тухайлбал, Интернэт ашиглан үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, аж ахуй нэгж, иргэдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор “Иргэний хууль”-д хуульд зааснаар бүртгүүлэх буюу нотариатаар гэрчлүүлбэл зохих хэлцлээс бусад, хуульд бичгээр хийхээр заасан хэлцлийг цахим хэлбэрээр хийж болно гэж нэмэлт, өөрчлөлт оруулсан нь цахим хэлбэрээр хийсэн хэлцлийн талаар маргаан гарсан тохиолдолд шүүхэд хандаж эрхээ хамгаалуулах боломжийг талуудад олгосон ач холбогдолтой зохицуулалт болсон.

⁸⁹ <http://www.bolod.mn> - (сүүлд нэвтэрсэн огноо 2012.04.02)



Мөн төрийн байгууллагын үйл ажиллагааг иргэдэд түргэн шуурхай хүргэх зорилгоор “Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль”-д:

- ✓ Хуулийн этгээдийн нэр өөр хуулийн этгээдийн нэртэй давхардсан эсэхийг холбогдох бүртгэх байгууллага цахим хэлбэрээр шалгаж баталгаажуулна;
- ✓ Хуулийн этгээдийн цахим хэлбэрээр улсын бүртгэлд бүртгүүлж болно;
- ✓ Иргэн, хуулийн этгээд улсын бүртгэлийн жагсаалтаас цахим хэлбэрээр лавлагаа авах хүсэлтийг холбогдох бүртгэх байгууллагад гаргаж болно гэж тус тус нэмэлт, өөрчлөлт оруулсан нь иргэдэд төрийн үйлчилгээг ойртуулсан ач холбогдолтой зохицуулалт болсон.

Мөн төрийн үйлчилгээг түргэн шуурхай чирэгдэлгүй болгох зорилгоор “Иргэний бүртгэлийн тухай хууль”-д иргэд лавлагааг цахим хэлбэрээр авч болно, мөн хүүхдийн төрснийг цахим хэлбэрээр бүртгүүлж болно гэж тус тус нэмэлт, өөрчлөлт оруулсан нь иргэдийн цагийг хэмнэсэн ач холбогдолтой зохицуулалт болсон юм.

Мөн түүнчлэн банкны үйлчилгээг иргэдэд ойртуулах зорилгоор “Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль”-д мөнгөн хадгаламжийн гэрээг цахим хэлбэрээр хийж болно, иргэн хуулийн этгээд цахим хэлбэрээр данс нээлгэж, хаалгаж болно гэж тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна. Энэхүү нэмэлт өөрчлөлт нь иргэдэд банкны үйлчилгээг ойртуулж өгсөн ач холбогдолтой зохицуулалт болсон юм.

Цахим худалдаа ба B-G Худалдааны төрөл

Дэлхий нийтээр сүүлийн үед хамгийн ихээр ашиглаж байгаа худалдааны нэг төрөл нь цахим худалдаа юм. Цахим худалдааг ашигласнаар орон зай, цаг хугацааг үл хамааран дэлхийн аль ч өнцөг булангаас хэрэглэгчдэд худалдан авалт хийх боломж бүрдэнэ. Цахим худалдаа гэдэгт зөвхөн бүтээгдэхүүнийг онлайнаар худалдах ба худалдан авах харилцааг ойлгодоггүй бөгөөд өөр олон төрлийн үйлчилгээг хамруулан авч үзнэ. Жишээ нь, цахим худалдаагаар хэрэглэгчдэд хүргэлтийн үйлчилгээ үзүүлж болно.

Цахим худалдаа /e-commerce/-г худалдагч буюу үйлчилгээ үзүүлэгч тал интернэтийн сүлжээнд байрлах өөрийн хаяг бүхий интернэт дэлгүүрээр дамжуулан бараагаа зарах болон бусад үйлчилгээг үзүүлэх, худалдан авалт хийж байгаа хүн төлбөрийн картаараа тухайн барааны төлбөрийг гүйцэтгэн бараа, үйлчилгээг авах процесс гэж тодорхойлж болох юм.

Цахим худалдаа нь цахим бизнес эрхэлж буй байгууллагуудад ашиг орлогоо нэмэгдүүлэх, бараа бүтээгдэхүүнээ дэлхий даяар зарах өргөн боломжийг олгож хэрэглэгчдийн тоог нэмэх ашигтай байдаг.

Харин хэрэглэгчдийн хувьд хүссэн бараа үйлчилгээгээ хурдан шуурхай авах, цаг хэмнэх ашигтай.



Манай орны хувьд цахим худалдааны үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчин дутмаг, цахим арилжааг явуулахад твгээлтийн зохистой систем бий болоогүй зэрэг бэрхшээлүүд бий. Мөн цахим худалдааг явуулснаар олж болох ашиг, давуу тал, боломжуудын талаар хүмүүст хангалттай мэдээлэл байдаггүй, интернэт ашиглагчдын тоо хангалтгүй, тэдгээрийн цахим худалдааны талаарх мэдлэг чадвар бага, цахим худалдаа эрхлэгчдэд төрөөс үзүүлэх дэмжлэг туслалцаа бага, хүмүүсийн худалдан авах чадвар муу /Цахим худалдаагаар 80 000 төгрөгөөр цамц худалдан авснаас дэлгүүрээс 50 000 төгрөгөөр цамц авахыг илүүд үзэх худалдан авагч олон байдаг/ зэрэг шалтгааны улмаас цахим худалдаа хөгжихгүй байна.

Цахим худалдааны төрлүүд дотроос Засгийн газраас хэрэглэгчдэд чиглэсэн business to government /B2G/ төрөл нь манай оронд үүсч хөгжөөд удаагүй байна.

Төрийн байгууллагууд болон компаниуд онлайн сүлжээг ашиглан хэн хэндээ ашигтай байдлаар мэдээлэл солилцох, худалдаа хийх үйл ажиллагааг B2G гэнэ. Жишээлбэл: Тендерийн тухай мэдээлэл, татварын хөнгөлөлт, төрийн бодлогоор авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүд гэх мэт.

Манай улсын хувьд “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангах зорилгоор Засгийн газрын худалдан авах ажиллагааны бодлого, зохицуулалт хариуцсан нэгжийг Сангийн яамны /хуучнаар/ үндсэн бүтцэд багтаан бий болгосон⁹⁰. Энэхүү газар нь Засгийн газрын худалдан авах ажиллагааны бодлого, зохицуулалттай холбогдсон бүх үйл ажиллагааг хариуцсан мэргэжлийн нэгж бөгөөд Сангийн сайдыг худалдан авах ажиллагааны бодлогын зөвлөгөөгөөр хангах үүрэгтэй.

Мөн уг газраас худалдан авах ажиллагааг төвлөрүүлэн зохион байгуулдаг бөгөөд аливаа нэг худалдан авах ажиллагааг хэрэгжүүлэхэд шууд оролцохгүй, зөвхөн хэрэгжүүлэгч байгууллагуудыг мэргэжлийн арга зүй, шаардлагатай журам заавраар хангаж, тэдгээрийн үйл ажиллагаа, холбогдох хууль тогтоомж, журам зааврын хэрэгжилтэд хяналт тавьж ажилладаг байна.

Энэхүү газар нь Монгол Улсын хэмжээнд төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тогтолцоог олон улсын стандартад хүргэж, бүх шатны төсвийн хөрөнгийн зарцуулалтад хэмнэлт, үр ашиг, ил тод байдал, харилцан тайлагнах болон хариуцлагын зарчмуудыг баталгаажуулж, авилгал гарах нөхцлийг бууруулах, дотоодын үйлдвэрлэгч, гүйцэтгэгчийг дэмжих шударга өрсөлдөөнийг өрнүүлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилт тавин ажилладаг.

B2G E-Худалдаа

B2G-д “e-procurement” гэдэг үйлчилгээ ч мөн хамаарна. Энэ үйлчилгээ нь төрийн байгууллагуудын худалдан авах бүтээгдэхүүний хэрэгцээ, хүсэлт, хариу

⁹⁰ 2000 оны 6 дугаар сарын 14-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар шийдвэрлэсэн.



зэрэг мэдээллийг өөртөө багтаана. B2G –ийг заримдаа “e-Government” ч гэж нэрлэдэг.

Дээр дурьдсанчлан Монгол Улсын хувьд B2G харилцааг Сангийн яамны худалдан авах ажиллагааны бодлого зохицуулалтын газар эрхлэн явуулж эхэлсэн.

Энэ газар нь:

- ✓ Засгийн газрын худалдан авах ажиллагаанд цахим хэрэгслийг нэвтрүүлэх нөхцөл, стандарт, журмыг тогтоон мөрдүүлэх;
- ✓ Засгийн газрын худалдан авах ажиллагааны зохион байгуулалт, төлөвлөлт, тайлагналтын зохистой тогтолцоог бүрдүүлэх;
- ✓ Худалдан авах ажиллагааны нэгдсэн мэдээ, тайлан боловсруулах журам, маягтын загварыг батлуулан мөрдүүлэх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэж байна.

Тус газар худалдан авах ажиллагааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах чиглэлээр:

- Засгийн газраас тогтоосон томоохон худалдан авах ажиллагааны тендер шалгаруулалтыг зарлан мэдээлэх, гүйцэтгэгчтэй гэрээ байгуулахын өмнө ирүүлсэн саналыг хянан үзэж, гэрээ байгуулах зөвшөөрөл олгох;
- Засгийн газрын худалдан авах ажиллагааны вэб хуудсыг ажиллуулж, түүнд тендерийн урилга, тендер шалгаруулалтын дүн мэдээг нийтэд түгээх болон бусад мэдээ, мэдээлэл тавих арга, хэлбэрийг тогтоох, мэдээллийг нийтлэх ажлыг зохион байгуулалт, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, улмаар томоохон тендер шалгаруулалтын дүн мэдээг олон нийтэд ил тод мэдээлдэг.

Энэхүү газар үйл ажиллагаандаа “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийг удирдлага болгодог бөгөөд уг хуулийг дагалдаж гарсан бусад эрх зүйн баримт бичиг, журам заавар, тендерийн жишиг бичиг баримтыг улсын хэмжээнд нэгдсэн журмаар мөрдүүлж хяналт тавих ажлыг эрхлэн гүйцэтгэж байна.

B2G харилцааг хэрэгжүүлэх явцад тулгамдаж буй асуудал

Уг харилцаа нь Монголд үүсч хөгжөөд удаагүй байгаа ба Сангийн яамны дэргэдэх худалдан авах ажиллагаа хариуцсан бодлогын газрын үйл ажиллагааны гол зорилго нь татвар төлөгчдийн буюу нийтийн хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй, ил тод, шударгаар зарцуулах, зарцуулалтыг харилцан тайлагнах, хариуцлагын зарчмыг сайжруулах асуудал юм. Улсын секторын худалдан авах ажиллагааг энэхүү шаардлагын хэмжээнд зохицуулах эрх зүйн орчин үндсэндээ бүрдэж байгаа боловч худалдан авах ажиллагааны хууль, түүнийг дагалдах журам, зааврыг хэрэгжүүлэхэд уламжлалт арга барил, туршлага, бэлтгэгдсэн үндэсний боловсон хүчний чадавхи хомс байна. Үүний улмаас заавар, журмыг буруу ойлгож хэрэгжүүлэх буюу огт хэрэгжүүлэхгүй байх, ашиглаж чадахгүй зэрэг байдал гарч, гүйцэтгэгчийг буруу сонгох, зардлыг нэмэгдүүлэх, Засгийн газрын



төслийн хэрэгжилт төлөвлөсөн хугацаанаасаа хэтрэх, олон нийтийн дунд Засгийн газрын байгууллагын нэр хүнд унах, санаатай буюу мэдлэг чадвар дутсанаас хууль тогтоомжийг зөрчих явдал гарч байна⁹¹.

B2G харилцааг хэрэгжүүлж эхэлж байгаа тус газрын хувьд тулгамдаж байгаа өөр нэг асуудал нь уг газар нь төсвийн хөрөнгө, мөнгийг хэмнэхийн тулд энэ хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаагаа аль болох бага өртгөөр хийх ёстой. Гэтэл энэхүү ажиллагааг хийхэд техник, технологи нь зардал байдаг учраас бага зардлаар хийх боломжгүй байгаа шалтгааны улмаас хөрөнгө мөнгөний санхүүжилтаас болж үйл ажиллагаа нь доголдохыг үгүйсгэхгүй юм. Мөн төрийн байгууллагын хувьд цахим худалдан авах үйл ажиллагааг цахим хэлбэрээр явуулах сонирхол бага учраас уг үйл ажиллагааг дэмжих бодлого шаардлагатай байгаа юм.

НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Энэхүү “Цахим худалдааны олон улсын эрх зүйн зохицуулалт” сэдэвт судалгаагаар судалгааны ажлын удирдамжийг удирдлага болгож дараах хүрээний асуудлыг судаллаа.

1. Цахим худалдааны олон улсын эрх зүйн нийтлэг зохицуулалтыг судлах тухайд

Цахим худалдаанд холбогдох олон улсын гэрээний хөгжил, ерөнхий үзэл баримтлал, онцлог зохицуулалтын талаар тоймлон судаллаа. Үүнд цахим худалдаатай холбоотой олон улсын эрх зүйн зохицуулалтууд хэрхэн бий болж хөгжсөн болоод өнөөгийн байдлаар эрх зүйн ямар ямар баримт бичиг, гэрээ, конвенцууд батлагдан үйлчилж байгаа талаар авч үзсэн. Тухайлбал, Бараа худалдах, худалдан авах тухай Венийн конвенц, Иргэний болон арилжааны асуудлаарх шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөх тухай Брусселийн конвенц, Иргэний болон арилжааны хэргийн асуудлаар гадаадын шүүхийн шийдвэр, маргаан шийдвэрлэх шүүхийн харьяаллын тухай Гаагийн конвенц, Маргаан шийдвэрлэх шүүхийг сонгох зөвшилцлийн тухай Гаагийн конвенц, Олон улсын гэрээнд цахим харилцааг ашиглах тухай конвенц болон цахим худалдаанд холбогдох олон улсын загвар хуулийг судалсан нь олон улсын нийтлэг зохицуулалт, түүний хөгжлийг бүрэн хамруулсан гэж хэлж болно.

2. Цахим худалдааны эрх зүйн харилцааны онцлог асуудлыг тодорхойлох тухайд цахим худалдааны талаарх нэлээд дэвшилттэй хэмээн тооцогддог зарим тодорхойлолтыг авч үзэхээс гадна цахим худалдааны харилцаанд оролцогчид, уг харилцааны төрөл, ангилал болон бусад хууль эрх зүйн асуудлууд болох мэдээллийг хамгаалах, татвар төлөх, гаалийн татвар ногдуулах, аюулгүй байдлыг хангах, оюуны өмчийн эрхийг хамгаалах, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, маргаан шийдвэрлэхтэй холбоотой

⁹¹ www.e-procurement.mn - aac авав



асуудлыг цахим худалдааны эрх зүйн онцлог асуудал болгож тодорхойлсны үндсэн дээр маргаан шийдвэрлэхтэй холбоотой асуудлыг илүү дэлгэрүүлж судлав.

3. Цахим худалдааны эрх зүйн хөгжлийн асуудлыг олон улсын байгууллагууд, хурал семинараас баталсан зөвлөмж, үр дүн, хөгжиж буй болон хөгжсөн орнууд дахь цахим худалдааны үндэсний хэмжээний ажлын хэсэг болон зөвлөх хороонууд, тэдгээрийн үүрэг оролцоо, туршлагыг танилцуулахын зэрэгцээ Монгол Улс дахь цахим худалдааны эрх зүйн орчинг судалж, цахим худалдааны “бизнес эрхлэгч-Засгийн газар” буюу B2G, “бизнес эрхлэгч-хэрэглэгч” буюу B2C хэлбэрийн харилцааг тусгайлан авч үзлээ.

Монгол Улсын хувьд цахим худалдааны B2G болон B2C харилцаа цахим хэлбэрээр хийгдэж буй бусад харилцаанаас илүүтэй хөгжиж эхэлсэн байна. B2G харилцаа Монгол Улсад цахим засаглалын нөлөөгөөр илүүтэй хөгжөөд эдийн засгийн суурь болж буй хувь хүн, хуулийн этгээд буюу бизнесийн байгууллагуудын хоорондох B2C харилцаанд зохицуулагдаагүй, эрх зүйн зохицуулалт шаардаж буй орон зай байсаар байгааг тэмдэглэн хэлмээр байна.

Хөгжиж байгаа болон хөгжилтэй улс орны хувьд цахим худалдааг хөгжүүлэхэд анхаарах асуудлуудыг тодруулсан⁹². Эдгээрээс Монгол Улсад хамааралтай дараах нийтлэг асуудлууд байна гэж дүгнэлээ. Үүнд:

- ✓ Үндэсний хэмжээний бодлого болон төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх
- ✓ Цахим худалдааны чиглэлээр хүний нөөцийг бүрдүүлэх
- ✓ Эх хэл дээрээ компьютерийн хэллэг, агуулгыг орчуулж, хэрэглээг бий болгох
- ✓ Цахим худалдааны портал сайтуудтай байх
- ✓ Цахим засаглал буюу гүйцэтгэх засаглалын үйл ажиллагааг хялбарчилсан байх
- ✓ Үйлдвэрлэл, аюулгүй байдал, эрүүл мэндийн стандартуудыг тодорхойлсон байх
- ✓ Мэдээлэл технологийн хууль тогтоомжтой байх (цахим-хэлцэл, цахим-гарын үсэг, компьютер ашиглан гэмт хэрэг үйлдэх асуудлыг зохицуулсан байх)
- ✓ Мэдээллийн, системийн, сүлжээний аюулгүй байдлыг хангах
- ✓ Сертификатчлах, албан ёсоор зөвшөөрөл олгох асуудал
- ✓ Орон нутгийн сүлжээний асуудлыг шийдвэрлэх
- ✓ Цахим зах зээлийг бий болгох
- ✓ Цахим хэлбэрээр төлбөр төлөх боломжийг бүрдүүлэх
- ✓ Хэрэглэгчийг хамгаалах болон нууцлалын асуудал
- ✓ Оюуны өмчийн эрхийг хамгаалах

⁹²UNCTAD, E-Commerce and Development Report 2003, p. 66



- ✓ Цахим худалдаатай холбоотой олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх, цахим хэлбэрээр худалдаа хийх, ажил хэрэг явуулах хэрэглээг бий болгоход чиглэсэн сургалт, сурталчилгаа нь цахим худалдааг хөгжүүлэх түлхэц болно.

Тохиромжтой хууль эрх зүйн орчин чухал гэдгийг хүлээн зөвшөөрснөөр улс орнуудын Засгийн газар цахим худалдаанд нийцсэн хууль эрх зүйг боловсронгуй болгох шинэчлэлийг хийж байна.

Монгол Улс цахим худалдааны эрх зүйн хүрээнд шийдвэрлэвэл зохих дараах асуудлыг санал болгож байна. Олон улсын эрх зүйн болон зохицуулалтын хөгжил⁹³ нь хөгжиж буй орнуудад хэрхэн нөлөөлж байгааг үнэлэх зорилгоор 1999 оны 7 дугаар сард⁹⁴ Женевд НҮБХХХ-ны ивээл дор зохион байгуулагдсан Шинжээчдийн уулзалтаас нь Засгийн газруудад хандаж боловсруулсан зөвлөмжийг⁹⁵ удирдлага болгон хууль, эрх зүйг шинэчлэх явцдаа Цахим худалдаанд хэрэглэх UNCITRAL Загвар Хуулийг ашиглах, UNCITRAL-ийн болон бусад байгууллагуудын боловсруулсан цахим худалдаанд авч үздэг бусад хэрэгслүүдийг хэрэглэх нь зүйтэй. Энэ нь шинэ хууль тогтоомж гаргахад эсвэл одоогийн хууль тогтоомжийг уялдуулахад суурь нь болох юм.

⁹³Цахим худалдааны талаар чадавхийг бэхжүүлэх Шинжээчдийн Уулзалтын тайлан: Хууль эрхзүйн болон зохицуулалтын хэм хэмжээнүүд, TD/B/COM.3/28, НҮБХХХ-ны 8 дугаар сарын 11-ны өдрийн тайлан “Цахим худалдааны эрхзүйн хэмхэмжээ”, TD/B/COM.3/EM.8/2. 1999 оны 5 дугаар сарын 4

⁹⁴Цахим худалдааны талаар чадавхийг бэхжүүлэх Шинжээчдийн Уулзалтын тайлан: Хууль эрхзүйн болон зохицуулалтын Хэмжүүрүүд, TD/B/COM.3/28, 1999 оны 8 сарын 11

⁹⁵Шинжээчдийн Уулзалтын Тайлан, 32-35 параграфуудыг харна уу.



ХАВСРАЛТ

Хавсралт 1

Цахим худалдааны тухай НҮБ-ын загвар хууль⁹⁶

[Эх хувь: Араб, Хятад, Англи, Франц, Орос, Испани хэл дээр хийгдэв]

Нэгдүгээр хэсэг. Цахим худалдааны ерөнхий ойлголт

БҮЛЭГ I. НИЙТЛЭГ ОЙЛГОЛТ

1 дүгээр зүйл. Хэрэглэх хүрээ*

Энэхүү хууль** нь худалдаа арилжааны**** үйл ажиллагааны агуулгыг*** илэрхийлэхийн тулд хэрэглэгдэж байгаа өгөгдөл зурвас байдлаар хэлбэржсэн аливаа төрлийн мэдээлэл бүхий харилцаанд хэрэглэгдэнэ.

Олон улсын хэмжээнд хэрэглэгдэж буй өгөгдөл зурваст энэхүү Хуулийг хэрэглэх хүрээг хязгаарлахыг хүсч буй Улс гүрэнд Комиссын* зүгээс дараах зүйлсийг санал болгож байна. Үүнд:

“Олон улсын худалдаа арилжаанд хамаарах өгөгдөл зурвас гэдгийг энэхүү Хуулийн 2 дугаар зүйлийн (1) дэх хэсэгт тодорхойлсноор ойлгох бөгөөд уг өгөгдөл зурваст энэхүү Хууль хамаарна.”

**Энэхүү Хууль нь хэрэглэгчийг хамгаалсан аливаа хуульд ёс (rule of law)-ноос илүү гарч үйлчлэхгүй.

***Энэхүү Хуулийн үйлчлэх хүрээг илүү өргөн байлгахыг хүсч буй Улс гүрнүүдэд дараах зүйлсийг Комиссын зүгээс санал болгож байна. Үүнд:

“Өгөгдөл зурвас байдлаар хэлбэржсэн аливаа төрлийн мэдээлэл бүхий харилцаанд дараах нөхцөл байдлаас бусад тохиолдолд энэ Хууль хэрэглэгдэнэ. Үүнд: [...]”

****Гэрээнээс үүсэлтэй харилцаа мөн эсэхээс үл хамааран худалдаа арилжааны мөн чанартай ямар ч харилцаанаас үүссэн асуудлуудад хамаарсан өргөн утгаар “худалдааны (commercial)” гэсэн нэр томъёог тайлбарлаж ойлгоно.

⁹⁶ Албан бус орчуулга, судалгааны багийн гишүүд орчуулав.



Худалдаа арилжааны мөн чанартай харилцаа гэдэг нь аливаа бараа үйлчилгээг хангах, солилцох хэлцэл, агентын буюу худалдааны зуучлал, факторинг, лизинг буюу санхүүгийн түрээс, банкны холбогдолтой хэлцэлүүд, барилгын ажил гүйцэтгэх хэлцэл, зөвлөх үйлчилгээний хэлцэл, инженерийн төрлийн хэлцэл, тусгай зөвшөөрөлтэй холбоотой хэлцэл, хөрөнгө оруулалтын хэлцэлүүд, санхүүгийн болон даатгалын хэлцэлүүд, концесс болон олборлолтын хэлцэлүүд, хамтарсан үйлдвэр болон үйлдвэрлэл эсвэл бизнесийн хамтын ажиллагааны хэлцэлүүд, агаараар, далайгаар, төмөр зам болон газраас зорчигч болон бараа тээвэрлэлтгэх мэт хэлцэлүүдийг агуулах боловч зөвхөн эдгээр хэлцлүүдээр хязгаарлагдахгүй болно.

2 дугаар зүйл. Нэр томъёоны тодорхойлолт

Энэ хуулийн зорилгыг хангах үүднээс дараах нэр томъёог дор тайлбарлав. Үүнд:

- (a) “Өгөгдөл зурвас” гэж цахим шуудан, телекс, телекопи, цахим өгөгдөлийг солилцоо зэрэг цахим, өндөр хурдны болон бусад адилтгах арга хэрэгсэл ашиглан нэгтгэх, илгээх, хадгалах зэргээр хэлбэржүүлсэн мэдээллийг хэлнэ.
- (b) “Цахим өгөгдөлийг солилцоо(EDI)” гэж тохиролцсон мэдээллийн бүтцийн стандартын дагуу мэдээллийг нэг компьютерээс нөгөө компьютер руу цахим хэлбэрээр шилжүүлэхийг хэлнэ.
- (c) “Үүсгэгч” буюу өгөгдөл зурвасыг үүсгэгч гэж уг зурвас мэдээллийг илгээх, хадгалах зэргээр зуучийн үүрэг гүйцэтгэж буй аливаа этгээдээс бусад этгээд буюу өгөгдөл зурвасыг нэгтгэх, илгээх, хадгалах зорилгоор үүсгэж буй хүн эсвэл уг үйлдлүүдийг хийхийг зорьсон этгээдийн өмнөөс хийж өгч буй хүнийг хэлнэ.
- (d) Өгөгдөл зурвасыг “хаягийн дагуу хүлээн авагч” гэж зурвас мэдээллийг илгээх, хадгалах зэргээр зуучийн үүрэг гүйцэтгэж буй аливаа этгээдээс бусад этгээд буюу уг өгөгдөл зурвасыг үүсгэгчээс илгээхийг зорьж буй хүнийг хэлнэ.
- (e) Тухайн өгөгдөл зурваст хамааралтай “Зууч (Intermediary)” гэж бусдын өмнөөс өгөгдөл зурвасыг илгээх, хүлээн авах, хадгалах, болон бусад байдлаар ашиглахад нь үйлчилгээ үзүүлж буй этгээдийг ойлгоно.
- (f) “Мэдээллийн систем” гэж өгөгдөл зурвасыг нэгтгэх, илгээх, хүлээн авах, хадгалах, болон бусад байдлаар ашиглах системийг хэлнэ.



3 дугаар зүйл. Хууль тайлбарлах

(1) Энэхүү хуулийг тайлбарлахдаа нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээг харгалзах, олон улсын хэмжээнд хэрэглэгддэг мөн чанар болон нэгдмэл байдлаар хэрэглэх явдлыг дэмжих хэрэгцээ зэргийг харьцуулан үзэх нь зохистой.

(2) Энэхүү Хуулиар зохицуулагдаж байгаа боловч бүрэн хэмжээгээр илэрхийлэгдэж чадаагүй асуудалд холбоотой асуудлыг энэ Хуульд заасан ерөнхий зарчмуудад үндэслэн шийдэрлэнэ.

4 дүгээр зүйл. Хэлэлцээрээр өөрчлөх

(1) Бүлэг III-т заасан зүйлүүдийг тухайлбал өгөгдөл зурвасыг нэгтгэх, илгээх, хүлээн авах, хадгалах болон бусад байдлаар ашиглах зэрэгтэй холбоотой асуудлыг талуудын хооронд хийсэн хэлэлцээрээр өөрчилж болно.

(2) Энэ зүйлийн (1) дэх хэсэг нь бүлэг II-т тусгагдсан аливаа эрх зүйт ёсыг хэлэлцээрийн үндсэн дээр өөрчлөх аливаа эрхэд нөлөөлөхгүй.

БҮЛЭГ II. ЗУРВАС ӨГӨГДӨЛД ТАВИГДАХ ХУУЛЬ ЗҮЙН ШААРДЛАГЫН ХЭРЭГЛЭЭ

5 дугаар зүйл. Зурвас өгөгдөлийг хууль зүйн хувьд хүлээн зөвшөөрөх

Зурвас өгөгдөл хэлбэрээр бичигдсэн, бичиг баримтынхаа нэг хэсэг нь болж байгаа мэдээлэл нь хууль зүйн үр дагавар, хууль зүйн хүчин төгөлдөр байдлаа алдахгүй.

Тайлбарын хамт хэрэглэх (1998 оны 6 дугаар сард Комиссын гучин гуравдугаар ээлжит хурлаар хэлэлцэн батлав)

Хууль зүйн үр дагавар үүсгэж байгаа талаар зурвас өгөгдөлд ямар нэг мэдэгдэл агуулагдаагүй боловч тухайн зурвас өгөгдөл нь хууль зүйн үр дагавар үүсгэж байгаа гэсэн шалтгааны улмаас тухайн мэдээлэл нь хууль зүйн үр дагавар, хууль зүйн хүчин төгөлдөр байдлаа алдахгүй.



6 дугаар зүйл. Бичмэл хэлбэртэй байх

- (1) Мэдээлэл нь бичмэл хэлбэртэй байна гэж хуульд хэлбэрийн шаардлага тавьсан нөхцөлд хэрэв агуулагдаж буй мэдээлэл нь хэрэглэж болохуйц мөн тухайн холбогдох баримт бичгийн хувьд ашиглагдахуйц байвал зурвас өгөгдөл нь энэнхүү шаардлагыг хангасан гэж үзнэ.
- (2) Дээрх (1) хэсэгт заасан шаардлага нь мэдээлэл бичмэл хэлбэрээр хийгдээгүйн улмаас гарах үр дагаварын талаар хуульд энгийнээр заасан эс бөгөөс үүрэг болгон шаардсан тохиолдолд мөн хамаарна.
- (3) Тус зүйлд заасан зохицуулалт дараах харилцаанд хамаарахгүй: [...].

7 дугаар зүйл. Гарын үсэг

- (1) Тухайн этгээдийн гарын үсэг шаардлагатай хэмээн хуульд заасан бөгөөд уг шаардлага нь хэрэв зурвас өгөгдөлд хамаарах дараах нөхцөлүүдтэй тохирч байвал гарын үсэгт тооцно. Үүнд:
- (a) уг зурвас өгөгдөл дэх мэдээлэл нь тухайн этгээд мөн эсэхийг тодорхойлсон бөгөөд уг этгээд зөвшөөрч байгааг илтгэж байгаа аргыг хэрэглэсэн бол;
 - (b) зурвас өгөгдөл нь ямар ч нөхцөлд тухайлбал аливаа хэлэлцээртэй холбоотой нөхцөлийг агуулсан бөгөөд хамаараххарилцааны зорилгод нийцсэн тохиромжтой, найдвартайаргыгхэрэглэсэн бол;
- (2) Дээрх (1) хэсэгт заасан шаардлага нь гарын үсэг байхгүйн улмаас гарах үр дагаварын талаар хуульд энгийнээр заасан эс бөгөөс үүрэг болгон шаардсан тохиолдолд мөн хамаарна.
- (3) Тус зүйлд заасан зохицуулалт дараах харилцаанд хамаарахгүй: [...].

8 дугаар зүйл. Эх хувь

- (1) Тухайн мэдээлэл нь эх хувь гэсэн хэлбэрээр илэрхийлэгдэж, хадгалагдаж байх шаардлагатай хэмээн хуульд заасан бөгөөд уг шаардлага нь хэрэв зурвас өгөгдөлд хамаарах дараах нөхцөлүүдтэй тохирч байвал эх хувьд тооцно. Үүнд:



(a) зурвас өгөгдөл эсвэл өөр байдлаар эцсийн хэлбэр болгон анх удаа нэгтгэгдсэн⁹⁷ тэр цаг мөчид уг мэдээлэл нэгдмэл цогц нэг зүйл боллоо гэдгийг найдвартай батлах нотолгоо байгаа бол; эсвэл

(b) уг мэдээлэл нь хүлээн авч буй хүнд очихдоо жижиг хэсгүүд болон задрахгүйгээр харагдах боломжтой байгаа байдлаар мэдээллийг илэрхийлэгдэхээршаардсан бол

(2) Дээрх (1) хэсэгт заасан шаардлага нь мэдээлэлэх хувь гэсэн хэлбэрээр илэрхийлэгдэж, хадгалагдаагүйн улмаас гарах үр дагаварын талаар хуульд энгийнээр заасан эс бөгөөс үүрэг болгон шаардсан тохиолдолд мөн хамаарна.

(3) (1)хэсгийн (a)дэд хэсэгт заасан зорилгыг хангах үүднээс:

(a) мэдээлэл нэгдмэл цогц нэг зүйл болох шалгуур нь хадгалах болон нээж үзэхэд нэмэлт орохгүй, өөрчлөлт хийгдэхгүй, нэг хэвийн байдлаар харилцааг хангах, мэдээлэл нь бүрэн цогц, цаашид задрахгүй байдлаар хэлбэржсэн байгаа эсэхийг хэлнэ.

(b) найдвартай байх стандарт нь мэдээлэл нэгдмэл байх зорилгоос шалтгаалж мөн бусад холбогдох нөхцөл байдлаас шалтгаалан үнэлэгдэхийг шаардана.

(4) Тус зүйлд заасан зохицуулалт дараах харилцаанд хамаарахгүй: [...].

9 дүгээр зүйл. Өгөгдөл зурвас нотлох баримт, нотолгоо болох

(1) Аливаа эрх зүйн ажиллагаанд мэдээлэл нь өгөгдөл зурвасыг дараах тохиолдлуудад нотлох баримтын хэмжээнд авч үзэхээс татгалзахгүй байх эсвэл нотлох баримттай холбоотой аливаа дүрэм журам үйлчлэхгүй байх ёсгүй. Үүнд дараах үндэслэлүүд хамаарна:

(a) өгөгдөл зурвас гэсэн цор ганц үндэслэл;

(b)хэрэвнотолгоог эзэмшиж буй этгээдийн хувьд энэ нь хамгийн сайн нотлох баримт гэж тооцогдож байгаа боловч хувийн шаардлага хангаагүйхэлбэртэй байна гэсэн үндэслэл.

(2)Өгөгдөл зурвас байдлаар хэлбэржсэн мэдээлэл нь нотлох баримтын хэмжээнд үнэлэгдэнэ. Өгөгдөл зурвасыг нотлох баримтын хэмжээнд үнэлэхдээуг өгөгдөл зурвас нэгдмэл нэг цогц байдлаар хэлбэржиж,

⁹⁷there exists a reliable assurances to the integrityof the information from the time when it was first generated in its final form, as a data message or otherwise



хадгалагдаж, холбогдсон байдал найдвартай хангагдсан эсэхийг, мөн мэдээллийн нэгжүүдийн холбоос нь найдвартай эсэх, уг мэдээллийг үүсгэгч нь мэдээллийг хэрхэн тодорхойлсон болон бусад холбогдох хүчин зүйлсийг харгалзана.

10 дугаар зүйл. Өгөгдөл зурвасын хадгалалт

(1) Хуулийн дагуу зарим бичиг баримт, тэмдэглэл, бүртгэл, мэдээллийг хадгалах талаар шаардлага тавьсан бол дараах нөхцөлүүдийг хангасан тохиолдолд өгөгдөл зурвасын хадгалалт уг шаардлагыг хангасан гэж үзнэ.

Үүнд:

(a) түүнд агуулагдаж буй мэдээлэл нь нээлттэй байхын зэрэгцээ дараагийн бичиг баримтад ашиглагдаж болохуйц байх;

(b) өгөгдөл зурвас нь нэгдмэл цогц болсон, илгээгдсэн, хүлээн авсан байдлаар хадгалагдсан эсвэл нэгдмэл цогц болсон, илгээгдсэн, хүлээн авсан тухай мэдээллийг нэгд нэгэнгүй харуулж чадахуйц байдлаар хэлбэржсэн байх;

(c) уг мэдээлэл нь үүсгэгдсэн байдал өгөгдөл зурвасын зам болон түүнийг илгээсэн, хүлээн авсан хугацаа, газрыг тодорхойлж болохуйцаар хадгалагдсан байх зэрэг болно.

(2) Зурвасыг илгээх, хүлээн авах боломжтой байсан гэсэн цор ганц зорилгыг хангах үүднээс аливаа төрлийн мэдээлэлд хамааралтайгаар энэхүү зүйлийн (1) дэх хэсэгт заасны дагуу бичиг баримт, тэмдэглэл, бүртгэл, мэдээллийг хадгалах үүрэг нь бий болохгүй.

(3) Энэхүү зүйлийн (1) дэх хэсэгт заасан шаардлагыг хангахын тулд аливаа этдээд нь бусад этгээдийн үйлчилгээг ашиглаж болно. Ингэхдээ энэхүү зүйлийн (1) дэх хэсгийн (a), (b) болон (c) дэд хэсэгт заасан шаардлагуудыг хангасан үйлчилгээг ашигласан байх шаардлагатай.



БҮЛЭГ III. ЗУРВАС ӨГӨГДӨЛӨӨР ХАРИЛЦАХ

11 дүгээр зүйл. Гэрээ байгуулах, түүний хүчин төгөлдөр байдал

- (1) Гэрээг байгуулах явцад талууд өөрөөр тохиролцоогүй бол гэрэний санал, саналын акцептыг өгөгдөл зурвасаар илэрхийлж болно. Хэрэв өгөгдөл зурвасыг гэрээ байгуулахад ашиглах нөхцөлд өгөгдөл зурвас байсан гэсэн цор ганц шалтгаанаар гэрээг хүчингүйд тооцох, хүчин төгөлдөр бус гэж үзэх ёсгүй.
- (2) Тус зүйлд заасан зохицуулалт дараах харилцаанд хамаарахгүй: [...].

12 дугаар зүйл. Өгөгдөл зурвасыг талууд хүлээн зөвшөөрөх

- (1) Өгөгдөл зурвасыг үүсгэгч болон хаягийн дагуу хүлээн авагчийн хоорондох харилцаанд хүсэл зоригоо илэрхийлэх болон бусад холбогдох мэдэгдэл нь өгөгдөл зурвасаар илэрхийлэгдсэн гэсэн цор ганц шалтгаанаар хууль зүйн хүчин төгөлдөр байдлаа алдахгүй
- (2) Тус зүйлд заасан зохицуулалт дараах харилцаанд хамаарахгүй: [...].

13 дугаар зүйл. Өгөгдөл зурвасад хамаарах зүйлс

- (1) Өгөгдөл зурвас нь түүнийг үүсгэсэн этгээд өөрөө илгээсэн тэр зүйл байна.
- (2) Хэрэв дор дурдсан байдлаар эсвэл дор дурдсан этгээд илгээсэн бол үүсгэгч болон хаягийн дагуу хүлээн авагч этгээдийн хоорондох харилцаанд уг зүйлийг өгөгдөл зурвас гэж ойлгоно. Үүнд:
- (a) тухайн өгөгдөл зурвасыг үүсгэсэн этгээдийн өмнөөс үйлдэл хийх эрх олгогдсон этгээд илгээсэн; эсвэл
 - (b) өгөгдөл зурвас үүсгэгчийн өмнөөс автоматаар ажилладаг, эсвэл пограмчлагдсан мэдээллийн системээр илгээгдсэн зэрэг хамаарна.
- (3) Үүсгэгч болон хаягийн дагуу хүлээн авагчийн хоорондын харилцаанд мэдээлэл үүсгэгчийн бий болгосон өгөгдөл зурвас мөн эсэхийг шалгах эрх хаягийн дагуу хүлээн авагчид үүснэ. Энэхүү эрхээ хэрэгжүүлэхдээ дараах байдлыг харгалзана. Үүнд:
- (a) тухайн үүсгэгчийн бий болгосон өгөгдөл зурвас мөн эсэхийг тодорхойлохын тулд уг зорилгын үүднээс үүсгэгчтэй урьдчилан тохирсон ажиллагааг хаягийн дагуу хүлээн авагч хэрэгжүүлнэ;



(b) үүсгэгчийн аливаа төлөөлөгчтэй харилцаатай эсвэл үүсгэгчтэй өөртэй нь харилцаатай этгээдийн хийсэн үйлдэлийн үр дүнд хаягийн дагуу хүлээн авагчийн хүлээн авсан өгөгдөл зурвас нь үүсгэгчийн бий болгосон өгөгдөл зурвас мөн эсэхийг тодорхойлох зорилгоор үүсгэгчийн хэрэглэж буй аргыг ашиглах эрхийг уг этгээдэд олгоно.

(4) Энэхүү зүйлийн (3) дахь хэсэгт доорх тохиолдолд хамаарахгүй:

(a) үүсгэгчийн бий болгосон өгөгдөл зурвас биш талаар үүсгэгчээс мэдэгдэл хүлээн авсан цаг хугацаанаас хойш хаягийн дагуу хүлээн авагч хариу үйлдэл хийх хангалттай хугацаа байгаа нөхцөл;

(b) энэ зүйлийн (3)(b) хэсэгт заасан тохиолдлын хүрээнд хаягийн дагуу хүлээн авагч нь уг өгөгдөл зурвас үүсгэгчийн бий болгосон мэдээлэл биш талаар мэдэж байсан эсвэл мэдэх ёстой байсан тэр цаг хугацанд урьдчилан тохироцсоны дагуу арга хэмжээ авч эрхээ хэрэгжүүлсэн нөхцөл тус тус орно.

(5) Үүсгэгч болон хаягийн дагуу хүлээн авагчийн хоорондын харилцаанд өгөгдөл зурвас нь үүсгэгчийн бий болгосон мэдээлэл мөн эсэх эсвэл уг үүсгэгчээр бий болгосон мэдээлэл гэж тооцогдохын тулд үүсгэгчийн илгээхийг зорьсон өгөгдөл зурвас нь түүний хүлээж авсан өгөгдөл зурвастай харьцуулан шалгаж үзэх эрхтэй. Хаягийн дагуу хүлээн авагч нь өгөгдөл зурвасыг хүлээн авахад дамжуулах процессын гаргасан аливаа нэг алдаатай үйлдэл байгаа талаар мэдсэн, мэдэх бололцоотой байсан бөгөөд түүний зүгээс урьдчилан тохиролцсоны дагуу арга хэмжээ авсан тохиолдолд уг эрхийг хэрэгжүүлэх ёсгүй.

(6) Хаягийн дагуу хүлээн авагч нь салангид байдлаар хүлээн авсан өгөгдөл зурвас бүрийг хариуцана. Өөр өгөгдөл зурваст уг мэдээлэл хуулбарлагдсан биш байгааг хаягийн дагуу хүлээн авагч нь мэдэх ёстой эсвэл мэдэх боломжтой байснаас бусад тохиолдолд өгөгдөл зурвас дахь мэдээлэл хуулбарлагдсан бол хоорондоо хэлэлцэн тохирсон арга хэмжээ авч, оновчтой байдлаар хэрэгжүүлнэ.

14 дүгээр зүйл. Хүлээж авсныг мэдэгдэх

(1) Энэ зүйлийн (2) болон (4) дэх хэсэгт заасан зохицуулалт өгөгдөл зурвасыг илгээхийг өмнө үүсгэгчийн шаардсанаар эсвэл үүсгэгч хаягийн дагуу хүлээн



авагчтай өгөгдөл зурвасыг хүлээн авсанаа мэдэгдэх талаар тохиролцсон тэр нөхцөлд хамаарна.

(2) Үүсгэгч нь хаягийн дагуу хүлээн авагчтай өгөгдөл зурвасыг хүлээн авсан эсэхийг ямар хэлбэрээр мэдэгдэх, ямар арга хэрэгсэл ашиглан мэдэгдэх талаар тохиролцоогүй бол дараах нөхцөлүүдийг өгөгдөл хүлээн авсан мэдэгдэл гэж тооцно. Үүнд:

(a) автомат болон бусад харилцааны хэлбэрийг хаягийн дагуу хүлээн авагчийн ашиглаж буй нөхцөлд,

(b) хаягийн дагуу хүлээн авагч нь өгөгдөл зурвасыг хүлээн авсаныг үүсгэгчид тодорхойлон зааж өгч буй хаягийн дагуу хүлээн авагчийн аливаа хангалттай ойлгомжтой үйлдэл хийгдсэн нөхцөл тус тус хамаарна.

(3) Хүлээж авсан тухай мэдэгдэлийг явуулах нөхцөлийг үүсгэгчийн зүгээс тавьсан бол хаягийн дагуу хүлээн авагч өгөгдөл зурвасыг хүлээн авлаа хэмээн мэдэгдэх хүртэл уг өгөгдөл зурвасыг илгээгдээгүй гэж тооцно.

(4) Хүлээж авсан тухай мэдэгдэлийг явуулах нөхцөлийг үүсгэгчийн зүгээс тавиагүй боловч урьдчилан тохиролцсоны дагуу, эсвэл тогтоосон хугацаанд, эсвэл хугацаа тогтоогоогүй, урьдчилан тохиролцоогүй тохиолдолд хангалттай хугацааны дотор үүсгэгчид хүлээн авсан тухай мэдэгдэл ирээгүй бол дараах арга хэмжээг үүсгэгч авч болно. Үүнд:

(a) хаягийн дагуу хүлээн авагчид өгөгдөл зурвас хүлээн авсан талаар аливаа мэдэгдэл ирээгүй тухай мэдэгдэж, хүлээн авсан талаар заавал мэдэгдэл өгөх хангалттай хугацааг тодорхойлж өгнө.

(b) энэ хэсгийн (a) дэд хэсэгт заасны дагуу тогтоосон хугацаанд өгөгдөл зурвасыг хүлээн авсан тухай мэдэгдэл ирээгүй бол өгөгдөл зурвасыг илгээгүй гэж үзэн үүсгэгч нь өөрт олгогдсон бусад эрхээ хаягийн дагуу хүлээн авагчид мэдэгдсэний үндсэн дээр хэрэгжүүлнэ.

(5) Үүсгэгчид хаягийн дагуу хүлээн авагчаас хүлээн авсан тухай мэдэгдэл ирүүлсэн нөхцөлд уг өгөгдөл зурвасыг хаягийн дагуу хүлээн авагч хүлээн авсан гэж тооцно. Ийнхүү тооцох нь өгөгдөл зурвасыг зурвас хүлээн авсан мэдэгдэлтэй адилтгана гэсэн агуулгыг илэрхийлэхгүй.

(6) Тохиролцсоны дагуу эсвэл тохиромжгүй стандартуудыг өмнө нь тодорхойлсоны дагуу тогтоосон техникийн шаардлагуудыг холбогдох өгөгдөл



зурвас нь хангаж байгаа тухай мэдэгдэлийг хүлээн авсан нөхцөлд уг тогтоосон шаардлагуудыг хангасан байна гэж үзнэ.

(7) Тус хуулийн энэ зүйл нь өгөгдөл зурвасыг илгээсэн, хүлээн авсантай холбоотойгоос бусад харилцаа буюу тухайн өгөгдөл зурвас, түүнийг хүлээн авсан мэдэгдэлтэй холбоотойгоор үүсч буй хууль зүйн үр дагаврыг хамааран зохицуулахгүй болно.

15 дугаар зүйл. Өгөгдөл зурвасыг илгээх, хүлээн авах цаг, газар

(1) Үүсгэгч болон хаягийн дагуу хүлээн авагчийн хооронд өөр тохиролцоо хийгдээгүй бол мэдээлэл үүсгэгч эсвэл мэдээлэл үүсгэгчийн өмнөөс өгөгдөл зурвасыг илгээж буй этгээдийн хяналтаасгарч мэдээллийн системд нэвтэрсэн тохиолдолд уг өгөгдөл зурвасыг илгээгдсэн гэж үзнэ.

(2) Үүсгэгч болон хаягийн дагуу хүлээн авагчийн хооронд өөр тохиролцоо хийгдээгүй бол өгөгдөл зурвасыг хүлээн авсан цагийг дараах байдлаар тодорхойлно. Үүнд:

(a) хэрэв хаягийн дагуу хүлээн авагч нь өгөгдөл зурвасыг хүлээн авах зорилгоор мэдээллийн системийг тодорхойлсон бол дараах тохиолдолд хүлээн авсан гэж үзнэ. Үүнд:

(i) өгөгдөл зурвас тодорхойлсон мэдээллийн системд нэвтэрч орсон цаг; эсвэл

(ii) хэрэв хаягийн дагуу хүлээн авагч этгээдийн тодорхойлоогүй мэдээллийн систем рүү өгөгдөл зурвас илгээгдсэн бол хаягийн дагуу хүлээн авагч нь өгөгдөл зурвасыг хайж олон сэргээн үзэж буй тэр цаг;

(b) хэрэв хаягийн дагуу хүлээн авагч нь мэдээллийн системийг тодорхойлоогүй бол хаягийн дагуу хүлээн авагчийн мэдээллийн системд өгөгдөл зурвас нэвтрэн орсон байдлыг хүлээн авсан гэж тооцно.

(3) Энэхүү зүйлийн (4) хэсгийн дагуу өгөгдөл зурвасыг хүлээн авсан газар нь мэдээллийн системээс өөр газар байрлаж буй газар эсэхийг үл харгалзан тус зүйлийн (2) дахь хэсгийн зохицуулалт үйлчилнэ.

(4) Үүсгэгч болон хаягийн дагуу хүлээн авагчийн хооронд өөр тохиролцоо хийгдээгүй бол мэдээлэл үүсгэгчийн ажил хэргээ явуулдаг газраас өгөгдөл зурвасыг илгээсэн гэж үзэх ба хаягийн дагуу хүлээн авагчийн ажил хэргээ



явуулдаг газарт уг өгөгдөл зурвасыг хүлээн авсан гэж тооцно. Энэхүү зүйлийг тайлбарлах үүднээс дараах тохиолдолуудыг авч үзнэ. Үүнд:

(a) хэрэвмэдээлэл үүсгэгч эсвэл хаягийн дагуу хүлээн авагч нь нэгээс дээш тооны газарт ажил хэргээ хөтлөн явуулдаг бол тухайн хэлцэлд хамгийн ихээр хамаарах харилцаагаа эрхлэн явуулдаг газрыг ажил хэргээ хөтлөн явуулдаг газар (place of business) гэж тооцно, хэрэв онцгойлсон хэлцэл хийгдээгүй тохиолдолд ажил хэргээ голлон явуулдаг газрыг ажил хэргээ хөтлөн явуулдаг газар (place of business) гэж тооцно.

(b) хэрэвмэдээлэл үүсгэгч эсвэл хаягийн дагуу хүлээн авагч нь ажил хэргээ хөтлөн явуулдаг тодорхой газаргүй бол түүний байнга оршин суудаг газраар хүлээн авсан газрыг тодорхойлно.

(5) Тус зүйлд заасан зохицуулалт дараах харилцаанд хамаарахгүй: [...].

Хоёрдугаар хэсэг. Тодорхой салбар дахь цахим худалдаа

БҮЛЭГ I. БАРАА ТЭЭВЭРЛЭХ

16 дугаар зүйл. Бараа тээвэрлэх тухай гэрээнд холбогдох үйлдэл

Энэхүү Хуулийн нэгдүгээр хэсгийн заалтуудыг дахин давтахгүйн үүднээс бараа тээвэрлэх гэрээнээс үүдэлтэй, түүнд хамаарах аливаа үйлдэлд тус бүлгийн зохицуулалт хамаарна. Гэхдээ гагцхүү дээр нэрлэсэн гэрээгээр хязгаарлагдахгүй бөгөөд дараах харилцааг мөн хамаарна. Үүнд:

- (a) (i) барааны жин, хэмжээ, тоо ширхэг, тэмдэгийг баталгаажуулах;
 - (ii) бараа үнэ цэнэ, гарал үүслийн талаар мэдүүлэн тэмдэглэх;
 - (iii) бараа худалдаж авсан тасалбараа өгөх;
 - (iv) бараа ачигдсан эсэхийг шалгаж баталгаажуулах;
- (b) (i) гэрээний нөхцөл, заалтуудын талаар тухайн этгээдэд мэдэгдэх;
 - (ii) тээвэрлэгчид заавар өгөх;
- (c) (i) барааг тээвэрлэхийг шаардах;
 - (ii) барааг тээвэрлэх зөвшөөрөл олгох;
 - (iii) бараанд гэмтэл, хохирол учирсан, бараа алдагдсан талаар мэдэгдэл хийх;
- (d) гэрээний үүргээ гүйцэтгэхтэй холбоотой аливаа мэдэгдэл, бичиг баримт өгөх;



(е) тухайн нэрлэн заасан этгээдэд эсвэл илгээхийг шаардах эрх олгогдсон этгээдэд бараа илгээх талаар үүрэг өгөх;

(f) бараатай холбоотойгоор хэлэлцээ хийх эрх олж авах, эрхээ шилжүүлэх, эрхээсээ татгалзах, эрхээ буцаах;

(g) гэрээний үндсэн дээр эрх, үүрэг шилжүүлэх эсвэл олж авах.

17 дугаар зүйл. Бичиг баримтыг шилжүүлэх

(1) Энэхүү зүйлийн (3) дахь хэсэгт заасанчлан тус хуулийн 16 дугаар зүйлд дурдагдсан аливаа үйлдэлийг бичмэл байдлаар эсвэл цаасан дээр буулгасан бичиг баримтын дагуу хийхийг хуулиар шаардаж байгаа бол нэг эсвэл түүнээс дээш хэд хэдэн өгөгдөл зурвасыг ашиглан уг үйлдэлийг хийсэн нөхцөлд дээрх шаардлагыг хангасан гэж үзнэ.

(2) Энэхүү зүйлийн (1)дэх хэсэгт дурдсан шаардлага нь үүргийн аль нэг хэлбэрээр илэрсэн байхыг эсвэл бичмэл байдлаар болон цаасан дээр буулгасан бичиг баримтын дагуу хийгдэх үйлдлийг хийгээгүйн улмаас учирч болох үр дагаврыг хуульд заасан нөхцөлд мөн хамаарна.

(3) Хуулиар өөр этгээд байхыг шаардаагүй бөгөөд аливаа этгээдэд эрх олгож, үүрэг үүсгэсэн явдлыг хүчин төгөлдөр болгох зорилгоор нэг эсвэл түүнээс дээш тооны өгөгдөл зурвас ашиглан уг эрх үүргийг шилжүүлж болно. Уг эрх үүргийг тухайн этгээдэд шилжүүлэхийг цаасан дээр буулгасан бичмэл баримт ашиглан хийхийг шаардсан тохиолдолд эрх үүргийг шилжүүлэхэд ашиглаж буй өгөгдөл зурвас нь тухайн асуудлыг онцгойлон агуулсан бөгөөд найдвартай арга хэрэгслэлээр тухайн этгээдэд хүргэгдсэн бол дээрх шаардлагыг өгөгдөл зурвас хангасан гэж үзнэ.

(4) Энэхүү зүйлийн (3) дахь хэсэгт заасан зорилгын үүднээс найдвартай байх стандарт нь эрх, үүрэг шилжих болсон зорилгыг харгалзах, мөн аливаа холбогдох хэлэлцээр зэргийг хамарсан бүх нөхцөл байдалын шалтгааныг авч үзэж хангагдана.

(5) Нэг болон түүнээс их хэд хэдэн өгөгдөл зурвасыг энэ хуулийн 16 дугаар зүйлийн (f) болон (g) гэсэн дэд хэсгүүдэд заасан аливаа үйлдлийг хүчин төгөлдөр болгоход хэрэглэхээр заасан боловч эдгээр үйлдлийг хүчин төгөлдөр болгоход ашиглагдах ямар нэг бичмэл цаасан дээр буулгасан баримт байхгүй нөхцөлд угашиглагдаж буй өгөгдөл зурвасыг цуцлах, өөр цаасан бичмэл баримтаар



солих хүртэл тухайн үйлдэл хүчин төгөлдөр хэвээр байна. Энэ тохиолдолд олгогдсон цаасан дээр буулгасан бичмэл баримт нь өгөгдөл зурвасыг цуцлах, дахин ашиглахгүй тухай мэдэгдэлийг агуулсан байх шаардлагатай. Өгөгдөл зурвасыгцаасан бичмэл баримтаар солих нь талуудын хүлээсэн үүрэг, эдэлж буй эрхэд нөлөө үзүүлэхгүй.

(6) Хэрэв бараа тээвэрлэх гэрээнд эрх зүйт ёсыг (rule of law) зайлшгүй хангахыг цаасан дээр буулгасан бичмэл баримт⁹⁸ болох нотолгооны үндсэн дээр шаардаж байвал уг цаасан дээр буулгасан бичмэл баримтын оронд өгөгдөл зурвасаар нотлогдох факт байхад уг эрх зүйт ёсыг хангах шаардлаганэг эсвэл хэд хэдэн өгөгдөл зурвасаар тодорхойлогдсон тухайн бараа тээвэрлэх гэрээний хувьд мөн хамаарна(хамаарахгүй байх ёсгүй).

(7) Тус зүйлд заасан зохицуулалт дараах харилцаанд хамаарахгүй: [...].

Хавсралт 2

ЦАХИМ ХУДАЛДААНД ХОЛБОГДОХ МОНГОЛ УЛСЫН НЭГДЭН ОРСОН ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧИГ⁹⁹

1. Далайд гарцгүй улсын дамжин өнгөрөх худалдааны тухай Нью-Йоркийн конвенц /Convention on Transit Trade of Land-locked States/, 1965
2. Олон улсын бараа худалдахад хөөн хэлэлцэх хугацааны тухай конвенц /Convention on the Limitation Period in the International Sale of Goods/, 1974
3. Ази-Номхон далайн орнуудад дээд боловсролын сургалт, эрдмийн зэрэг дипломыг хүлээн зөвшөөрөх тухай бүсийн конвенц /Regional Convention on the Recognition of Studies, Diplomas and Degrees in Higher Education in Asia and Pacific/, 1983
4. Техникийн болон мэргэжлийн боловсролын тухай конвенц /Convention on Technical and Vocational Education/, 1989
5. Бараа худалдах-худалдан авах олон улсын гэрээний тухай Венийн конвенц /United Nations Convention On Contracts For The International Sale Of Goods/, 1980

⁹⁸ цаасан дээр буулгасан бичмэл баримт – paper document

⁹⁹ <http://www.mfat.gov.mn/images/dwfile/olontaltgereee.pdf> -аас хэсэгчлэн авав



6. Хөрөнгө оруулалтыг баталгаажуулах олон талт агентлагийг үүсгэн байгуулах конвенц /Convention establishing the Multilateral Investment Guarantee Agency/, 1985
7. Дэлхийн худалдааны байгууллага байгуулах тухай Марракешийн хэлэлцээр /Marrakesh Agreement Establishing the World Trade Organization/, 1994
8. Эрчим хүчний хартийн гэрээ болон Эрчим хүчний үр ашиг, хүрээлэн буй орчны холбогдох асуудлын тухай протокол, Эрчим хүчний хартийн Гэрээний худалдаанд заалтуудын нэмэлт өөрчлөлт /Energy Charter Treaty, Energy Charter Protocol on Energy Efficiency and Related Environmental Aspects/, 1994
9. Олон улсын худалдааны мэдээлэл, хамтын ажиллагааны агентлагийг Засгийн газар хоорондын байгууллага болгон байгуулах тухай хэлэлцээр /Agreement Establishing the Agency for International Trade Information and Co-Operation (AITIC) as an Inter-Governmental Organisation/, 2002
10. Дэлхийн оюуны өмчийн байгууллага байгуулах тухай конвенц /Convention Establishing the World Intellectual Property Organization/, 1967
11. Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенц /Paris Convention for the Protection of Industrial Property/, 1883
12. Барааны тэмдгийн олон улсын бүртгэлийн тухай Мадридын хэлэлцээр /Madrid Agreement Concerning the International Registration of Marks/, 1891
13. Радио нэвтрүүлгийг энх тайвны зорилгод ашиглах тухай Женевийн конвенц /International Convention concerning the Use of Broadcasting in the Cause of Peace/, 1936
14. Патентын хамтын ажиллагааны гэрээ /Patent Cooperation Treaty/, 1970
15. Утга зохиол, урлагийн бүтээлийг хамгаалах тухай Бернийн конвенц /Berne Convention for the Protection of Literary and Artistic Works/, 1886
16. Худалдаанд хамаарах оюуны өмчийн эрхийн тухай хэлэлцээр /Agreement on Trade-Related Aspects of Intellectual Property Rights/, 1994
17. Бүтээгдэхүүний загварын олон улсын хадгалалтын тухай Гаагийн хэлэлцээр /The Hague Agreement concerning the International Deposit of Industrial Designs/, 1925
18. Барааны тэмдгийн олон улсын бүртгэлийн тухай Мадридын хэлэлцээр, түүний протокол /Madrid Protocol concerning the International Registration of Marks/, 1989



19. Бүтээгдэхүүний загварын олон улсын ангилал тогтоох тухай Локарнийн хэлэлцээр /Locarno Agreement Establishing an International Classification for Industrial Designs/, 1968
20. Патентын олон улсын ангилалын тухай Страсбургийн хэлэлцээр /Strasbourg Agreement concerning the International Patent Classification/, 1971
21. Барааны тэмдгийг бүртгэх зорилгоор бараа, үйлчилгээний олон улсын ангилал тогтоох тухай Ницийн хэлэлцээр /Nice Agreement concerning the International Classification of Goods and Services for the Purposes of the Registration of Mark/, 1957
22. Олимпын бэлэг тэмдэгийг хамгаалах тухай Найробын гэрээ /Nairobi Treaty on the Protection of the Olympic Symbol/, 1996
23. Зохиогчийн эрхийн тухай Дэлхийн оюуны өмчийн байгууллагын гэрээ /WIPO Copyright Treaty/, 1996
24. Тоглолт болон дуу авианы бичлэгийн тухай Дэлхийн оюуны өмчийн байгууллагын гэрээ /Treaty on Protection of Performers, Producers of Phonograms and Broadcasting Organizations/, 1996
25. Соёлын биет бус өвийг хамгаалах тухай ЮНЕСКО-ийн конвенц /Convention for the Safeguarding of the Intangible Cultural Heritage/, 2003
26. Бүтээгдэхүүний загварын олон улсын бүртгэлийн тухай Гаагын хэлэлцээр /The Hague Agreement Concerning The International Registration of Industrial Designs/, 1960
27. Бүтээгдэхүүний загварын олон улсын бүртгэлийн тухай Гаагын хэлэлцээрийн 1999 оны Женевийн акт /Geneva Act of the Hague Agreement Concerning the International Registration of Industrial Designs/
28. Соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах болон хөхиүлэн дэмжих тухай ЮНЕСКО-ийн конвенц /Convention on the Protection and Promotion of the Diversity of Cultural Expressions/, 2005
29. Оюуны өмчийн эрхийн худалдаатай холбогдсон асуудлын тухай хэлэлцээрт нэмэлт өөрчлөлт оруулах тухай /Amendment of the TRIPS Agreement/, 2005
30. Эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны харилцаанаас үүссэн иргэний эрх зүйн маргааныг арбитраар шийдвэрлүүлэх тухай конвенц /Convention on the Settlement By Arbitration of Civil Law Disputes Resulting from Relations of Economic and Scientific-Technical Cooperation/, 1972



31. Гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх тухай конвенц /Convention on the Recognition and Enforcement of Foreign Arbitral Awards/, 1958
32. Улс болон гадаад улсын иргэний хооронд хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэх тухай Вашингтоны конвенц /Convention on the Settlement of Investment Disputes Between States and Nationals of Other States, Washington/, 1965
33. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай конвенц /Convention on Civil Procedure/, 1954



АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

I. Ном, гарын авлага:

- Монгол хэл дээр: Галбаатар Л (2010) *"Цахим эрх зүй"*, УБ, "Мөнхийн үсэг" хэвлэл. 141 хуудас
- Орос хэл дээр: Рассолов. И. М. (2011), *Информационное право*, Учеб, С.303.

II. Өгүүлэл, нийтлэл:

- Монгол хэл дээр
- Хуо Шу И (2012 №2-37) *Хил дамнаж хэрэглэгчтэй байгуулсан цахим хэлбэр бүхий гэрээний маргаанд шүүхийн харьяаллыг нэгдмэл байдлаар тогтоох боломж* // (орч Мөнхтуяа Н), Хууль дээдлэх ёс сэтгүүл, 35-40 дэх тал
 - Г.Халиунаа (2012 №2-37) *Цахим худалдааны загвар хууль батлах болсон шалтгаан, нөхцөл* //, Хууль дээдлэх ёс сэтгүүл, 91-96 дэх тал

III. Олон улсын эрх зүйн баримт бичиг:

1. Brussels Convention on jurisdiction and Recognition of Judgments in Civil and Commercial Matters, J.O. L 299/32 (1972), amended by O.J. L 304/77 (1978), amended by O.J. L 388/1 (1982), amended by O.J. L 285/1 (1989)
2. Article 15 (1) defines consumer contract as a "contract concluded by a person, the consumer, for a purpose which can be regarded as being outside his trade or profession"
3. НҮБХХБ-ын Нарийн бичгийн дарга нарын газраас гаргасан "Цахим худалдаа: Хууль эрх зүйн асуудлууд" сэдэвт баримт бичиг
4. НҮБХХБ-ын (1999.05.04) *"Цахим худалдааны эрх зүйн асуудлууд"* сэдэвт TD/B/COM.3/EM.8/2 дугаартай тайлан
5. (1998) *"Цахим худалдаа: Хууль эрх зүйн асуудлууд"*, UNCTAD/SDTE/BFB/1,87 дугаар параграф дахь нийтлэлийг
6. "Худалдаа явуулахад шаардлагатай элементүүд" нийтлэл, ECE, III дугаар Боть, "Худалдааны бичиг баримтуудыг гарын үсгээс бусад хэлбэрээр баталгаажуулах нь" сэдэвт нийтлэл, ECE/TRADE/200,
7. UNCITRAL материалууд A/CN.9/265, 49-58 дугаар параграф, A/CN.9/933, 50-59 дугаар параграф, A/CN.9/390, 86-89 дугаар параграф, A/CN.9/W6.IV/WP.53, 61-66 дугаар параграф
8. ДООБ-ын 1999 оны 4 дүгээр сарын 30-ны 439 дүгээр товхимол
9. 1999 оны 8 дугаар сарын 26 ОНДИК "Домэйн нэрийн маргаан шийдвэрлэх нэгдсэн удирдамж"
10. 1999 оны 10 дугаар сарын 24-нд "Домэйн нэрийн маргаан шийдвэрлэх нэгдсэн удирдамжийн дүрэм"
11. Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (1998) *"Цахим зах зээлд хэрэглэгчийн эрх ашиг хамгаалах нь"*, ЭЗХАХБ-ын товхимол, DSTI/CP(98) 13Rev. 2.
12. ЭЗХАХБ-ын Цахим худалдааны асуудлаарх зөвлөгөөний тайланг үзнэ үү. х. 14. 1999 оны 10 дугаар сарын 12-13, Парис хот.
13. ЭЗХАХБ-ын Сайд нарын бага хуралд танилцуулсан "Цахим худалдаа: Татварын



тогтолц Түтил Л “Хэрэглэгчдэд зориулсан цахим худалдаа: Дэлхийн зах зээлийг өргөжүүлэх нь – цаашдын замнал”, ЭЗХАХБ-ын тайлан №33.

14. Иргэний болон худалдааны хэрэгт хамаарах харъяа нутгийн эрх зүй, шүүхийн шийдвэр биелүүлэх тухай 1968 оны 9 дүгээр сарын 27-ны Брюсселийн конвенц
15. 1988 оны 9 дүгээр сарын 16-ны Луганогийн конвенц
16. Цахим худалдааны талаар чадавхийг бэхжүүлэх Шинжээчдийн Уулзалтын тайлан: Хууль эрх зүйн болон зохицуулалтын хэм хэмжээнүүд, TD/B/COM.3/28, НҮБХХХ-ны 8 дугаар сарын 11-ны өдрийн тайлан “Цахим худалдааны эрх зүйн хэм хэмжээ”, TD/B/COM.3/EM.8/2. 1999 оны 5 дугаар сарын 4
17. Цахим худалдааны талаар чадавхийг бэхжүүлэх Шинжээчдийн Уулзалтын тайлан: Хууль эрх зүйн болон зохицуулалтын Хэмжүүрүүд, TD/B/COM.3/28, 1999 оны 8 сарын 11
18. Шинжээчдийн Уулзалтын Тайлан, 32-35 параграф
19. UNCTAD (2003) E-Commerce and Development Report

IV. Хууль тогтоомжууд:

Монгол хэл дээр:

- “Төрийн мэдээлэл” сэтгүүл. 2002 он. №7.
- “Төрийн мэдээлэл” сэтгүүл. 2012 он. №1.
- “Төрийн мэдээлэл” 2002 он. №7.
- “Төрийн мэдээлэл” 2001 он. №3
- Цахим гарын үсгийн тухай Монгол Улсын хууль
- Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 78 дугаар тогтоол. “Монгол Улсад бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бий болгох үндэсний хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх тэргүүлэх ач холбогдол бүхий төсөл, арга хэмжээ”
- Электрон монгол үндэсний хөтөлбөр. Уб., 2004 он

Англи хэл дээр:

Brussels Convention on jurisdiction and Recognition of Judgments in Civil and Commercial Matters, J.O. L 299/32 (1972), amended by O.J. L 304/77 (1978), amended by O.J. L 388/1 (1982), amended by O.J. L 285/1 (1989)

Орос хэл дээр:

Федеральный закон Российской Федерации “Об электронной торговле”

V. Интернет эх сурвалж:

1. Fred Calves “Virtual Justice as Reality making the Resolution of e-commerce disputes more convenient legitimate, efficient, and secure”, p. 68
2. Edward C. Anderson & Timothy S. Cole (2002), 6J. Small Emerging Bus. L. 35 “The UDRP – A model for dispute resolution in e-commerce”, The Journal of small and Emerging Business Law //, LexisNexis p.2-11.
<https://litigationessentials.lexisnexis.com/webcd/app?action=DocumentDisplay&crawlid=1&doctype=cite&docid=6+J.+Small+%26+Emerging+Bus.+L.+235&srctype=smi&srcid=3B15&key=aacf6f2083717cb030c402cb660cbec4>
3. Arthur T. von Mehren (2007), “Convergence and Compromise in Private International Law: The Role of International instruments”, Adjudicatory authority in private international law, Martinus Nijhoff Publishers in Leiden, Boston. p.354-378.
http://openlibrary.org/books/OL18406407M/Adjudicatory_authority_in_private_international_law (сүүлд орсон 2012.06.08)
4. Pavan Duggal (2004) “Harmonization of e-commerce laws and regulatory systems in



- South Asia”, Regional Expert Conference on Harmonized Development of Legal and Regulatory Systems for E-commerce, 7-9 July 2004 //Bangkok, Thailand.p.23-36.
http://www.unescap.org/tid/projects/ecom04_s3dug.pdf (сүүлд 2012 оны 6 сарын 07 өдөр)
5. Benjamin C.Elacqua (2004) , High tech L.95(2004) Vol. III No.1 “The Hague Runs into B2B: Why Restructuring the Hague Convention of Foreign judgments in Civil and Commercial Matters to Deal with B2B Contracts is Long Overdue”, The Journal of high technology law //,p. 93-113. <http://www.jhtl.org/docs/pdf/Elacqua-Note-PDF.pdf> (сүүлд 2012 оны 6 сарын 07 өдөр) p.
 6. Mary Shannon Martin (2002) , 20B.U.Int’L.J.125, “Keep it online: The Hague Convention and the need for online alternative dispute resolution in International Business to consumer e-commerce”, Boston University International Law Journal //, LexisNexis.p.2-26.
<https://litigationessentials.lexisnexis.com/webcd/app?action=DocumentDisplay&crawlid=1&srctype=smi&srcid=3B15&doctype=cite&docid=20+B.U.+Int'l+L.J.+125&key=c342c7e48554692bb591696703f3979a> (сүүлд 2012 оны 6 сарын 07 өдөр)
 7. Toshiyuki KONO (2010) , Vol. 15, No. 30, “The Reform of International Civil Procedure Law in Japan” ,26 Journal of Japanese Law //,
http://papers.ssrn.com/sol3/papers.cfm?abstract_id=1874555 (сүүлд орсон огноо 2012 оны 6 сарын 07 өдөр)
 8. Нямхүү Ц “Домайн нэрний зүй бус ашиглалт, шийдвэрлэх арга зам”
 9. Paul Przemyslaw Polanski (2006), 19th Bled eConference eValues, “Convention on E-Contracting: The Rise of International law of Electronic Commerce” //, Bled, Slovenia, June 5-7.p.1-10
 10. UNCITRAL Model Law on Electronic Commerce, <http://www.uncitral.org>
 11. <http://ecommerce.wipo.int/activities>
 12. <http://ecommerce.wipo.int>
 13. <http://ecommerce.wipo.int/domains/process>
 14. <http://arbiter.wipo.int>
 15. <http://ecommerce.wipo.int/agenda/index.html>
 16. <http://cavecom-e.org.ve>
 17. <http://www.prompex.gob.pe>
 18. <http://www.prompex.gob.pe/ipce.htm>
 19. <http://www.tradenetsl.lk>
 20. <http://www.ecomm-debate.co.za>
 21. <http://www.pit.co.za>
 22. [www.e-procurement.mn-](http://www.e-procurement.mn)
 23. Raising confidence in E-commerce: the legal framework, UNITED NATIONS COMMISSION ON INTERNATIONAL TRADE LAW(UNCITRAL), www.uncitral.com – сүүлд нэвтэрсэн огноо – 2012.02.10
